



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ази, Европын дээд түвшиний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүнд хийсэн эрсдэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны нэгдүгээр улиралд Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Ш.Занданшатар/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Гадаад харилцааны сайд /Д.Цогтбаатар/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал /Б.Батбаяр/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар илэрсэн зөрчилтэй зарим асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Ажлын хэсэг

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Ажлын хэсгийн ахлагч

Чанарын баталгаажуулалтын албаны
Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 329874

Ажлын хэсгийн гишүүд:

Ахлах аудитор	Л.Хонгорзул
Ахлах аудитор	Я.Наранцэцэг

Аудитор	Ц.Гэрэл
Аудитор	Б.Ариунжаргал
Аудитор	Ш.Гүрпүрэв

2018 оны 5 дугаар сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал дээрх дугаарын
утасаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр, Бага
тойруу-6, Улаанбаатар-46 Монгол
Улс

Товчилсон үгийн жагсаалт2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,
стандартын мэдэгдэл4

Бүлэг 1. “АСЕМ”-ын үйл ажиллагаа, түүний үр дүн, ач
холбогдлыг дүгнээгүй байна.....6
Ерөнхий мэдээлэл

- 1.1 “АСЕМ”-ын бэлтгэл ажил болон зохион байгуулах, явуулахтай
холбоотойгоор хууль зөрчсөн байна.....7
- 1.2 “АСЕМ”-ыг зохион байгуулсан нэгжүүд түүнд оролцсон иргэн,
хуулийн этгээдийн үүрэг оролцоог тодорхой заагласан болон
нэгтгэн гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан байхгүй
байгаа бөгөөд энэ талаар эрх зүйн баримт бичигт тодорхой
заагаагүй байна.....10
- 1.3 “АСЕМ”-ын үйл ажиллагааны зардлын нэгдсэн төсөв
гаргаагүйгээс гүйцэтгэлийн тайлагнал байхгүй, түүнд тавих
дотоод хяналт орхигдсон байна.....11

Бүлэг 2. “АСЕМ”-д зарцуулсан төсвийн хөрөнгийн
зарцуулалт, түүний үр дүн12
Үндсэн мэдээлэл

- 2.1 “АСЕМ”-ыг зохион байгуулах зориулалтаар батлагдсан төсвийн
хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг орхигдуулснаас
хөрөнгийг хяналтгүй зарцуулж, хууль, дүрэм журмыг мөрдөж
ажиллаагүй байна.....12
- 2.2 Нийслэлийн төсвөөс хэрэгжсэн “АСЕМ”-ын төсөл арга хэмжээг
эрх шилжүүлэн хууль зөрчин шууд гэрээгээр гүйцэтгэсэн ба
хөрөнгийн ихэнхийг өмчид бүртгээгүй байна.....33
- 2.3 “АСЕМ”-ын бэлтгэл ажил, үйл ажиллагаанд оролцсон иргэн,
хуулийн этгээдүүд ажлын гүйцэтгэлээ тайлагнаагүй, түүнд
төрөөс тавих хяналтгүй байжээ.....40

Бүлэг 3. “АСЕМ”-д зориулан зарцуулсан банкны зээлийн
зарцуулалт, түүний үр дүн.....51

- 3.1 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулан Хөгжлийн банкны эх
үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан зочид буудлуудад
олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, гүйцэтгэлд ХБ, СЯ-
аас хяналт тавьж тайлагнаагүй байна.....51
- 3.2 БНСУ-ын Экспорт-импортын банкны зээлээр авсан 43
автобусыг “АСЕМ”-ын үйлчилгээнд бүгдийг ашиглах
шаардлагагүй байжээ.....55

Бүлэг 4. “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулсан хандив,
тусламжийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт,
тайлагнал59

- 4.1 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж БНХАУ-аас ирүүлсэн
буцалтгүй тусламжийн тавилга, эд хогшлыг ажлын хэсэг
томилон хүлээн аваагүй, тэдгээрийг зохих байгууллагын
шийдвэргүйгээр тараасан байна.....59
- 4.2 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж БНСУ-ын олон улсын
“Койка” байгууллагаас хандивласан буцалтгүй тусламжийн нийт
хөрөнгийн хэмжээ, үнийн дүн тодорхойгүй байна.....65
- 4.3 Төрийн байгууллагууд хандивын хөрөнгийг хэрхэн үнэлж
бүртгэлд тусгасан нь тодорхой баримтаар нотлогдохгүй
байна.....66
- 4.4 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж бусад байгууллагаас
хандивласан хөрөнгийг зохих зөвшөөрлийн дагуу бүртгэлд
тусгаагүй байна.....67

Аудитын дүгнэлт68

Аудитын зөвлөмж70

Хавсралтууд.....71



Товчилсон үгийн жагсаалт

АСЕМ	Ази Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ААН	Аж ахуйн нэгж
АЗТБХЗГ	Авто замын төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОНХАЖЯ	Байгал орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БАА	Бэлтгэл ажлын алба
БХЯ	Батлан хамгаалах яам
БХБЯ	Барилга хот, байгуулалтын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГХС	Гадаад харилцааны сайд
ГТЕГ	Гааль, Татварын ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЕС	Ерөнхий сайд
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТБХЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ЗТС	Зам тээврийн сайд
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
МУЭ	Монголын урчуудын эвлэл
МХЗХС	Монголын Хүүхэд, залуучуудын хөгжлийн сан
МГЗНХ	Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НСУГ	Нийслэлийн соёл, урлагийн газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮУБН	Нийтлэг үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОАТ	Онцгой албан татвар
ОУ	Олон улс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар



СЯ	Сангийн яам
СС	Сангийн сайд
ТагЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ТЗҮЭГ	Төр, захиргааны үйлчилгээ эрхлэх газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЗУГ	Төрийн захиргаа удирдлагын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮЗ	Үндэсний зөвлөл
ХЗЯ	Хууль зүйн яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ХС	Хөдөлмөрийн сайд
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБ	Хөгжлийн банк
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЭСЯ	Элчин сайдын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв



Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлтэй холбоотой улс, нийслэлийн төсвийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийн хөрөнгийн зарцуулалтыг төрийн 46 байгууллага, 28 хуулийн этгээдийг хамрууллаа.

Аудитад ашигласан арга зүй

Аудитын явцад Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан болон түүнд оролцсон байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, холбогдох судалгааг гаргуулан авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, хөрөнгийг биетээр болон анхан шатны баримтаар тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын Олон Улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт, Аудитын Олон Улсын стандарт, Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт зэргийг шалгуур болгохоос гадна дараах хууль, эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулиар "АСЕМ"-тай холбоотой батлагдсан хөрөнгө;
- Нийслэлийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор 2015, 2016 оны нийслэлийн төсвөөс "АСЕМ"-тай холбоотой батлагдсан хөрөнгө;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төсвийн тухай хууль ;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Татвараас чөлөөлсөн тухай хуулиуд;
- "АСЕМ"-тай холбогдож гарсан Засгийн газрын 2016 оны 142, 189, 248, 220, 332, 227, 317 дугаар тогтоолууд;
- Арилжааны банкны тухай хууль;
- Хөгжлийн банкны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5-6, 9, 11, 14-18, 21, 24-31, 65-67, 69, 70, 73 дугаар заалт;
- "АСЕМ"-ыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөө, гаргасан шийдвэрүүд;
- ТӨБЗГ-ын 2017 оны 75, 76, 77, 78, 121, 122, 123 дугаар тогтоолууд;
- Татварын тухай хууль;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд.

Аудитын гүйцэтгэх үе шатны болон чанарын хяналтыг зохих журмын дагуу Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг удирдан зохион байгуулж,



чанарын баталгаажуулалтыг Чанарын баталгаажуулалтын албаны дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Батбаяр хэрэгжүүлж, аудитыг Чанарын баталгаажуулалтын албаны менежер Л.Одгэрэл ахалж, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Ариунжаргал, гэрээт аудитор Ш.Гүрпүрэв, Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Я.Наранцэцэг, аудитор Ц.Гэрэл нар 2017 оны 11 дүгээр сарын 20-нд эхэлж, 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэв.

Аудитад тулгарсан бэрхшээлтэй асуудлууд

“АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг ГХЯ-ны архиваас 58 ширхэг боть материал авч танилцлаа. Түүнд “АСЕМ”-ын үйл ажиллагааг зохион байгуулсан нэгтгэсэн төлөвлөгөө, хөрөнгийн эх үүсвэр зарцуулалтын талаарх нэгдсэн тайлан бэлтгэж тайлагнаагүй байна.

“АСЕМ”-ын зохион байгуулалттай холбоотой улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн чиглэл бүрээр шалгах түүнд оролцогч бүрийг тогтооход бэрхшээлтэй хэмжээ, далайц ихтэй ажил байлаа.

Мөн гадаад улс орноос буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгийг бүртгэсэн байдал болон гаалийн байгууллагад мэдээлсэн хэмжээгээр тулган баталгаажуулсан.

Зарим хөрөнгийн талаар баримт мэдээлэл бүрхэг, олдоогүй учраас бүрэн магадлан тогтооход хүндрэлтэй байсан.

“АСЕМ”-ын үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдүүд хөрөнгө, үйл ажиллагааны чиглэлээр өргөн хүрээтэй оролцож, ерөнхий гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгч рүү хөрөнгийн зарцуулалт хийсэн учраас богино хугацаанд иргэн, хуулийн этгээдийг олж лавлан тодруулах, аудитын тулган баталгаажуулалт хийхэд ихээхэн бэрхшээлтэй байлаа. Зарим хуулийн этгээдтэй холбогдсон боловч ирж уулзаагүй, санхүүгийн тайлан, баримт материал бүрэн бус, байхгүй байх зэрэг зөрчил дутагдал элбэг тааралдсан болно.



Бүлэг 1.

УИХ, ЗГ “АСЕМ”-ын үйл ажиллагаа, түүний үр дүн, ач холбогдлыг дүгнээгүй байна.

Ерөнхий мэдээлэл

МУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 163 дугаар зарлигаар Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүрэгтэй Үндэсний зөвлөл байгуулагдсан байна.


МУ-ын Ерөнхий сайдын 2015 оны 17 дугаар захирамжаар Үндэсний зөвлөлийг 6 ажлын хэсгээр байгуулж, 2015 оны 128, 2016 оны 13 дугаар захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

Зураг 1.



Зураг 2.

АСЕМ-ын бэлтгэл ажлыг хангах ажлын албаны бүтэц





1.1 "АСЕМ"-ын бэлтгэл ажлыг хангах болон зохион байгуулан явуулсан зарим ажил нь хууль зөрчсөн байна.

МУ-ын УАБЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 дугаар зөвлөмжөөр Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар тогтжээ.

Уг зөвлөмжөөр доорх байгууллагуудаар хийж гүйцэтгэх ажлыг тусгаж өгсөн байна. Тухайлбал: Үүнд:

Ерөнхийлөгчид:

- Уулзалтыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүргээр хангах “Үндэсний зөвлөл байгуулах”;
- Уулзалтыг зохион байгуулах ажлыг бодлогын удирдлагаар хангаж ажиллах;
- Уулзалтын үеэр бусад дээд, өндөр түвшний уулзалтыг зохион байгуулах.

Улсын Их Хуралд:

- Уулзалтын бэлтгэлийг хангаж, зохион байгуулах зардлын санхүүжилтийг 2015, 2016 оны улсын нэгдсэн төсөвт тусгах;
- Шаардлагатай тохиолдолд материал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон төлөөлөгчдөд үйлчлэх унаа, тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татвараас чөлөөлөх.

Монгол Улсын Засгийн газарт:

- Уулзалтын тов, сэдвийг тодруулж холбогдох талуудтай тохирох;
- ҮЗ-ийн ажлын хэсгүүд болон ажлын албыг байгуулан ажиллуулах;
- ҮЗ-ийн ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг сар, бүр гаргаж МУ-ын Ерөнхийлөгчид танилцуулж байх;
- Уулзалтын хүрээнд “АСЕМ”-ын парламентчидын, бизнесийн, иргэний нийгмийн болон оюутан, залуучуудын чуулга уулзалт, Сангийн сайд нарын болон ахлах албан тушаалтны уулзалт, “АСЕМ”-ын 20 жилийн ойн арга хэмжээ, бусад арга хэмжээг зохион байгуулах;
- Уулзалтыг зохион байгуулах хурлын төв болон бусад дэд бүтцийн бэлтгэлийг хангах дараах арга хэмжээг авах:
 - “Чингис хаан” олон улсын нисэх буудлын агаарын хөлгийн зогсоолын талбайг нэмэх, газрын үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүндэт зочдын танхимыг сайжруулж тохижуулах;
 - Шинээр барьж буй олон улсын нисэх буудал болон түүний хурдны автозамыг хугацаанд нь барьж ашиглалтад оруулах арга хэмжээ авах, орон нутгийн нислэгийг тухайн үед нь зохицуулах, нөөц нисэх буудлын асуудлыг судалж үзэх;
 - Их тэнгэрийн ам хүртэлх авто замд өргөтгөл шинэтгэл хийж, богд уулын арын авто замд гэрэлтүүлэг, хайс, бэхэлгээ хийх;
 - Уулзалтыг хийх хурлын төв, зочид буудлыг бэлтгэх, Их тэнгэрт ОУ-ын хурлын төв шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэх;
 - Уулзалтын хүндэт зочдыг байрлуулах хотхоныг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барихад дэмжлэг үзүүлэх; /мөнгөн бус/
 - Шаардлагатай барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж, угсрах зорилгоор гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог тогтоож, зөвшөөрөл олгох;
 - ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн шаардлагатай материал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон



төлөөлөгчдөд үйлчлэх унаа, тээврийн хэрэгслийг нийлүүлэх компанийг сонгож **шууд** гэрээ байгуулах;

- Уулзалтын бэлтгэлийг хангаж зохион байгуулахад гадаадын улсуудаас тусламж авах чиглэлийг тодорхойлж холбогдох улсуудтай яриа хэлэлцээ хийх;
- Уулзалтын үеэр ажиллах англи, орос, хятад, франц, испани, араб болон бусад шаардлагатай хэлний синхрон орчуулагчдыг бэлдэх, сайн дурынхныг сонгон сургаж дадлагажуулах.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 163 дугаар зарлигаар Үндэсний зөвлөлийг байгуулж, түүний бүрэлдэхүүнийг нь дараах байдлаар баталжээ. Үүнд:

- ❖ Үндэсний зөвлөлийн даргаар: МУ-ын Ерөнхий сайд,
- ❖ Үндэсний зөвлөлийн дэд даргаар: ГХС, ЕТГ-ын дарга,
- ❖ Үндэсний зөвлөлийн гишүүдэд: СС, ЗГХЭГ-ын дарга, НЗД бөгөөд УБ хотын захирагч, Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх, УИХ-ын даргын Ахлах зөвлөх, Ерөнхий сайдын Ахлах зөвлөх, Ерөнхий сайдын олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн зөвлөх, ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга нарыг тус тус оролцуулахаар,
- ❖ Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар: ГХЯ-ны ТНБД ажиллахаар,
- ❖ Үндэсний зөвлөлийн ажлын хэсгүүд болон ажлын албыг байгуулан ажиллуулах, ҮЗ-ийн ажлын төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийг нь сар бүр танилцуулж ажиллахыг Үндэсний зөвлөлийн дарга буюу Ерөнхий сайдад даалгасан байна.

МУ-ын Ерөнхий сайдын 2015 оны 01 дүгээр сарын 16-ны 17, 2015 оны 05 дугаар сарын 22-ны 128, 2016 оны 01 дүгээр сарын 21-ний 13 дугаар захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, хоёрдугаар хавсралтаар чуулга уулзалтыг зохион байгуулах ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Үүнд:

1. Байр, зочид буудлын асуудал хариуцсан,
2. Аюулгүй байдал, ёслол, улсын хил нэвтрэх асуудал хариуцсан,
3. Зам, тээвэр, харилцаа холбоо, нисэх буудлын асуудал хариуцсан,
4. Үйлчилгээ, соёл урлагийн арга хэмжээ, хоол хүнс, түүний аюулгүй байдлыг хариуцсан,
5. Дээд түвшний уулзалтын хуралдаан, үндсэн арга хэмжээнүүдийн зохион байгуулалт, баримт бичгийн асуудал хариуцсан,
6. Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан нийт 6 ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна.

УИХ-ын даргын 2016 оны 02 дугаар сарын 12-ны 28 дугаар захирамжаар Ази, Европын Парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг 2016 оны 4 дүгээр сарын 21-ээс 23-ны өдрүүдэд зохион байгуулахаар, уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна.

УИХ-аас "АСЕМ"-ын үйлчилгээнд ашиглах зориулалтаар импортоор оруулж байгаа суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийг Гаалийн, Нэмэгдсэн өртгийн, Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05-нд баталж гаргасан байна.

Дээрх хуулиуд батлагдсантай холбогдуулан Засгийн газраас импортоор оруулж ирэх автомашин техник хэрэгслийн жагсаалтыг 2016 оны 142, 248, 342, 220, 227, 317 дугаар тогтоолуудаар баталсан байна.



ҮАБЗ-ийн 2014 оны 63/37 дугаар зөвлөмжийн 3.5.7 дахь хэсэгт заасны дагуу ТБОНӨХБАҮХАТХ-ийн дараах заалтыг баримтлан *шууд* гэрээ байгуулсан байна.

- 3.4-д “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”,
- 34.1.5-д “гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол”.

Дээрх 2 заалтыг хэрэгжүүлсэн байдал нь “АСЕМ”-ын уулзалтыг зохион байгуулахтай холбоотой ажил, үйлчилгээ бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал мөн эсэх, мөн “*гэнэтийн болон давагдашгүй хүчний шинж*”-тэй онцгой байдал мөн эсэх зэрэг маргаантай асуудлыг үүсгэж байгаа боловч түүнийг тодруулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ҮАБЗ-ын тухай хуулийн 2 дугаар зүйлд ҮАБЗ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн “*зөвлөлдөх*” байгууллага болохыг тодорхойлсон байна.

Мөн ҮАБЗ нь чиг үүргийнхээ дагуу түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, улс, үндэснийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн хамгаалах зарчмыг баримтлан, хууль, тогтоомжийн бусад актуудад нийцүүлэн, эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэр гаргадаг байгууллага болохыг тус хуульд зааж өгсөн байна.

Гэтэл ҮАБЗ-ийн 2014 оны 63/37 дугаар зөвлөмжийн 3.5.7 дахь хэсгээр өгсөн зөвлөмжийг үндэслэл болгон ЗГ болон бусад төрийн байгууллагаас эрх зүйн шийдвэр гаргаж хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу “АСЕМ”-ын үйл ажиллагааг зохион байгуулахад хамааралтай гэж үзсэн бүх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо *шууд* гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчих нөхцөл бүрдүүлсэн байна.

Аудитын явцад Шүүхийн тухай хуулийн 17.3.1¹-д заасны дагуу Улсын дээд шүүхээс ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.1.5 дахь “*гэнэтийн болон давагдашгүй хүчний шинж*”-тэй онцгой байдлын талаарх тайлбар гаргуулахаар хандсан боловч “тайлбар өгөх” журам гараагүй учраас боломжгүй гэсэн байна.

Иймд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Аудитын явцад ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн дараах зөрчил илэрлээ. Үүнд: Үнэлгээний хороо байгуулаагүй, үнэлгээний хороо байгуулсан боловч хэрхэн хэлэлцэж шийдвэрлэсэн нь тодорхойгүй, худалдан авах ажиллагааг багц болгон явуулсан боловч багц тус бүрээр үнэлгээ хийгээгүй, *шууд* гэрээ байгуулсан үндэслэл, тайлбарын талаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж

¹ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх гэж Улсын дээд шүүхийн эрхийг тодорхойлсон.



байгаагүй, гүйцэтгэлийн баталгаа шаарддаггүй, худалдан авах ажиллагаанд оролцогчийн зүгээс үнэлгээний хорооны шийдвэрт нөлөөлсөн зэрэг болно.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 163 дугаар зарлиг болон ҮАБЗ-ийн зөвлөмжийн 3.3-т заасны дагуу ҮЗ-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг Ерөнхийлөгчид танилцуулж ажиллахыг даалгасан боловч хэрэгжээгүй байна.

“АСЕМ”-ыг Монгол Улсад зохион байгуулахын зорилго, түүний ач холбогдлын талаар тодорхойлсон болон түүний үр дүнг УИХ, ЗГ дүгнэсэн албан ёсны баримт материал ГХЯ-ны архивд байхгүй байна.

1.2 “АСЕМ”-ыг зохион байгуулсан нэгжүүд түүнд оролцсон иргэн, хуулийн этгээдийн үүрэг оролцоог гэрээнд тодорхой зааглаж тусгаагүй, төлөвлөгөө, тайлан гаргах талаар эрх зүйн баримт бичигт тодорхой заагаагүй байна.

“АСЕМ”-ын БАА болон “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас “АСЕМ”-ын үйл ажиллагаанд нийт 24.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын ихэнхийг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, зарцуулсан байна.

“АСЕМ”-ын үйл ажиллагааг бэлтгэн зохион байгуулсан иргэн, хуулийн этгээдтэй хийсэн ихэнх гэрээнд захиалагч, гүйцэтгэгч 2 тал нь хийсэн ажлаа дүгнээгүй, гэрээгээр хүлээсэн ажлын үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангаа гаргаж хянуулахаар заалт орсон боловч хэрэгжүүлээгүй байна.

“АСЕМ”-ын бэлтгэл үйл ажиллагаа 2014 оны 12 дугаар сард МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг гарснаар эхэлсэн гэж үзэх талтай боловч эрх зүйн зохицуулалтыг дутуу хийсэн байна. *Тухайлбал,*

- *Иргэн, хуулийн этгээдтэй хийх гэрээний үлгэрчилсэн иж бүрэн загварыг гэрээгээр гүйцэтгэх ажлын төрлөөр гаргаагүй, түүнд захиалагч, гүйцэтгэгчийн эрх үүрэг хариуцлага, хяналтын талаар тодорхой тусгах асуудлыг орхигдуулсан, иргэн, хуулийн этгээдтэй ажил үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө түрээслэх гэх мэт гэрээнүүд утга агуулга, бүтцийн хувьд хангалтгүй болсон зэргээс гэрээгээр хяналт тавих боломжгүй болгосон байна.*
- *Мөн “ажлын шаардлага”-аас гэсэн үндэслэлээр гэрээг тухайн үед байгуулалгүй нөхөн гаргасан зөрчлүүд гарч байна.*

Иргэн, хуулийн этгээдүүд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн актыг нэр төдий, хянах боломжгүй, хийсэн ажил тодорхой бус бичигдсэн байдлаар хийсэн байхад түүнийг төдийлөн харгалзан үзээгүйгээр хүлээн авч байжээ.

Гэрээгээр зарцуулсан мөнгөнөөс хөрөнгө, материал бэлтгэсэн боловч түүнийгээ захиалагчид өгөх талаар гэрээнд тусгаагүйгээс өгөөгүй байна.

Аудитын явцад иргэн, хуулийн этгээдтэй холбогдож гэрээгээр гүйцэтгэсэн ажлын санхүүгийн гүйцэтгэлийн тайлан, баримттай танилцаж, тодруулан шалгах гэсэн боловч тэдгээрийн ихэнх нь холбогдоогүй учир бэлтгэсэн хөрөнгө, материалын нэгдсэн судалгааг гаргах боломж гарсангүй.



1.3 "АСЕМ"-ын үйл ажиллагааны зардлын нэгдсэн төсөв гаргаагүйгээс гүйцэтгэлийн тайлагнал байхгүй, түүнд тавих дотоод хяналт орхигдсон байна.

"АСЕМ"-ын бэлтгэл, үйл ажиллагаанд улсын төсвөөс зарцуулагдах зардлын төсвийг УИХ-аас батлан гаргасны дагуу ГХЯ тайлагнажээ. Харин бусад эх үүсвэрээс санхүүжигдсэн орлого, түүний зарцуулалтыг төлөвлөн, гүйцэтгэлийг нэгтгэн гаргаагүй байна.

ҮЗ 2015-2016 онд нийт 31 удаа хуралдаж, нийт 79 хүн /давхардаагүй/ оролцож "АСЕМ"-ыг зохион байгуулахтай холбоотой 130 асуудлыг хэлэлцэн 174 асуудлыг шийдвэрлэсэн байна. /ГХЯ-ны архивд ҮЗ-ийн Анхдугаар хуралдааны материал байхгүй байна./

ЗГ-ын 2014 оны 382 дугаар тогтоол болон ГХС-ын 2015 оны 08 дугаар сарын 31-ний А/75 дугаар тушаалаар "АСЕМ"-ын БАА байгуулагдсан байна. Энэхүү ажлын алба "АСЕМ"-ын уулзалт болон түүний дагалдах арга хэмжээнүүдийг зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангах, ҮЗ-ийн ажлын хэсгүүдийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх, ажлын хэсгүүдийн уялдаа холбоог зохицуулах ажлыг хариуцсан байна.

"АСЕМ"-ын БАА-нд 2015 оны 09 дүгээр сарын 01-ээс 2016 оны 08 дугаар сарын 01-нийг хүртэл нийт 46 хүн /зөвлөх 8, ахлах мэргэжилтэн 2, зохицуулагч 1, мэргэжилтэн 35/-ийг ажиллуулахаар "ажил гүйцэтгүүлэх гэрээ" байгуулан ажиллаж, цалин, нийгмийн даатгалд нийт 645.2 сая төгрөг зарцуулсан байна.

ГХЯ-ны архивд байгаа "АСЕМ"-ын БАА-аас 2015 оны 11 дүгээр сард гүйцэтгэсэн ажлын тайланг эс тооцвол "АСЕМ"-ын бэлтгэл, үйл ажиллагаа, санхүүгийн зарцуулалтын тайланг ҮЗ болон ЗГ-т танилцуулагдаж байсан гэсэн нотлох баримт байхгүй байна.

"АСЕМ"-ын үйл ажиллагаанд нийт 395.7 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд үүний 23.0 хувь буюу 90.9 тэрбум төгрөг нь улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөс, 11.6 хувь буюу 46.1 тэрбум төгрөг нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, хандив тусламжийн хөрөнгөөс, 65.4 хувь буюу 258.7 тэрбум төгрөг нь гадаад, дотоодын банкны зээлээс зарцуулагдсан байна.

Хүснэгт 1

Хөрөнгийн эх үүсвэрийн судалгаа

№	Хөрөнгийн эх үүсвэр	Дүн /тэрбум төгрөг/	эзлэх хувь
1	Улсын төсөв	58.3	14.7
2	Нийслэлийн төсөв	32.6	8.2
3	ТӨҮГ-ын өөрийн хөрөнгө	23.9	6.0
4	хандив тусламж	22.2	5.6
5	ХБ-ны үнэт цаасаар олгосон зээл	233.4	59.0
	БНСУ-ын "Экспорт-Импорт" банкны зээл	13.7	3.5
	43 автобусыг худалдсан лизингийн зээл	11.6	2.9
	нийт хөрөнгө	395.7	100

Эх сурвалж: аудитын ажлын баримт

"АСЕМ"-ын хүрээнд гарсан эрх зүйн баримт бичигт "АСЕМ"-ын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг орхигдуулсан бөгөөд "АСЕМ"-ын үйл ажиллагааны санхүүгийн тайлагналыг хэзээ гаргах, түүнд хэн хяналт тавих талаар эрх зүйн заалт байхгүй байна.

"АСЕМ"-ын БАА-аас төсвийн хөрөнгийн зарцуулалт, хандив тусламжийн хөрөнгийн орлого, зарцуулалтад тавих дотоод хяналтыг мөн орхигдуулснаас төрөөс тавих хяналтгүй болсон байна.



Бүлэг 2. “АСЕМ”-д зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн

Үндсэн мэдээлэл

“АСЕМ”-ын үйл ажиллагаанд улсын төсвөөс нийт 58.3 тэрбум, нийслэлийн төсвөөс 32.6 тэрбум, нийт 90.9 тэрбум төгрөг, төрийн өмчит аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөс 23.9 тэрбум, нийт 114.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2.1 “АСЕМ”-ыг зохион байгуулах зориулалтаар батлагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг орхигдуулснаас хөрөнгийг хяналтгүй зарцуулж, хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Үндсэн мэдээлэл

МУ-д 2016 онд Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ”-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж ГХС-ын төсвийн багцад “АСЕМ”-ын БАА-нд 2015 онд 5,000.0 сая, 2016 онд 21,104.9 сая төгрөг, нийт 26,104.9 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2015 онд 3,988.1 сая, 2016 онд 19,268.7 сая төгрөг, нийт 23,256.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2

Батлагдсан хөрөнгийн зарцуулалт

Д/д	Зардлын нэр	Дүн /сая.төг/
1	Салбар хуралдаан, уулзалтуудын зардал	1,303.0
2	Дээд хэмжээний уулзалтын зардал	2,645.3
3	АСЕМ-ын шууд дамжуулалтын төлбөр	657.0
4	Үндсэн хөрөнгө	1,078.9
5	Автомашин худалдан авах зардал	3,508.4
6	Бараа материал	305.3
7	ГХЯ-ны АСЕМ-ын БАА-ны зардал	1,506.4
8	ГХЯ-ны АСЕМ-ын БАА-ны цалингийн зардал	645.3
9	ГХЯ-ны АСЕМ-ын БАА-ны томилолтын зардал	358.8
10	Сурталчилгаа	820.2
11	Сайн дурын ажилтнуудын зардал	365.8
12	Тоног төхөөрөмжийн түрээс	547.0
13	Шатахууны зардал	122.3
14	ТЗҮЭГ-ын засвар үйлчилгээний зардал	653.4
15	Асем Виллагийн зардал	4,703.4
16	Шангрилла зочид буудалтай холбоотой зардал	1,422.2
17	Бэлэг дурсгалын зардал	938.9
18	Асемд ажилласан ажилтнуудын хоол, хүлээн авалтын зардал	727.6
19	АСЕМ-ын хэвлэлийн төв байгуулах зардал	947.6
	Нийт дүн	23,256.8

Эх сурвалж: аудитын ажлын баримт

2015 онд 2,500.0 сая төгрөгийг цагдаагийн тусгай хамгаалалт бүхий 52 ш “Приус-30” маркийн автомашины урьдчилгаа төлбөрт шилжүүлж, 1,488.1 сая төгрөгийг “АСЕМ”-ын БАА-ны урсгал зардалд зарцуулсан байна.

2016 онд 19,268.7 сая төгрөгийг “АСЕМ”-ын хурал, уулзалтуудыг зохион байгуулах болон БАА-ны урсгал зардалд зарцуулсан байна.



“АСЕМ”-ын 8 салбар дагалдах уулзалтуудыг зохион байгуулахад 100 иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллаж нийт 1,303.0 сая төгрөг зарцуулсан байна.
/дэлгэрэнгүйг хавсралт №1-с үзнэ үү/

“АСЕМ”-ын дээд түвшний уулзалтыг 2016 оны 07 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 2,645.5 сая төгрөг зарцуулсан байна.
/дэлгэрэнгүйг хавсралт №2-с үзнэ үү/

2.1.1 “АСЕМ”-ыг зохион байгуулах ҮЗ-ийн 2016 оны 02 дугаар сарын 04-ний 14 дүгээр хуралдаанаар уулзалтын зочид төлөөлөгчдийн бүртгэл, итгэмжлэл, нэвтрэх үнэмлэх олгох зэрэг аюулгүй байдлыг хангаж ажиллах зорилгоор олон улсад энэ чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Итали Улсын “Триумф групп”-тэй “Үйлчилгээ үзүүлэх” гэрээг яаралтай байгуулахыг “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуягт үүрэг болгосны дагуу тус компанид үйлчилгээний төлбөрт нийт 132.8 мянган евро төлөхөөр 2016 оны 02 дугаар сарын 19-нд гэрээ хийгдсэн байна.

Дээрх гэрээний 3 дугаар зүйлд² тусгасны дагуу “Триумф групп”-ын төлөөлөгчдийн нэмэлт зардал болох арга хэмжээний газарт очих, баг илгээх, 2016 оны 4 болон 6 дугаар сард зохион байгуулах арга хэмжээний зөвлөхийн зардал, тоног төхөөрөмж илгээх зардал, бүх ажилтны байр хоолны мөнгө, итгэмжлэлийн серверт ажиллах операторын зардал гэх мэт зардлуудыг ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны албаны дарга Д.Ганхуягийн 2016 оны А/73, А/146, А/171 дүгээр тушаалаар нийт 54.8 сая төгрөг баталсан байна.

Дээрх нэмэлт зардлыг гэрээний дүнд тусгаж нэмэлт гэрээ байгуулаагүй нь гэрээний 9 дүгээр зүйл³-д заасантай нийцэхгүй байна.

“Триумф групп” 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр гэрээний үлдэгдэл төлбөр болох 20.4 мянган еврог нэхэмжилсний дагуу 2016 оны 12 дугаар сарын 23-нд 53.6⁴ сая төгрөгийг гэрээг дүгнэсний дараа төлөхөөр МУ-аас Итали Улсад суугаа ЭСЯ-ны дансанд шилжүүлж, өглөгөөр бүртгэж ирсэн бөгөөд өнөөдрийг хүртэл 2 талаас гэрээг дүгнээгүй байгаа тул ЭСЯ-ны харилцах дансанд байна.

Гэрээний дагуу “Триумф групп”-д нийт 163.4 мянган евро буюу 378.0 сая төгрөгийг шилжүүлэхээс 143.0 евро буюу 324.4 сая төгрөгийг СЯ-ны гадаад гуйвуулгын гүйлгээгээр дамжуулан еврогоор шилжүүлсэн байна.

2.1.2 “АСЕМ”-ын БАА-ны төсвөөс нийт 1,884.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авснаас 2016 оны 07 дугаар сарын 21-нд “Моннис моторс” ХХК-тай АП-37/07 дугаар гэрээ байгуулан 427.0 сая төгрөгөөр 3ш Ниссан патрол маркийн автомашин, ХБНГУ-ын “Мерседес” компанитай 2016 оны 04 дүгээр сарын 25-нд 110 дугаар гэрээ байгуулан 581.4 сая төгрөгөөр тусгай зориулалтын 2ш “Мерседес бенз” маркийн автомашинуудыг худалдан авч, 2016 оны 05 дугаар сарын 03-нд ТТХГ болон ТагЕГ⁵-т акт үйлдэн шилжүүлсэн байна.

² “үйл ажиллагаанд тусгаадаагүй болон эсвэл нэмэлт аливаа зардлыг тусад нь үнэлж нэмэлт үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой зардлын төсвийг үйлчлүүлэгч урьдчилан батална”

³ “ тус хэлэлцээрт оруулах аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн харилцан тохиролцож гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр болно”

⁴ Монголбанкны 2016.12.23-ны ханш 2631 төг

⁵ Нэмэлт тусгай аудитын тайлан




2.1.3 МУ-ын Ерөнхийлөгчийн 2016 оны 12 дугаар сарын 05-ны “Засгийн газарт чиглэл өгөх” тухай 161 дүгээр зарлигийн 2-т “Ази Европын Дээд түвшний уулзалт болон “АСЕМ-ын өдөр”-ийг тэмдэглэж өнгөрүүлэхтэй холбоотой төр, иргэд, уран бүтээлчид, олон нийтийн санал санаачилгыг дэмжих нь зүйтэй” гэж ЗГ-т чиглэл өгсний дагуу МУЭ-ийн шагналт зураач А.Чадраабал “Тэнгэрийн өрх” уран баримлын загварыг гаргаж танилцуулсан гэх боловч хэзээ хэнд танилцуулсан, ямар эрх зүйн үндэслэлтэй шийдвэр гарсан, ямар аргаар сонгон шалгаруулалт явуулсан, тендер зарласан эсэх нь тодорхойгүй баримт, материал байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁶, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

Зураг 3

“АСЕМ”-ын ҮЗ-ийн 2016 оны 04 дүгээр сарын 20-ны 23 дугаар хуралдаанаар Ази, Европын дээд түвшний уулзалтын 20 жилийн ойн түүхэн дурсгалт хөшөөг байгуулах асуудлыг хэлэлцэж, МУ-д “АСЕМ” -ыг зохион байгуулсан дурсгалд зориулсан хөшөө хийлгэхээр шийдвэрлэсний дагуу “АСЕМ”-ын нэрэмжит хүрэл цутгамал “Тэнгэрийн өрх” нэртэй 500.0 сая төгрөгийн үнийн дүнтэй хөшөө хийхээр “АСЕМ”-ын БАА /Ерөнхийлөгчийн зөвлөх бөгөөд БАА-ны олон нийттэй харилцах ажлын хэсгийн ахлагч А.Ганбаатар/, “Олон Улсын уран бүтээлчдийн Монголын холбоо” ТББ /тэргүүн А.Чадраабал/ нар 2016 оны 08 дугаар сарын 02-нд 01 дугаартай гэрээ байгуулсан байна.



“Олон Улсын уран бүтээлчдийн Монголын холбоо” ТББ-д гэрээний дагуу ГХЯ-аас 2016 оны 08 дугаар сарын 03-нд 500.0 сая, 2016 оны 12 дугаар сарын 21-д “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас уг уран баримлыг БНХАУ-аас оруулж ирэх гаалийн татвар 58.1 сая, бусад нэмэлт зардалд 22.0 сая төгрөг, нийт 580.1 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

“Тэнгэрийн өрх” хөшөөг Д.Сүхбаатарын нэрэмжит талбайн урд талын цэцэрлэгт хүрээлэн дэх “Энхтайваны хонх” хөшөөний сууринд байрлуулахын тулд “Энхтайваны хонх” хөшөөг сууринаас баруун тийш 50 м орчимд нүүлгэн шилжүүлж, 2 хөшөөний суурийг бэлтгэх ажлыг сонгон шалгаруулалт хийлгүйгээр 2016 оны 11 дүгээр сарын 20-нд 71.9 сая төгрөгөөр “Шандаст хонгор” ХХК-аар гүйцэтгүүлэхээр 10/16 дугаартай гэрээг “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ, “Шандаст хонгор” ХХК-тай байгуулсан байна.

⁶ “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”

⁷ “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”



Уг ажлын санхүүжилтийг “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-ийн УЗ-ийн 2016 оны 11 дүгээр сарын 20-ны 8/16 дугаар тогтоолоор 88.6 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэсний дагуу нийт 71.9 сая төгрөгийг “Шандаст хонгор” ХХК-д олгосон байна.

Мөн хөшөөний ажилтай холбоотойгоор 2016 оны 11 дүгээр сарын 01-нд иргэн Д.Бат-Эрдэнэтэй 16.7 сая төгрөгийн ямар ажил гүйцэтгэх нь тодорхойгүй, “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-ын захирал, тэргүүн нар баталгаажуулаагүй, зөвхөн тус сангийн нягтлан бодогч гарын үсэг зурсан 11/16 дугаар гэрээг байгуулсны дагуу 2016 оны 11 дүгээр сарын 22-нд 15.0 сая төгрөгийг Д.Бат-Эрдэнэд бэлэн мөнгөөр олгосон байна.

Энэхүү гэрээгээр ямар ажил үйлчилгээ үзүүлэх, юу худалдан авах нь тодорхойгүй, хийж гүйцэтгэсэн ажлын санхүүгийн анхан шатны баримт, ажлын тайлан байхгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

“Тэнгэрийн өрх” хөшөө хийлгэх, суурилуулах болон “Энхтайваны хонх” хөшөөг зөөж суурилуулахтай холбоотой нийт 668.7 сая төгрөгийн зардал гарсан боловч анхан шатны санхүүгийн баримт дутуу, ажил хүлээж авсан акт, хүлээлгэж өгсөн акт баримт байхгүй байгаа нь түүнд Нийслэлээс тавих хяналтгүй байсныг харуулж байна.

Уг нь НЗД-ын 2016 оны 11 дүгээр сарын 9-ны А/789 дүгээр захирамжаар “Тэнгэрийн өрх” хөшөөг Нийслэлийн өмчид бүртгэх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т үүрэг болгосон боловч өнөөг хүртэл өмчид бүртгээгүй, эзэмшил тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁹, 14.4.2¹⁰-т заасантай нийцэхгүй байна.

Ийнхүү уг хөшөөг хамгаалах эзэнгүй байснаас аудитын тулган баталгаажуулалтаар хөшөөнд янз бүрийн үг эрээчсэн, суурь нь эвдэрсэн байдалтай байна.

Зураг 4



Зураг 5



2.1.4 “АСЕМ”-ын БАА-ны төсвөөс ГТЕГ /хуучин нэрээр/-т Буянт ухаагийн гаалийн байцаагчдын дүрэмт хувцасны үнэнд 32.0 сая, ТТХГ-т “Их тэнгэр цогцолбор”-ын аяга

⁸ “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”

⁹ “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”

¹⁰ “бүх хөрөнгө, хөрөнгөө оруулалт, авлага”



таваг шинээр худалдан авахад зориулж 100.1 сая төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

2.1.5 “АСЕМ”-ын БАА-ны 2015, 2016 оны төсвөөс урсгал зардалд нийт 1,957.5 сая төгрөг зарцуулснаас 507.3 сая төгрөгийг “АСЕМ”-ын бэлтгэл ажилд хамааралгүй арга хэмжээнд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал;

- “Монголын мянган сорилын сан”-д 4.4 сая төгрөгийн тавилга, ДБҮЭГ-ын цайны газарт 12.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч ГХЯ-ны хөрөнгөд бүртгэсэн, “Гадаад харилцааны нэгдмэл байдлыг хангах тухай” хуулийн төсөл боловсруулах, “Дипломат албаны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар иргэн Ж.Нарантуяа, В.Энхтамир нартай гэрээ байгуулан 10.0 сая төгрөг төлсөн, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нарын газарт 50.0 мянган ам доллар буюу 99.5 сая төгрөгийн хандивыг санхүүжүүлсэн, ГХЯ-ны ажилтнуудын гадаад томилолтод 263.9 сая төгрөг, нийт 507.3 сая төгрөг зарцуулсан байна.

- ГХЯ-ны сайд, ажилтнууд “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбогдолгүй гадаад томилолтын зардалд зарцуулсан 263.9 сая төгрөгийн зарцуулалтыг нотлох баримттай тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ГХС асан Л.Пүрэвсүрэн, сайдын туслах Г.Учралт нар нь 2015 оны 09 дүгээр сарын 09-өөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганд оролцохоор явахдаа сайдын зочид буудлын зардлыг 1 хоногт 5,000.0 ам доллар, туслахын зочид буудлын зардлыг 1 хоногт 200-400 ам.доллараар тооцон гарсан бөгөөд гүйцэтгэлээр сайдын зочид буудалд 1 хоногт 1,500.0 ам.доллараар тооцон сайдад 12.8 мянган ам.доллар буюу 25.6 сая төгрөгөөр илүү олгосон, туслахын зочид буудлын зардлыг 1 хоногт 240 ам.доллар, харилцаа холбооны зардалд 200 ам.доллар, нийт 600 ам.доллар буюу 1.2 сая төгрөгөөр илүү олгосон,

- ГХС асан Л.Пүрэвсүрэн, Бодлого төлөвлөлт зохицуулалтын газрын захирал Г.Амартүвшин нарын 2016 оны 02 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд ХБНГУ-ын Мюнхен хотод бага хуралд оролцсон томилолтын зочид буудлын зардлыг Л.Пүрэвсүрэн 4.0 сая, Г.Амартүвшин 2.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн олгож СС-ын 2011 оны 188 дугаар тушаалын холбогдох заалтыг зөрчсөн байна.

- ГХС-ын 2016 оны А/45 дугаар тушаалаар “АСЕМ”-ын БАА-ны төсвөөс ГХЯ-ны байр болон гаднах талбайн засварын зардалд 117.3 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2¹² дахь заалтыг зөрчсөн байна.

2.1.6 “АСЕМ”-ын уулзалтын үеэр Онцгой байдлын албанаас зохион байгуулсан нэгдсэн хамгаалалтаар Нисэх онгоцны буудал, Хан-Уул дүүргийн Нүхтийн уулзвар, Хан-Уул дүүргийн “МСМ” группийн автозогсоол, Хан-Уул дүүргийн “Монгол Хьюндай” ХХК, Сүхбаатар дүүргийн “Шангри-Ла” зочид буудал, Сүхбаатар дүүргийн Төрийн ордон, Чингис хааны талбай, Хан-Уул дүүргийн “Оргил” худалдааны төвийн зогсоол, Баянзүрх дүүргийн “Ривер бич” амралтын автозогсоол, Баянзүрх дүүргийн “АСЕМ Вилла цогцолбор” гэсэн байршлуудад хамгаалалтад 10,798 км буюу 12044 литр шатахуун зарцуулж 20.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

2.1.7 “АСЕМ”-ын БАА “АСЕМ”-ын дээд түвшний уулзалт болон дагалдах 8 уулзалт, арга хэмжээний бэлэг дурсгалын зардлыг арга хэмжээ тус бүрээр нь тооцож, нийт 215.6 сая төгрөгийн зардлын төсвийг 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуягаар батлуулсан байна.

¹¹ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

¹² “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”



Гэтэл гадаадын зочин, төлөөлөгч нарт 784.4 сая, Монгол Улсын Ерөнхийлөгч "АСЕМ"-ын арга хэмжээнд ажилласан ажилтнуудыг хүлээн авч талархал илэрхийлж 197.0 сая, нийт 981.4 сая төгрөгийг бэлэг дурсгалын зардалд зарцуулсан байна.

Үүнээс дээд хэмжээний уулзалтад оролцсон 1 төлөөлөгчид 6.7 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл гардуулж, нийт 366.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 3

Бэлэг дурсгалын зүйлсийн жагсаалт

Д/д	Гүйлгээний утга	Тоо/ ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн /мян.төг/
1	Флаш диск	55	14,600.0	803.0
2	"АСЕМ"-ын дардастай дэвтэр, хавтас, тор /ком/	55	6,700.0	368.5
3	The History of Mongolia 3 боть ном	70	400,000.0	28,000.0
4	"АСЕМ"-ын хөтөлбөр	55	2,300.0	126.5
5	Принттэй ноолууран алчуур	53	189,000.0	10,017.0
6	"Монголия" ном	55	3,950.0	217.3
7	Япон улсад захиалгаар хийлгэсэн бал	55	42,311.0	2,327.1
8	"АСЕМ"-ын логотой арьсан цүнх	55	308,000.0	16,940.0
9	"АСЕМ"-ын логотой үзгийн гэр	55	12,100.0	665.5
10	Уран зураг	60	3,050,000.0	183,000.0
11	"АСЕМ"-ын логотой эсгий хавтас /33x48/	55	44,545.0	2,450.0
12	Тэргүүнүүдэд эмээл хазаар	55	1,500,000.0	82,500.0
13	Монгол дээл	53	286,000.0	15,158.0
14	"АСЕМ"-ын фото зургийн цомог	55	31,700.0	1,743.5
15	The History of Mongolia 3 боть ном	55	400,000.0	22,000.0
	ДҮН			366,316.4

Эх сурвалж: аудитын ажлын баримт

- АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад оролцсон төлөөлөгчдөд гардуулсан 55 ш эмээл, хазаарыг нэг бүрийг нь 1.5 сая, нийт 82.5 сая төгрөгөөр эмээл хазаар бэлтгэн нийлүүлэх гэрээг ЗХЖШ /дарга Д.Даваа / 2016 оны 07 дугаар сарын 18-нд "Аз билэг Ерөө" ХХК /захирал Д.Алтансүх/ нар байгуулж, санхүүжилтийг 2017 оны 07 дугаар сарын 19-нд ГХЯ-ны "АСЕМ"-ын төсвөөс шилжүүлсэн байна.

"АСЕМ"-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтыг 2016 оны 07 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулсан байтал байгуулсан гэрээ нь уулзалт зохион байгуулагдсанаас хойш 2 хоногийн дараа хийгдэж, төлбөр нь 1 хоногийн дараа шилжсэн, "Аз билэг Ерөө" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд ийм төрлийн үйл ажиллагаа эрхлэх тэмдэглэгээ хийгдээгүй байгаа зэрэг нь эргэлзээтэй байна.

- "АСЕМ"-ын Дээд түвшний уулзалтад оролцох төлөөлөгчдөд өгөх нэн эртний үеийн урлагийг орчин үеийн урлагийн хэлбэрт хөрвүүлсэн 60ш уран зургийг зуруулах /1ш зургийн үнэ 3.0 сая төгрөг, 1ш зургийн хөлийн үнэ 60.0 мянган төгрөг/ гэрээг 2016 оны 07 дугаар сарын 05-нд ГХЯ-ны Ёслолын газар /захирал Д.Тэгшжаргал/, "Монголын үндэсний артель" ХХК /зураач Ш.Тэнгисболд/ нар байгуулж, ГХЯ-ны ТНБД, "АСЕМ"-ын БАА-ны дарга Д.Ганхуяг баталсан бөгөөд 2016 оны 07 дугаар сарын 10-нд ЕТГ-ын нэр бүхий ажилтнууд актаар хүлээн авсан байна.
- "АСЕМ"-ын Дээд түвшний болон дагалдах уулзалтуудад оролцсон бүх төлөөлөгчдөд өгөх гэрэл зургийн 3000ш цомгийг бүтээж, нийлүүлэх /дээд түвшний болон дагалдах бүх хурал зөвлөгөөнийг гэрэл зургаар баримтжуулж, гэрэл зургийн цомгийг бүтээх/ гэрээг 2016 оны 07 дугаар сарын 05-нд "АСЕМ"-ын сурталчилгаа хариуцсан ажлын хэсгийн ахлагч, Ерөнхийлөгчийн зөвлөх



А.Ганбаатар “Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо”-ны ЕНБ-ийн дарга Ц.Батбаатартай байгуулж, ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо”-ны дарга Л.Ганзориг нар баталсан байна.

“АСЕМ”-ын дагалдах уулзалтууд 2016 оны 06 дугаар сараас эхэлж байхад зургийн цомог хийлгэх гэрээг 2016 оны 07 дугаар сарын 05-нд байгуулсан гэрээ нь цаг хугацааны хувьд цомгийг төлөөлөгчдөд гардуулсны дараа нөхөн байгуулсныг харуулж байна.

- “АСЕМ”-ын уулзалтад оролцсон төлөөлөгчдөд өгсөн “The History of Mongolia” 3 боть номыг “НЕПКО” ХХК-аас ЕТГ 2016 оны 05 дугаар сарын 05-нд /3ш-ыг 400.0 мянган төгрөгөөр/ нийт 70 ботийг 28.0 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулан авч ГХЯ-нд 2016 оны 06 дугаар сарын 22-нд хүлээлгэн өгсөн байна.

Мөн “АСЕМ”-ын БАА нь “НЕПКО” ХХК-аас 1300 ш “The History of Mongolia Албанах” номыг /нэг бүрийг нь 60.0 мянган төгрөгөөр/ нийт 78.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Дээрх номуудыг худалдан авах төсөв батлагдаагүй бөгөөд “АСЕМ”-ын ҮЗ-ийн 2016 оны 03 дугаар сарын 02-ны 17 дугаар хуралдаанд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “АСЕМ”-ын бэлэг дурсгалын зүйлийн жагсаалтад Монголын түүхтэй Англи хэлээр бичсэн ном, альбомыг оруул” гэсэн үүрэг өгсний дагуу худалдан авалт хийжээ.

Нийт бэлэг дурсгалын зардлын гүйцэтгэлийг нотлох баримтаар тулган шалгахад нэмэлтээр батлуулсан төсөв байхгүй, *шууд* захиалан худалдан авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹³-д гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Мөн гадаадын зочин төлөөлөгчид 1 хүнд 0.1-6.7 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл гардуулсан нь ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ын 2.3¹⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

2.1.8 “АСЕМ”-ыг МУ-д зохион байгуулах ажлыг идэвхтэй, зохион байгуулсан ажлын хэсэг, ажилтнуудад зориулсан “Талархлын хүлээн авалт”-ын зардалд 393.0 сая төгрөг, алтан мөнгөн талархлын бичгийн үнэнд 16.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁵-дэх заалттай нийцэхгүй байна.

2.1.9 “АСЕМ”-ын БАА-ны хүрээнд батлагдсан төсвийг зарцуулахдаа ҮАБЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны 63/37 дугаар зөвлөмж /Ц.Элбэгдорж, З.Энхболд, Ч.Сайханбилэг/ 2016 оны 03 дугаар сарын 10-ны 4/77 дугаар албан бичиг /ҮАБЗ-ын нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшин/-ээр ГХЯ-д ирүүлсэн чиглэлийн дагуу 12.4 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчтэй *шууд* гэрээ байгуулсан байна.

“АСЕМ”-ын сургалт зохион байгуулсан байгууллагууд ажлаа тайлагнасан боловч зарцуулсан хөрөнгийн тайлан гаргаагүй, зарцуулалт нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна.

¹³ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

¹⁴ “Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд албан ёсны айлчлалаас бусад үед гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянга, УИХ-ын дарга, Ерөнхий сайдаас 80.0 мянга”, 2.4-т “Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 65.0 мянган төгрөгөөс ... тус тус илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор ...”

¹⁵ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”



Үндсэн мэдээлэл

“АСЕМ”-ын бэлтгэл, үйл ажиллагааны хүрээнд 2015-2016 онд “АСЕМ”-ийн БАА-ны төсвөөс гадаадад болон дотоодын сургалтуудыг зохион байгуулахад 347.1 сая, ХЭДС-аас 25.2 сая, Засгийн газрын нөөц сангаас 350.1 сая төгрөг, нийт 722.4 сая төгрөгийг зарцуулжээ.

“АСЕМ”-ын байр, зочид буудлын асуудал хариуцсан ажлын хэсэг Ерөнхийлөгчийн Тамгын газар /дарга П.Цагаан/ болон Хөдөлмөрийн яам /Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан/ нар 2015 оны 11 дүгээр сарын 13-нд “АСЕМ”-ын зочид, төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлын үйлчилгээний ажилтнуудыг ажлын байранд мэргэшүүлэх, шинээр ажлын байр бий болгох, мэргэжлийн ур чадвар олгох, сургалтыг хоол үйлдвэрлэл, тогооч, талх, нарийн боов, зочид буудлын үйлчилгээний ажилтан /хаалгач, авто зогсоолын ажилтан, ачаа зөөгч, зочин угтагч, зочин хүлээн авагч, өрөөний үйлчлэгч, нийтийн талбайн үйлчлэгч, угаалгын ажилтан, зөөгч, баармен, хөтөч, тайлбарлагч/-г бэлтгэх зорилгоор хамтран ажиллах санамж бичгийг байгуулжээ.

Дээрх хамтран ажиллах санамж бичгийн дагуу “АСЕМ”-ын зочид, төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлын үйлчилгээний ажилтнуудыг ажлын байранд мэргэшүүлэх, ажилгүй иргэдэд мэргэжлийн сургалт явуулж, шинээр ажлын байр бий болгох зорилгоор Хөдөлмөрийн яамны ТНБД /Р.Эрдэнэбүрэн/ болон ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга /Д.Ганхуяг/ нар 370.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Гэрээний гүйцэтгэлээр ГХЯ-аас 2015 онд 74.2 сая, 2016 онд 222.1 сая төгрөг, ХЭДС-аас 2017 онд 25.2 сая төгрөг, нийт 321.5 сая төгрөгийг олгосон байна.

Дээрх санамж бичгийн хүрээнд “АСЕМ”-ын БАА 23 гүйцэтгэгчтэй зочин хүлээн авагч, зөөгч баармен, өрөөний үйлчлэгч тогооч, нарийн боовчин, нийтийн талбайн үйлчлэгч, угаалгын ажилтан бэлтгэх чиглэлээр “Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах тухай гэрээ”-г байгуулж 279.2 сая төгрөгийг санхүүжүүлжээ.

2.1.10 Хамтран ажиллах санамж бичгийн 4.3-т “*санамж бичгийн хэрэгжилтийг ХС-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүгнэнэ*” гэж заасан боловч тус ажил хийгдээгүй, тус санамж бичгийн хүрээнд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээт ажлын нийт үр дүнгийн талаарх мэдээлэл байхгүй байна.

2.1.11 “Монголын зочид буудлуудын холбоо” ТББ 104.1 сая төгрөгийн гэрээт ажил хийж гүйцэтгэсэн нь сургалтын нийт зардлын 37 хувийг эзэлж байна. ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА /дарга Д.Ганхуяг/, “Монголын Зочид буудлын холбоо” ТББ /тэргүүн С.Мөнхбат/ нь 2015 оны 12 дугаар сарын 18-нд сургагч багш бэлтгэх сургалт явуулахаар 28.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилт авсан боловч хийж гүйцэтгэсэн ажлыг аудитын явцад тулгахад анхан шатны баримт үнэн биш байх магадлалтай байна.

- “Гүүд моторс” ХХК нь хуучин япон сэлбэг худалдаа эрхэлдэг атал тус компанийн тамгатай зарлагын баримт дээр 3.5 сая төгрөгийн хүнсний ногоо худалдан авсан гэсэн,
- “Монгол материал экспо” гэсэн тамгатай зарлагын баримт дээр 12.1 сая төгрөгийн цэвэрлэгээний материал худалдан авсан гэжээ.

2.1.12 ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА /дарга Д.Ганхуяг/, “Монголын зочлох үйлчилгээний холбоо” ТББ /тэргүүн Д.Дэвшил/ нар 2015 оны 12 дугаар сарын 18-нд 29.2 сая төгрөгийн мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах 15/001



дугаартай гэрээ байгуулсан боловч нийт гэрээт ажлын 35.3 хувь буюу 10.3 сая төгрөгийг завсарлагааны цай кофенд зарцуулсан нь бусад ижил үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэгч байгууллагуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь доорх баримтаар нотлогдож байна.

Зураг 6

СУРГАГЧ БАГШ НАРЫН СУРГАЛТЫН ЗАРДЛУУД			
2016.02.03			
Зардлууд	Тоо хэм	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Хүнсний түүхий эд материал	115	60,000.00	3,450,000.00
Цэвэрлэгээний материал	200		12,120,000.00
Багш нарын төлбөр	140	34,000.00	4,760,000.00
ХАОАТ		476,000.00	476,000.00
Утасны нэгж	2	5,000.00	10,000.00
Цай кофены завсарлага	3200		2,794,000.00
Цай кофены завсарлага	200	2,500.00	500,000.00
Сургалтын хөтөлбөр			
Боловсруулах төлбөрт	30	50,000.00	1,500,000.00
Бичгийн хэрэгслэл	200	12,000.00	2,390,000.00
Нийт дүн			28,000,000.00

Нябо
Нэгтгэсэн менежер: Г.Ганзориг
Г.Ундрал

Зураг 7

ЗОЧИД БУУДЛУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДЫН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН НЭГТГЭЛ			
2016.03.30			
№	Зардлууд	Тоо хэм	Нийт дүн
1	Хүнсний түүхий эд материал		1,308,343.80
2	нарийн ногоо	53	840,300.00
3	Мах махан бүтээгдэхүүн	53	3,210,000.00
4	Утасны төлбөр	2	20,000.00
5	Цэвэрлэгээний бодис	40	2,477,904.00
6	Цэвэрлэгээний багаж хэрэгслэл	40	301,200.00
7	Угаалгын бодис материал	40	2,189,150.00
8	Бичиг хэргийн зардал	290	847,160.00
9	Завсарлагааны цай кофе сандвич	2829	10,314,600.00
10	Байрны түрээсийн төлбөрт 11 танхим, 2 лаборатор	585м2	4,095,000.00
11	Багш нарын хөлс/ 1 хүний 450000/	8	3,240,000.00
12	ХАОАТ	8	360,000.00
	Нийт дүн		29,203,657.80

Нэгтгэл гаргасан: Менежер М.Санаажуу
Хянасан: Нягтлан Г.Ганзориг

2.1.13 “АСЕМ”-д ажиллах хөтөч, орчуулагч бүртгэх үйл ажиллагаанд 24.7 сая төгрөгийн төсвийг /ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг/ баталсан боловч гүйцэтгэлээр 44.3 сая төгрөг зарцуулж, 19.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Нийслэлийн Хөдөлмөрийн газар санамж бичгийн хүрээнд “АСЕМ”-ын зочид, төлөөлөгчдөд хөтөч, тайлбарлагч хийх хүсэлтэй иргэдийг бүртгэх ажлыг 2016 оны 01 дүгээр сарын 06-16-ны өдрүүдэд бүртгэлийн ажлыг зохион байгуулж 4.8 сая төгрөгийн санхүүжилт авчээ.

Бүртгэлийг тус газрын байранд зохион байгуулсан, гэрээгээр 20 оюутан залуучууд, “Хөтөч тайлбарлагчдын нэгдсэн холбоо” ТББ-ын 11 багш нарыг ажиллуулан 2,415 сайн дурынхныг бүртгэн, бүртгэлийг нэгтгэн мэдээллийн санг үүсгэн “Монголын хөтөч тайлбарлагчдын нэгдсэн холбоо” ТББ-д нэгтгэлийн хүснэгт болон бүртгэлийн анкетыг хүлээлгэн өгсөн гэж тайлагнажээ.

Гэтэл “Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо” нь 2016 оны 1 дүгээр сарын 06-нд “АСЕМ”-ын БАА болон НХГ-ын холбогдох хүмүүстэй уулзаж “АСЕМ”-ын уулзалтын үеэр ажиллах сайн дурын ажилтан, хөтчийг сонгон шалгаруулж бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхээр аман байдлаар тохиролцсон байна.

Дээрх ажлын хүрээнд “Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо” 2016 оны 01 дүгээр сарын 06-25-ны хооронд тус холбооны үндсэн сургагч 22 багш, гэрээт сургагч 4 багш, 7 туслах ажилтан, нийт 33 хүн 18 өдөр ажиллаж, 2,530 сайн дурынхны анкет, материалыг хүлээн аван ярилцлага зохион байгуулж англи, орос, герман, франц, хятад, япон, солонгос, итали, испани зэрэг гадаад орны 9 хэлээр тухайн оролцогчийн ерөнхий мэдлэгийн түвшнийг тогтоож, мэдээллийн сан бүрдүүлэхэд 12.5 сая төгрөгийн зардал гаргасан гэж нэхэмжилсэн байна.

Энэхүү санхүүжилтийг ХЯ-ны ТНБД /Ю.Идэрцогт /-ын 2016 оны 04 дүгээр сарын 11-ны 2/984 дүгээр албан бичгийн дагуу 370.4 сая төгрөгийн үндсэн төлбөрөөс /төсөвлөгдөөгүй/ 12.5 сая төгрөгийг гэрээгүйгээр ГХЯ олгосон байна.



Аудитаар тухайн ажлын гүйцэтгэлийг хүлээн аваагүй, энэхүү сонгон шалгаруулалтаас мэдээллийн сан бүрдсэн эсэх, бүртгэгдсэн хүмүүсийг "АСЕМ"-ын үйл ажиллагаанд оролцуулсан эсэх гэх мэт мэдээ, тайлан, судалгаа байхгүй байгааг тогтоолоо.

Мөн "Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо" нь бүртгэл хийсэн 1 багшийн 1 өдрийн хөлсөнд 50.0 мянган төгрөг, хоолны үнэнд 8.0 мянган төгрөг, нийт 12.2 сая төгрөгийг олгосон гэсэн боловч эдгээрийг тогтоосон эрх зүйн үндэслэл, хянаж зөвшөөрсөн шийдвэргүй байна.

2.1.14 "АСЕМ"-ын БАА-ны төсвөөс тус яамны ажилтнуудад нийт 24.2 сая төгрөгийн сургалт явуулсан нь "АСЕМ"-ын бэлтгэл ажлын батлагдсан сургалтын төлөвлөгөө гэж байхгүйгээс энэхүү сургалтуудын санхүүжилтийг ГХЯ-ны урсгал зардлаас бус "АСЕМ"-ын урсгал зардлаас санхүүжүүлсэн байна. Үүнд:

- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны А/29 дугаар тушаалын дагуу "Дипломат ажилтнуудын илтгэл боловсруулах ур чадварыг дээшлүүлэх нь" сэдэвт сургалтыг 2015 оны 05 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд тус яамны дипломат ажилтны илтгэл боловсруулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж сургалтын зардалд гадаад улсын 2 багшид сургалтын төлбөр болон томилолт, зочид буудлын зардалд 22.2 сая төгрөг /5480¹⁶ фунт стерлинг, 6.0 сая төгрөг/, сургалтын бичиг хэрэг, цайны завсарлагын зардалд 500.0 мянган төгрөг, нийт 22.7 сая төгрөг;
- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 10 дугаар сарын 14-ны А/84 дүгээр тушаалын дагуу ГХЯ-ны Дипломат Академиас "АСЕМ"-ын БАА-ны 25 ажилтанд зориулан 2015 оны 10 дугаар сарын 15-16-ны өдөр сургалт зохион байгуулахад багшийн цалин, гарын авлага, дурсгалын ном, дэвтэр, цайны зардалд 557.0 мянган төгрөг;
- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 03-ны А/100 дугаар тушаалын дагуу 2015 оны 11 дүгээр сарын 06-20-ны өдрүүдэд "Хэлмэрчдийн онол арга зүй" сэдэвт 16 цагийн сургалтад 17 дипломат ажилтнууд хамрагдаж, багшийн цалинд 800.0 мянган төгрөг, сургалтын материалд 100.0 мянган төгрөг, нийт 900.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

2.1.15 ГХЯ-аас дараах шийдвэрүүдийн дагуу гадаадын 4 улсад зохион байгуулагдсан сургалтад 16 албан тушаалтан хамрагдаж, нислэгийн тийз, байр, харилцаа холбоонд 20.0 сая төгрөг болон 2,600¹⁷ ам.доллар буюу 5.7 сая төгрөг, нийт 25.7 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний А/105 дугаар тушаалын дагуу 2015 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд "Хүнсний аюулгүй байдлын стандарт чиглэлээр хамтын ажиллагаа, уялдаа холбоог дэмжих нь" сэдэвт семинарт НМХГ-ын дарга Л.Эрдэнэчулуун оролцож, 1.6 сая төгрөгийн нислэгийн тийзийн зардал;
- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 27-ны А/132 дугаар тушаалын дагуу "АСЕМ"-ын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Сингапур Улсын Дотоод хэргийн академийн 2015 оны 12 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтад нэр бүхий 12 албан тушаалтан оролцож, 17.6 сая төгрөгийн тийзийн зардал;
- ГХЯ-ны ТНБД-ын 2016 оны 02 дугаар сарын 25-ны А/36 дугаар тушаалын дагуу Европын Холбооноос "АСЕМ"-ын бэлтгэл ажлын хүрээнд 2016 оны 3 дугаар

¹⁶ Монголбанкны ханш 2015.12.31-ний ханш 2,958.14

¹⁷ Монголбанкны ханш-2489.53



сарын 7-11-ний өдрүүдэд Брюссель хотноо зохион байгуулах сургалтад Олон талт хамтын ажиллагааны газрын зөвлөх Ш.Ренчинмядаг оролцож, 893.3 мянган төгрөг, 1,400 ам доллар буюу 3.5 сая төгрөгийн замын зардал,

- ГХЯ-ны ТНБД-ын 03 дугаар сарын 23-ны А/70 дугаар тушаалын дагуу БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага "КОИСА"-гийн сургалтад "АСЕМ"-ийн БАА-ны мэргэжилтэн Г.Төмөрхүү, Д.Амарболд нар 2016 оны 3 дугаар сарын 28-аас 4 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хамрагдаж, нийт 1,200 ам.доллар буюу 3.0 сая төгрөгийн зам хоногийн зардал.

2.1.16 2015-2016 онд Монголын талаас сургалтын зардлыг гаргаагүйгээр сургалтад дараах ажилтнууд хамрагдсан байна. Үүнд:

- ГХЯ-ны ТНБД-ын 2015 оны 12 дугаар сарын 17-ны А/163 дугаар тушаалын дагуу Тайландын Олон Улсын Хамтын ажиллагааны Агентлаг "Тайка"-ын бүрэн дэмжлэгтэйгээр Тайландын ГХЯ-нд Дээд түвшний зочин хүлээн авах сургалтад 10 албан тушаалтныг оролцуулжээ.
- ГХЯ-ны ТНБД-ын 2016 оны 02 дугаар сарын 25-ны А/36 дугаар тушаалын дагуу Европын Холбооноос "АСЕМ"-ын бэлтгэл ажлын хүрээнд 2016 оны 3 дугаар сарын 7-11-ний өдрүүдэд Брюссель хотноо зохион байгуулсан сургалтад Олон талт хамтын ажиллагааны газрын зөвлөх Ш.Ренчинмядаг оролцсон байна. /замын зардлаас бусад зардлыг сургалт зохион байгуулагч хариуцсан/,
- "АСЕМ"-ын уулзалтад англи хэлээр "синхрон" орчуулга хийх орчуулагчдыг Европын Холбооны орчуулгын ерөнхий газартай хамтран сонгон шалгаруулж, Бельгийн Вант Улсад хэлмэрчийн мэргэшил дээшлүүлэх чиглэлээр 2015 оны 11 дүгээр сарын 03-аас 2016 оны 9 дүгээр сарын 01-нийг хүртэл 5 сарын хугацаатай 5 орчуулагчтай хэлмэрчийн сургалтад хамрагдах сургалтын гэрээ байгуулж, суралцуулсан байна. /суралцагчийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалж суралцуулсан./

2.1.17 ЗГ-ын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны 427 дугаар тогтоолоор "АСЕМ"-ын уулзалтад оролцох төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын албан хаагчдын дунд нэгдсэн сургалт зохион байгуулах, уг сургалтад ашиглах техник хэрэгслийг худалдан авахад шаардагдах 374.3 сая төгрөгийг ЗГ-ын нөөц сангаас шийдвэрлэсний дагуу 350.1 сая төгрөгийг зарцуулжээ.

БХЯ-аас хариуцан зохион байгуулсан "Нүүдэлчдийн наадам" арга хэмжээнд ихээхэн хэмжээний ус, ундаа, архи, шар айраг, зарцуулсан байна.

Үндсэн мэдээлэл

ҮЗ-ийн 2016 оны 02 дугаар сарын 17-ны 15 дугаар хурлаар "АСЕМ"-ын уулзалтад оролцох зочид төлөөлөгчдөд зориулан бэсрэг наадмыг Ерөнхий сайд С Ч.Сайханбилэг "Чингисийн хүрээ" жуулчны баазад зохион байгуулах санал гаргасан ба ҮЗ-ийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны 29 дүгээр хуралдаанаар "АСЕМ"-ын уулзалтад оролцох зочид, төлөөлөгчдөд зориулсан **"Нүүдэлчдийн наадам"**-ын арга хэмжээний төсвийг 1.9 тэрбум төгрөгөөр баталжээ.

Дээрх хуралдааны шийдвэрийн дагуу 2016 оны 06 дугаар сарын 14-нд ГХЯ-ны ТНБД, "АСЕМ"-ын БАА-ын дарга Д.Ганхуяг, БХЯ-ны ТНБД, "АСЕМ"-ын дэд ажлын хэсгийн ахлагч Б.Батсайхан нар харилцан тохиролцон "Нүүдэлчдийн наадам"-ын арга хэмжээг 738.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн байна.



2.1.18 БХЯ “Нүүдэлчдийн наадам”-ын арга хэмжээг зохион байгуулахад **796.8** сая төгрөгийн зардал гарсан ба 14 иргэн, хуулийн этгээдтэй *шууд гэрээ* байгуулан зарцуулжээ.

2.1.19 Дээрх зардлаас БХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын дэд ажлын хэсгийн ахлагч Б.Батсайхан, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дарга Ш.Одончимэг нар 2016 оны 06 дугаар сарын 21-нд “Нүүдэлчдийн наадам”-ын арга хэмжээний 2,500 хүний зоогийн үйлчилгээ, хүлээн авалт, наадмын талбайг бэлтгэх, цахилгаан хангамжийн кабель татах ажлын 398.3 сая төгрөгийн төсөвтэй 16/2171 дугаар гэрээг байгуулан туслан гүйцэтгэгчээр дараах байгууллагатай хамтран ажилласан боловч энэхүү хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө, материалын нэгтгэсэн судалгаа, тайлан гаргаагүйгээс зарим хөрөнгө эзэмшлийн хувьд тодорхойгүй байна.Үүнд:

- Тус гэрээний ажлын хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний “Улаанбаатар нэгтгэл” ОНӨҮГ-д “Чингисийн хүрээ” жуулчны баазын талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламж, усалгаа, зөөврийн био “00” ажиллуулах, хогийн сав, амралтын сандал, зөөврийн бункер, хулдаасан хэвлэл байршуулах, газар шорооны ажилд 19.1 сая;
- “Чингисийн хүрээ” жуулчны баазад 3 төрлийн 137 ширхэг асар, 5 төрлийн хэмжээтэй 255 ширхэг ширээ түрээслэх мөн асруудыг хаягжуулах ажлыг зохион байгуулах зорилгоор “Ганаа майхан” ХХК-д 41.0 сая;
- “УСУГ” ОНӨҮГ-д “Нүүдэлчдийн наадам” арга хэмжээний хоол бэлтгэх цэвэр ус тээвэрлэх зардалд 504.8 мянган төгрөг;
- “УБЦТС” ТӨХК-д 22.9 сая төгрөгийн цахилгаан хангамжийн кабель татах, тулгуур солих, шинээр гадна шит суурилуулах ажлыг хийлгэсэн бөгөөд хийгдсэн ажлууд “Чингисийн хүрээ” жуулчны баазад үлдсэн байна.

2.1.20 БХЯ болон Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар 398.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч шинээр жааз хөгжим тоглох, тайз засах, үзүүлэнгийн гэр барих ажлууд нэмэгдэн 27.6 сая төгрөгийг зарцуулснаар нийт 425.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.1.21 “Нүүдэлчдийн наадам” арга хэмжээнд зарцуулсан зардлыг эзлэх хувийн жингээр авч үзвэл: “Нүүдэлчдийн наадам” арга хэмжээнд зарцуулсан нийт зардлын 40 хувь буюу 315.7 сая төгрөг нь хоол, ус, архи, шар айргийн үнэ болон сүүдрэвчний түрээсийн төлбөр байгаа ба эдгээрийг “Арвайн үндэс” ХХК, “СББ” ХХК, “Чингис шар айраг” ХХК, “М-Си-Эс Кока-Кола” ХХК, “Жем Трейд” ХХК, “Ноён Уул Эрдэнэ” ХХК-аас тус тус худалдан авсан боловч гүйцэтгэлийг 500 зочид төлөөлөгчдөд харьцуулахад 1 хүнд архи 1.1 л, ундаа 9.6 л, ус 5.5 л, шар айраг 25.1 л байхаар тооцоо гарч байгаа нь төсвийг бодитой биш, үндэслэл муутай төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 4

Бүтээгдэхүүний судалгаа

№	Бүтээгдэхүүний төрөл	Нийт тоо	Нийт литр	Нийт үнэ	Нийт 500 хүн, 1 хүнд ногдох хэмжээ литр
1	Цэвэр ус	5,260.0	2,774.8	2,068.0	5.5
2	Архи	919.1	573.6	13,977.3	1.1
3	Шар айраг	6,771.3	12,570.0	17,360.0	25.1
4	Жүүс	2,350.0	425.0	1,855.0	0.9
5	Цай	1,350.0	-	863.6	0.0
6	Ундаа	3,287.0	4,787.1	1,520.0	9.6
7	Дарс	2,138.0	903.7	5,797.8	1.8
8	Мөс	40.0	-	126.0	0.0
	Нийт үнэ	22,115.4	22,034.2	43,567.7	

Эх сурвалж: БХЯ-ны зарцуулалтын тайлан



Дээрх судалгаанаас харахад БХЯ болон Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын хооронд байгуулсан 16/2171 дугаар гэрээний хавсралтад ус, уух зүйлд 67.5 сая төгрөгийг төсөвлөсөн байхад БХЯ-ны ТНБД, "АСЕМ"-ын дэд ажлын хэсгийн ахлагч, Б.Батсайхан, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дарга Ш.Одончимэг нар хяналтгүйгээр баталгаажуулсан байна.

2.1.22 "АСЕМ"-ын ҮЗ-ийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр хуралдаанаар уг уулзалтад оролцох зочид, төлөөлөгчдөд зориулсан "Нүүдэлчдийн наадам"-ын арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг хэлэлцэн шийдвэрлэсний дагуу НСУГ-ын даргын 2016 оны 6 дугаар сарын 23-ны А/17 дугаар тушаалаар тайз, хүндэт зочдын суудлын сүүдрэвч бэлтгэх ажлыг "Гэсү" ХХК-аар 166.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр баталжээ.

Дээрх ажлыг гүйцэтгүүлэх 02/23 дугаар гэрээг НСУГ-ын дарга АСЕМ-ын дэд ажлын хэсгийн гишүүн Б.Батцэнгэл, "Гэсү дизайн" ХХК-ийн ерөнхий захирал Г.Ганбаатар нар 2016 оны 06 дугаар сарын 23-нд байгуулан гүйцэтгүүлж, 2016 оны 07 дугаар сарын 27-нд биелэлтийг 100 хувь гүйцэтгэсэн гэсэн актыг НСУГ-ын дарга Б.Батцэнгэл, "Гэсү" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Хонгорзул нар үйлдэн ажил хүлээлцсэн байна. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэлээр тайз, сүүдрэвчийг НСУГ хүлээн авсан боловч хөрөнгийг бүртгэлд тусгаагүйгээр зардал болгосон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар "АСЕМ"-тай холбоотойгоор хэрэгжүүлсэн 25.1 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээний зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийг баримтлан ажиллаагүй байна.

2.1.23 2016 оны улсын төсвөөс Зам, тээврийн сайд /хуучин нэрээр/-ын багцад ИНЕГ-т "АСЕМ"-тай холбоотой 13.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 88 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 43 нэр төрлийн 7,545.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдаж, 6,993.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнээс орон нутгийн нисэх буудлуудад 1,466.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны 99 дүгээр тушаалаар өөрийн хөрөнгөөр "АСЕМ"-д зориулж 19,579.8 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 19,570.3 сая төгрөгийн ажлыг гэрээлэн 18,134.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- ИНЕГ "АСЕМ"-ын уулзалтын аюулгүй байдлыг хангах зориулалтаар хэрэгжсэн нийт 47 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ҮАБЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны 63/37 дугаар "Зөвлөмж"-ийн 3.5.7¹⁸ дахь заалт, ЗГ-ын 2016 оны 349 дугаар тогтоолыг үндэслэн 9 төсөл, арга хэмжээнд *шууд* гэрээ байгуулсан байна.
- Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.4.1¹⁹-д заасныг зөрчиж гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй, мөн хуулийн 47.1²⁰-д заасан төсөвт өртгөөс давсан төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулаагүй ажлын хэсэг байгуулсан, ажлын хэсэг нь *шууд* гэрээ байгуулахаар шийдвэр гаргахдаа мөн хуулийн 34.3²¹-т заасан дагуу СЯ-д энэ тухай мэдэгдээгүй байна. *Тухайлбал,*

¹⁸ 3.5.7. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.4 дүгээр заалтыг үндэслэн шаардлагатай материал, техник хэрэгслэл, тоног төхөөрөмж, болон төлөөлөгчдөд үйлчлэх унаа, тээврийн хэрэгслийг нийлүүлэх компанийг сонгож шууд гэрээ байгуулах;

¹⁹ 43.4.1.150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах;

²⁰ 47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна;

²¹ 34.3.Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



- “Чингис хаан” олон улсын нисэх буудлын зорчигч үйлчилгээний танхимуудын өргөтгөл засвар, техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “ажлын хэсэг” байгуулж “Анхууш” ХХК-тай 1.8 тэрбум төгрөгийн “ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Мөн “Анхууш” ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй;
 - “Чингис хаан” олон улсын нисэх буудлын перроны өргөтгөлийн ажлын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “ажлын хэсэг” байгуулж “Рэс” ХХК-тай 7.1 тэрбум төгрөгийн “ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Мөн “Рэс” ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй;
 - “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын 500 метр бетон хэсгийн хүчитгэлийн ажлын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “ажлын хэсэг” байгуулж “Дагшин харгуй” ХХК-тай 2.4 тэрбум төгрөгийн “ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Мөн “Дагшин харгуй” ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй;
 - “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын явгалах замуудын хүчитгэлийн ажлын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “ажлын хэсэг” байгуулж “Бадрах ойл” ХХК-тай 8.0 тэрбум төгрөгийн “ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Мөн “Бадрах ойл” ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй.
- ТБОНӨХБАҮХАТХ-д заасан төсөвт өртгөөс давсан 2 төсөл, арга хэмжээнд “үнэлгээний хороо” байгуулалгүй худалдах худалдан авах гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.1 ба 34.1.5²²дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,
 - Технологийн зориулалттай дунд оврын автобус /25 хүний суудалтай/ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “Хьюндай Моторс Монгол” ХХК-тай 390.0 сая төгрөгийн “худалдах худалдан авах гэрээ” байгуулж, 3 ширхэг автомашин;
 - Агаарын хөлгийн хөтлөх зориулалтын авто машин /2 ширхэг/ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй “Хьюндай Моторс Монгол” ХХК-тай 128.0 сая төгрөгийн “худалдах худалдан авах гэрээ” байгуулж, 2 ширхэг автомашин.
 - Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу зохион байгуулж тендер зарласан ч мөн хуулийн 47.2.2²³-т заасныг зөрчиж Үнэлгээний хорооны шийдвэргүйгээр гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн байна. Тухайлбал,
 - Нар, дизель хосолсон холимог тэжээлийн системийн инвертер нийлүүлэх /4 ширхэг/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 2 удаа нээлттэй тендер зарлаж шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул 4 компанид саналын урилга хүргүүлж, тухайн компаниудаас хариу ирээгүй байхад үнэлгээний хорооны шийдвэргүйгээр “Гранд Океанос” ХХК-тай 78.0 сая төгрөгийн “бараа нийлүүлэх гэрээ” байгуулж;
 - Хөшгийн хөндийн олон улсын шинэ Нисэх буудлын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байранд PABX-ийн дэд станц нийлүүлэх, суурилуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 2 удаа нээлттэй тендер зарлаж шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул Техник хангалт, навигацийн үйлчилгээний албанд тухайн ажлыг хэрэгжүүлэх чадавхтай байгууллагуудын талаар мэдээлэл хүсэж, уг мэдээллийн дагуу “Нью телеком” ХХК-ийг санал болгосноор үнэлгээний хорооны шийдвэргүйгээр 150.0 сая төгрөгийн гэрээ байгуулж;
 - Технологийн зориулалтын туулах чадвар бүхий автомашин /2 ширхэг/ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 2 удаа нээлттэй тендер зарлаж, шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул “Моннис моторс” ХХК-тай 137.8 сая төгрөгийн “бараа нийлүүлэх гэрээ” байгуулж үнэлгээний хорооны шийдвэргүй.

²² 34.1.5.гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

²³ 47.2.2. “Үнэлгээний хороо” тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх.



2.1.24 Улсын төсвийн 537.0 сая төгрөгөөр УАЗ 220695-04 маркийн 20ш фургон машиныг ИНЕГ авсан бөгөөд 2017 оны 01 дүгээр сард Говь-Алтай, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Завхан аймгийн Нисэх буудалд 5-г хуваарилсан байна. Харин 2017 оны 03 дугаар сард Ховд, Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгооны төвд, Баян-Өлгий, Өмнөговь, Баянхонгор аймгийн сумын эмнэлэгт, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт, Говь Алтай, Төв аймгийн ЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний төвд тус бүр 1, нийт 214.8 сая төгрөгийн 8 фургон автомашиныг зохих эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үнэ төлбөргүй шилжүүлсэн тул зөрчлийг арилгах **албан шаардлага** өглөө.

ХЗЯ “АСЕМ”-тай холбоотой хийгдсэн зарим үйл ажиллагаанд зохих хуулийг баримтлан ажиллаагүй байна.

2.1.25 ЦЕГ “АСЕМ”-д оролцох зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд “Хэт моторс” ХХК-аас нийлүүлэгдсэн нэг бүр нь 64.1 сая төгрөгийн үнэтэй нийт 3,337.2 сая төгрөгийн үнэ бүхий 52 ширхэг “Тоёота приус-30” маркийн суудлын автомашиныг “АСЕМ”-ын БАА-аас 2016 оны 06 дугаар сарын 30-нд /352 дугаар орлогын баримт/ хүлээн авсан байна.

СЯ-ны ТНБД /Х.Ганцогт/-ын 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” 13-2/3528 дугаар албан бичгийг үндэслэн ЦЕГ-ын дарга /Р.Чингис/-ын 2016 оны 05 дугаар сарын 16-ны Б/249 дугаар тушаалаар хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

ЦЕГ-ын дарга /Р.Чингис/-ын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны Б/645 дугаар тушаалаар 29 автомашиныг орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэст, 23 автомашин харьяа газар, салбар нэгжүүдэд хуваарилан шилжүүлж, хөрөнгийг бүртгэлд тусгуулсан байна.

2.1.26 “АСЕМ”-ын үеэр мэдээлэл холбооны системийн эрсдэлгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс “Мэдээлэл, шуурхай удирдлагын төв”-ийн серверийн өрөө, мэдээлэл, холбооны тулгуур цэгүүдийн техникийн өрөөний хөргөлтийн систем, төхөөрөмжүүдийг шинэчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 173.0 сая төгрөгийн үнийн дүнтэй 05/206-ТХ-47 дугаар гэрээг 2016 оны 06 дугаар сарын 06-нд ГХЯ-ны ТНБД Д.Ганхуяг, ЦЕГ-ын дарга Р.Чингис нар байгуулжээ.

Гэрээний дагуу ГХЯ-аас 2016 оны 06 дугаар сарын 16-нд ЦЕГ-т 173.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. ТЕГ-ын Тамгын газар /дарга Б.Доньжчимбуу/-ын 2016 оны 06 дугаар сарын 22-ны 01/1323 дугаар албан бичгээр “10НР” хөргөлтийн тоног төхөөрөмж нь ЗГ-ын 2001 оны 122 дугаар тогтоолоор баталсан тусгай зориулалтын тоног төхөөрөмжид хамаарч байгаа тул *шууд* худалдан авалт хийх нь зүйтэй гэсний дагуу “Мэдээлэл, шуурхай удирдлагын төв”-ийн дарга Н.Амарзаяа 2016 оны 06 дугаар сарын 27-ны А/16 дугаар тушаалаар тус төвийн серверийн өрөө, мэдээлэл, холбооны тулгуур цэгүүдийн техникийн өрөөний хөргөлтийн систем, төхөөрөмжүүдийг худалдан авах, угсрах ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /дарга Н.Амарзаяа/, “Синус-дочи” ХХК /захирал Т.Олзбаатар/ нар 2016 оны 06 дугаар сарын 28-нд 147 дугаар гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу “Мэдээлэл, шуурхай удирдлагын төв”-өөс 69.2 сая төгрөгийг “Синус дочи” ХХК-д шилжүүлж, 2016 оны 09 дүгээр сарын 20-нд хүлээн авсан байна.



2.1.27 ЦЕГ-ын шуурхай удирдлагын штабын өрөөг засварлахад 3.3 сая төгрөгийн үнийн дүнтэй дугаарлаагүй гэрээг 2016 оны 06 дугаар сарын 21-нд байгуулж ЦЕГ-ын Санхүү хангамжийн газрын дарга Д.Амарсайхан, "Алтан бийр цац" ХХК-ийн захирал Л.Баяраа нар байгуулж, төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.

Засварын ажлыг хийж гүйцэтгэсэн тайлан, гэрээ дүгнэсэн, ажил хүлэлцсэн тухай ямар нэгэн акт баримт байхгүй байгаа нь Төсвийн тухай 41 дүгээр зүйлийн 41.2.3²⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

2.1.28 "АСЕМ"-д оролцох зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд нэгдсэн удирдлагын штабт шаардагдах 35.6 сая төгрөгийн хөрөнгийг ЦЕГ-ын даргын 2016 оны 06 дугаар сарын 24-ний Б/332 дугаар тушаалаар шийдвэрлэж шууд худалдан авалтаар "Долоон болдог" ХХК болон "Эй и Кэй" ХХК-аас 2016 оны 06 дугаар сарын 26-нд 14.5 сая төгрөгөөр тавилга, ширээ сандал авч бүртгэлд тусгасан байна.

2.1.29 "АСЕМ"-ын хамгаалалтад ажилласан цагдаагийн албан хаагчдын хоолны зардалд "Номадс Хоспиталити" ХХК-аас 2016 оны 07 дугаар сарын 08-нд бэлнээр 66.0 сая төгрөг авч хамгаалалтад ажилласан гэх цагдаагийн 83 байгууллагын 4600 гаруй албан хаагчдад 1 хүнд 1 өдөрт 5,000 төгрөгөөр тооцож, нийт 59.8 сая төгрөгийг жагсаалтаар олгон, 6.2 сая төгрөгийн татварыг суутган ЧД-ийн Татварын хэлтэст шилжүүлсэн байна.

2.1.30 Цагдаагийн хамгаалалтад ажилласан автомашинд зориулж 2016 оны 07 дугаар сарын 14-нд "АСЕМ"-ын БАА /ажилтан Б.Жавхлан/-аас "АСЕМ"-ын хандивын бензиний 9.5 сая төгрөгийн талон, шатахууны картаар 6.0 сая төгрөг болон дансаар 29.5 сая төгрөгийн шатахууны санхүүжилт авч хамгаалалтад ажилласан 500 гаруй автомашинд олгосон байна.

2.1.31 ХХЕГ "АСЕМ"-ын төсвөөс шатахууны зардалд 8.4 сая, "Номадс Хоспиталити" ХХК-аас хоолны зардалд 8.0 сая, нийт 16.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба ХХЕГ-ын 2016 оны урсгал төсвөөс "АСЕМ"-ын уулзалтын үеэр "Жаргалантын ам"-ны онгоц хөөрөх буух зурвасыг хамгаалахад 22 автомашины шатахууны зардалд 6.2 сая, хоол хүнсний материал, хоол боловсруулах зардалд 3.0 сая, нийт 9.2 сая төгрөгийг зарцуулж, нийт 25.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

Тагнуулын ерөнхий газар ЗГ-ын тогтоолоор автомашин техник хэрэгслийг худалдан авсан байна.

ТагЕГ нь "АСЕМ"-ын үйл ажиллагаатай холбоотойгоор 6.5 тэрбум төгрөгийн автомашин, 1.8 тэрбум төгрөгийн тоног, төхөөрөмж, 70.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 71.4 сая төгрөгийн техник хэрэгсэл, 1.1 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, нийт 9.5 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

ТТХГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.5 тэрбум, урсгал төсвөөс 138.1 сая, Засгийн газрын нөөц сангаас 350.1 сая, нийт 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулж бүртгэлд тусгасан байна.

Мөн ТТХГ-аас БХЯ-ны Зэвсэгт хүчний 310 дугаар ангид "АСЕМ"-ын уулзалтын хамгаалалтын ажилтнуудын хоол, хүнсэнд 53.4 сая төгрөг, "АСЕМ"-ын уулзалтын хамгаалалтын автомашины шатахууны зардалд 23.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

²⁴ "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"



Эрчим хүчний салбар салбарт “АСЕМ”-тай холбоотойгоор аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 5.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шууд гэрээ байгуулжээ.

Эрчим хүчний салбарт “АСЕМ”-тай холбоотойгоор нийт 5,238.4 сая төгрөгийн хөрөнгийн зардал, 182.1 сая төгрөгийн урсгал зардал гарсан байна.

Хүснэгт 5

Зарцуулсан хөрөнгийн судалгаа

№	Байгууллагын нэр	“АСЕМ”-д гаргасан хөрөнгийн дүн /сая.төг/	АСЕМ”-д гаргасан зардлын дүн /сая.төг/
1	Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК	101.7	
2	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК	441.7	
3	“ДДЦС” ТӨХК	82.9	7.0
4	“ЦДҮС” ТӨХК	353.5	170.0
5	Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК	141.5	
6	“Диспетчерийн үндэсний төв” ХХК	1.0	
7	“УБДС” ТӨХК	414.0	
8	“ЭХХТ” ТӨҮГ		5.1
9	“УБЦТС” ТӨХК	3,702.1	
	НИЙТ ДҮН	5,238.4	182.1

Эх сурвалж: ЭХЯ-аас ирүүлсэн албан бичгийн хавсралт

2.1.32 “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-д ҮАБЗ-ийн ажлын албаны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 5/130 дугаар албан бичиг, ЭХЯ-ны 2016 оны 06 дугаар сарын 22-ны в/1856 дугаар удирдамжийг үндэслэн тус компанийн ТУЗ-ийн 2016 оны 06 дугаар сарын 24-ны 13 дугаар тогтоолоор камерын хяналтын системийг шинэчлэх, рентген хяналтын төхөөрөмж суурилуулах ажлуудын зардлыг 2016 оны хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд тусгажээ.

Хүснэгт 6

Төсөл, арга хэмжээний судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөв /сая.төг/	Гүйцэтгэгч	Гэрээний дүн /сая.төг/	Гэрээний огноо	Гэрээний дугаар
1	Хяналтын рентген төхөөрөмж	40.0	Тамсагийн тал ХХК	33.7	2016.06.28	А-16/78
2	Хяналтын камерын иж бүрэн систем	71.2	Тэргэлтех ХХК	68.0	2016.06.28	А-16/79
	Нийт	111.2		101.7		

Эх сурвалж: ЭХЯ-аас ирүүлсэн албан бичгийн хавсралт

Дээрх төсөл, арга хэмжээг зохион байгуулахдаа үнэлгээний хороо байгуулалгүй, компанийн гүйцэтгэх захирал М.Баянмөнх, Цах-ДХХА цехийн дарга С.Батсайхан, ХААХ-н мэргэжилтэн М.Энхбат нар хэлэлцэж протокол үйлдэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйл, 47 дугаар зүйлд заасныг баримтлалгүй харьцуулалтын аргыг хэрэглэн дээрх 2 гүйцэтгэгчийг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, үнэлгээний хороо байгуулахаас эхлээд тендерийг үнэлэх хүртэлх үйл ажиллагааны ажилбарууд хийгдээгүй тендерийг үнэлж дуусгасан байна.

2.1.33 “Дулааны 4 дугаар цахилгаан станц” ТӨХК нь ҮАБЗ-ийн ажлын албанаас 2016 оны 04 дүгээр сарын 26-нд 5/133 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу тус компанийн ТУЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 20-ны 17, 2016 оны 11 дүгээр сарын 11-



ний 27 дугаар тогтоолоор 2016 оны бизнес төлөвлөгөөнд камерын хяналтын системийн өргөтгөлд 282.0 сая, рентген төхөөрөмж суурилуулахад 160.0 сая төгрөгийг тодотгон баталжээ.

Хүснэгт 7

Төсөл, арга хэмжээний судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөв /сая, төг/	Гүйцэтгэгч	Гэрээний дүн /сая.төг/	Гэрээний огноо	Гэрээний дугаар
1	Гар тээш шалган нэвтрүүлэх 3ш рентген тоног төхөөрөмж, 3ш металл илрүүлэгч нэвтрэх хаалга нийлүүлэх, суурилуулах	159.7	"Ньюспайр" ХХК	159.7	үгүй	СХА-2016/08 ба Д/2016-281
2	Хяналтын камер нийлүүлэх, суурилуулалт	282.0	"Профессионал Нетворк Солюшн" ХХК	282.0	2016.06.21	СХА-2016/08 ба Д/2016-282
Нийт дүн		441.7		441.7		

Эх сурвалж: ЭХЯ-аас ирүүлсэн албан бичгийн хавсралт

"Дулааны 4 дугаар цахилгаан станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ж.Осгонбаатар/-ын 2016 оны 05 дугаар сарын 16-ны А/79 дүгээр тушаалаар "Харуул хамгаалалтын хяналтын камерын сүлжээ систем шинээр нийлүүлэх, суурилуулах" ажилд 7 хүнтэй үнэлгээний хороо байгуулсан байна. Үнэлгээний хорооны 2016 оны 06 дугаар сарын 07-ны хурлаар дараах шалтгаанаар тус 2 компанитай гэрээ байгуулах боломжгүй, хязгаарлагдмал тендерийг дахин зарлах боломжгүй тул шууд гэрээ байгуулах шийдвэр гаргасны дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйл, 27 дугаар зүйлд заасныг хэрхэн баримталж ажилласан нь тодорхойгүй "НЬЮСПАЙР" ХХК-тай гэрээ байгуулсан байна.

- "Хутула" ХХК-ийн ирүүлсэн тендерийн материал шаардлага хангахгүй, тусгай зөвшөөрөлгүй,
- "Гурван-Уул трейд" ХХК өртэй, туршлагагүй, тусгай зөвшөөрөлгүй.

2.1.34 "Цахилгаан түгээх үндэсний сүлжээ" ХК ҮАБЗ-ийн ажлын албанаас 2016 оны 04 дүгээр сарын 26-нд 5/132, 5/138 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, ТагЕГ-ын 2016 оны 04 дүгээр сарын 25-ны 04 дугаар албан шаардлагыг үндэслэн тус компанийн ТУЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 06-ны 21 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн 2016 оны 04 дүгээр сарын 19-ний 10 дугаар тогтоолын хавсралт 1-д "Хангайн бүсийн салбарын барилга" гэснийг "АСЕМ"-ыг зохион байгуулах ажлын хүрээнд аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх ажлын зардал" гэж өөрчлөхөөр шийдвэрлэсэн байна.

Тус компанийн ТУЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 06-ны 22 дугаар тогтоолоор 9 нэрийн ажлын 523.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталж шууд гэрээ байгуулан зохион байгуулсан байна.

"Цахилгаан түгээх үндэсний сүлжээ" ХК 9,571.04 м өргөст тор татах ажилд материалыг худалдан авч өөрсдийн хүчээр хийж нийт 49.5 сая төгрөгийн зардал гаргасан гэсэн нь аудитын явцад ирүүлсэн тайлан, баримтаар бүрэн нотлогдохгүй байна. Мөн "АСЕМ"-тай холбоотой гэж орон нутагт байрлах 4 дэд станцад өргөст торыг өөрсдийн хүчээр хийхэд урсгал зардлаас 23.5 сая төгрөг зарцуулсан гэж тайлагнасан байна.



Монгол хотхоны цахилгаан хангамжид цалингийн зардалд 19.1 сая, шатахууны зардалд 0.4 сая төгрөг зарцуулж цахилгааны монтажны зураг, монтажны ажлыг өөрсдөө хийсэн байна. Мөн нэр бүхий 10 байгууллагад 32.9 сая, нийт 52.4 сая төгрөгийг шилжүүлжээ. Гэвч батлагдсан гүйцэтгэлд 87.9 сая төгрөг гэж гүйцэтгэл бичсэн байна.

2.1.35 “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 06 дугаар сарын 15-ны 17 дугаар тогтоолоор тус компанийн 2016 оны их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны нэмэлт тодотгосон төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд “АСЕМ”-ыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах 100.0 сая төгрөгийн 2 ажлын төсвийг баталсан байна.

- “Хгау” рентген төхөөрөмж, металл илрүүлэгч хаалга худалдан авах, суурилуулахад 79.2 сая,
- Хашааны хамгаалалтын торыг шинэчлэхэд 20.8 сая төгрөг.

Тус компанийн гүйцэтгэх захирал /Д.Чимэддорж/-ын 2016 оны А/168 А/169 дүгээр тогтоолоор харьцуулалтын аргаар ажлын гүйцэтгэгч сонгох комиссыг байгуулж, “И ТИ КБЮКОНСАЛТИНГ” ХХК, “ЭЙНШЭНТКАСТЛ КОНСТРАКШН” ХХК-ийг шалгаруулжээ.

“АСЕМ”-ыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах 49.4 сая төгрөгийн бараа материалыг гэрээгүйгээр худалдан авсан байна.

- “Шангри-Ла” зочид буудлын “Хэвлэлийн төв”-д цахилгааны монтаж хийхэд зориулж “Сартпланет” ХХК-аас 1400м цахилгааны кабель утас авахад 41.3 сая;
- Тохижилтод “Соёолж” ХХК-аас 2 төрлийн 6ш цэцэг, 6 цэцгийн баар авахад 0.7 сая;
- “Нэкс электроникс” ХХК-аас 4ш агаар чийгшүүлэгч авахад 0.4 сая;
- “Арвин шүр” ХХК-аас 10ш цагаан сейф авахад 3.1 сая;
- “Зүүн гурван түмт” ХХК-аас 13 нэр төрлийн цахилгаан, гэрлийн 170ш хэрэгсэл авахад 2.6 сая;
- “Мянган ватт” ХХК-аас 27м зүлгийн гадна гэрэл авахад 1.3 сая төгрөг.

2.1.36 “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аас “АСЕМ Вилла” хотхоны тохижилтод “Номин тав трейд” ХХК-аас 0.2 сая төгрөгийн 4ш агаар чийгшүүлэгч, “Соёолж” ХХК-аас 0.4 сая төгрөгийн 3ш савтай цэцэг, “Хашхан” ХХК-аас 0.4 сая төгрөгийн 1ш сейф, нийт 1.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 2016 оны 06 дугаар сарын 15-нд ажлын хэсэгт өгч 2016 оны 10 дугаар сарын 03-нд буцаан авсан байна.

2.1.37 “УБДС” ТӨХК нь МУ-ын ЗГ /Ерөнхий сайд С Ч.Сайханбилэг/-ын 2015 оны 07 дугаар сарын 27-ны 315, 2016 оны 03 дугаар 21-ны өдрийн 172 дугаар тогтоол, ЭХС /Д.Зоригт/-ын 2016 оны 03 дугаар сарын 23-ны 01 дүгээр тушаалд 630 квт-ын хүчин чадалтай зөөврийн цахилгаан үүсгэрийг шууд гэрээгээр худалдан авахыг заасны дагуу 2016 оны 04 дүгээр сарын 18-нд Н-2016/01 дугаар 414.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг “Амбер” ХХК /захирал Д.Төвшин/-тэй хийсэн байна.

Гэрээнд 4.1.1-д заасны дагуу 800 ква-ын хүчин чадалтай 1ш үүсгүүрийг 2016 оны 06 дугаар сарын 01-ний дотор нийлүүлэх байсан боловч 2016 оны 07 дугаар сарын 1-нд 640 квт, 800 ква-ын хүчин чадалтай үүсгүүрийг нийлүүлсэн байна. Гэрээний биелэлт, бараа нийлүүлсэн актад захиалагч тал санхүүжилтийг гэрээний хугацаанд хийгээгүйтэй холбоотой гэж дүгнэсэн байна.



2.1.38 Аудитын тулган баталгаажуулалтаар ЭХЯ-аас ирүүлсэн судалгаанд ороогүй “УБЦТС” ТӨХК “АСЕМ”-ын бэлтгэл ажилтай холбоотойгоор дараах ажлуудыг хийсэн байна.

Хүснэгт 8

Төсөл, арга хэмжээний судалгаа

№	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн /сая.төг/	Гэрээний дугаар	Хийгдэх ажлууд
1	“Амбер” ХХК	411.9	98/2016	800ква-н 1ш зөөврийн генератор
		1059.0	99/2016	800ква-н 2ш суурийн генератор, дагалдах хэрэгсэл
2	“Топика” ХХК	7.4	130/2016	МТ-ийн тоног төхөөрөмж
3	“Их модун” ХХК	10.1	95/2016	Төрийн ордны дизель станц, дэд станцын барилгын засвар
4	“Сан-Индустриал” ХХК	4.8	209/2016	Төрийн ордны дизель станцын бетон угсралтын ажил
5	“Их Модун” ХХК	185.6	145/2016	Их тэнгэрт байрлах дизель станцын суурь, дээврийн ажил болон хаалга суулгах
6	“Кэй Эү Эм Эм Жи Эл” ХХК	245.9	132/2016	Тог баригч
7	“Юнайтэд Повер” ХХК	48.0	189/2016	4ш тог баригч
8	“Вагнер Ази” ХХК	199.3	96/2016	2ш генератор
9	“РЗА” ХХК	159.9	105/2016	Зөөврийн АВР, микропроцессорын хамгаалалт бүхий трансформаторын зөөврийн универсаль панель нийлүүлэх угсрах
10	“ЭСПМ интернэшнэл” ХХК	1,370.2	127/2016	Зайсан дэд станцаас төлөвлөгдөж буй дэд станц хүртэлх дэд станцын барилга
Нийт дүн		3,702.1		

Эх сурвалж: аудитын ажлын баримт

Аудитын явцад эдгээр ажлуудын гүйцэтгэгчийг хэрхэн сонгон шалгаруулсан болон гэрээ байгуулалт, гүйцэтгэлийг аудитын явцад анхан шатны баримтаар шалгах гэсэн боловч тус компанийн “нууц” гээд үзүүлээгүй учраас эдгээр төсөл, арга хэмжээний ажлын талаар хуулийн байгууллагад шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

“АСЕМ”-ын төсвөөс БХЯ “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор 317.4 сая төгрөгийг санхүүжилт авч зарцуулсан байна.

2.1.39 БХЯ-аас “АСЕМ”-ын уулзалтын арга хэмжээнд зориулж нийт 245.3 сая төгрөгийг шууд гэрээг байгуулан зарцуулжээ. Үүнд:

- ЗХЖШ /дарга Д.Даваа/-ын 2016 оны 07 дугаар сарын 01-ний 1/2602 дугаар албан бичгийн дагуу Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн захирагчид “Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчид”-ийн 72.8 сая төгрөгийн үнэтэй 75 хос төрийн ёслолын харуулын хувцсыг үйлдвэрлүүлэхээр “Бөртэ” ТӨҮГ-тай шууд гэрээ байгуулсан;
- “Бөртэ” ТӨҮГ /захирал Д.Дуламсүрэн/ БХС-ын 2016 оны 06 дугаар сарын 30-ны А/184 дүгээр тушаалын дагуу “Өгөөмөр баян дэнж” ХХК-тай 2016 оны 07 дугаар сарын 05-нд 160ш цэргийн хүндэт харуул, морьт цэргийн ёслолын хувцасны металл эдлэл нийлүүлэх 26.4 сая төгрөгийн 25 дугаар гэрээ байгуулсан;
- “Бөртэ” ТӨҮГ /захирал Д.Дуламсүрэн/ БХС-ын 2016 оны 06 дугаар сарын 30-ны А/184 дүгээр тушаалын дагуу “Сүмбэр Гранд констракшн” ХХК-тай 40.0 сая төгрөгийн үнийн дүнтэй цэргийн хүндэт харуулын 130 ширхэг зуны гутал, морьт



цэргийн 30 ширхэг зуны гутал бэлтгэн нийлүүлэх 26 дугаар гэрээг 2016 оны 06 дугаар сарын 30-нд байгуулсан;

- “Бөртэ” ТӨҮГ-/захирал Д.Дуламсүрэн/ БХС-ын 2016 оны 06 дугаар сарын 30-ны А/184 дүгээр тушаалын дагуу “Хатан Илд” ХХК-тай 34.1 сая төгрөгийн үнийн дүнтэй цэргийн хүндэт харуул, морьт цэргийн ёслолын хувцасны малгай, бүс, мөрөвч тус бүр 30 ширхгийг бэлтгэн нийлүүлэх 25 дугаар гэрээг байгуулсан;
- Зэвсэгт хүчний 232 дугаар анги 72.0 сая төгрөгөөр монгол тоногтой эмээлийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

БОНХАЖЯ “АСЕМ Вилла” цогцолборын орчинд 2 га талбайд ногоон байгууламж, мод тарих болон түүний арчилгаанд зориулж 150.0 сая төгрөгийг зарцуулсан боловч мод, бутыг бүртгэлд аваагүй байна.

2.1.40 “АСЕМ Вилла” цогцолборын орчинд 2 га талбайд мод тарьж, ногоон байгууламж байгуулах зорилгоор 2016 оны 04 дүгээр сарын 27-нд БОНХАЖЯ-ны ТНБД /Ц.Цэнгэл/, “Тод газар” ХХК-ийн захирал /Г.Батсайхан/ нар 150.0 сая төгрөгийн дугааргүй гэрээ байгуулсан байна.

Дээрх гэрээний дагуу “АСЕМ”-ын төсвөөс БОНХАЖЯ /хуучин нэрээр/-нд 2016 оны 05 дугаар сарын 11-нд 135.0 сая, 2016 оны 06 дугаар сарын 28-нд 15.0 сая, нийт 150.0 сая төгрөгийг “АСЕМ Вилла” цогцолборт мод тарьж, ногоон байгууламж бий болгоход зориулж санхүүжүүлжээ.

БОНХАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газар /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Тунгалаг/-ын 2016 оны 5 дугаар сарын 16-ны 06/2967 дугаар албан бичгээр Булган аймгийн БОАЖГ-т 550ш нарс, 300ш хус, 300ш шинэс, 60ш монос модны ойгоос бэлтгэх төлбөр хураамжийг чөлөөлөх тухай хариуцуулсан байна.

“Тод газар” ХХК нь дээрх 4 төрлийн 1,210 ш модыг Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон дахь сум дундын ойн ангиас авч ирэхэд тээвэр, шатахууны зардалд 42.0 сая, мод арчлалтын зардалд 7.9 сая, мод суулгах хүрз, хайчны зардалд 76.8 сая, хоол хүнсний зардалд 19.3 сая, бусад зардалд 4.0 сая төгрөг, нийт 150.0 сая төгрөгийг зарцуулсан гэж тайлагнажээ.

БОНХАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газар /дарга М.Тунгалаг/, “Тод газар” ХХК /захирал Г.Батсайхан/ 750ш том мод, 6000ш бут, нийт 6,750ш мод бут суулгасан гэж акт үйлдсэн байна.

“Тод газар” ХХК-ийн БОНХАЖЯ-нд гаргаж өгсөн ажлын тайланд “АСЕМ-Вилла” цогцолборын “Asem Villa Mongolia Club House” ресторан, нийт 53 байшингийн арын гадна талбайд 2м-ийн нарс 1ш, 4м-ийн нарс 5ш, 5м-ийн нарс 1ш, хус 3ш, шинэс 4ш, монос 1ш, шархуайс 95ш, нийт 5830ш /110ш*53/ мод, бутыг суулгасан гэсэн боловч мод, бутны эзэмшигч тодорхойгүй, бүртгэлд тусгаагүй, бүртгэлд тусгах арга хэмжээ аваагүй байна.

“АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор импортоор оруулж ирэх автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг УИХ хууль гарган ЗГ жагсаалтыг батлан НӨАТ, ОАТ, гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.

2.1.41 “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор УИХ 2016 оны 02 дугаар сарын 05-ны “НӨАТ-аас чөлөөлөх тухай”, “ОАТ-аас чөлөөлөх тухай”, “Гаалийн албан татвараас



чөлөөлөх тухай” хууль батлан гаргаж, ЗГ 2016 онд 142, 248, 332, 220, 227, 317 дугаар тогтоол гаргасан байна.

2.1.42 “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор /ГЕГ-аас ирүүлсэн судалгаагаар/ УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хууль болон ЗГ-ын 142,189,329 дугаар тогтоолоор дараах импортлогчдын оруулж ирсэн 14.9 сая ам доллар буюу 29.7 тэрбум төгрөгийн үнэтэй бараа, бүтээгдэхүүний нийт 6.0 тэрбум төгрөгийн албан татвар /НӨАТ, ОАТ, Гаалийн/ -ийг чөлөөлөгдсөн байна.

Хүснэгт 9

Чөлөөлөгдсөн албан татвар

№	Импортлогчийн нэр	Барааны нэр төрөл	Тоо ширхэг	Гаалийн үнэ /сая.төг/	Чөлөөлөгдсөн албан татвар /сая.төг/			
					НӨАТ	Онцгой АТ	Гаалийн АТ	Нийт АТ
1	Киамоторс ХХК	1	1	23.6	1.2	0	2.5	3.7
2	Монголхьюндай автомотив ХХК	1	3	107.5	5.4	0	11.3	16.7
3	Монголын Галын инженер техникчдийн холбоо	1	160	76.3	3.8	0	8.0	11.8
4	Моннис моторс ХХК	3	254	18,112.5	905.6	1,276.0	2,029.4	4,211.0
5	МСМ групп ХХК	2	5	1,559.5	78.0	36.2	167.4	281.6
6	ТТХГ	11	623	5,709.1	285.4	42.8	603.7	931.9
7	Хэтмоторс ХХК	1	52	2,631.1	131.6	0	276.3	407.9
8	Эртний говь ХХК	1	33	1,519.0	0	0	151.9	151.9
	Нийт дүн	21	1131	29,738.6	1,411.0	1,355.0	3,250.5	6,016.5

Эх сурвалж: аудитын ажлын баримт

2.1.43 “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны “НӨАТ-аас чөлөөлөх тухай, “ОАТ-аас чөлөөлөх тухай”, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн дагуу татвараас чөлөөлөгдөх ЗГ-ын 2016 оны 189, 220 дүгээр тогтоолоор баталсан жагсаалтад “Моннис Моторс” ХХК Nissan Patrol-Y62 маркийн 100ш, Nissan Teana-Y62 маркийн 120ш, Nissan Urvan микроавтобус 30ш, нийт 250ш автомашиныг татваргүйгээр импортлон оруулж ирэхийг зөвшөөрсөн байна. Гэтэл Nissan Civilian маркийн 4ш микроавтобусыг нэмж оруулан нийт 254ш автомашиныг 9,057.7 сая ам доллар буюу 18.1 тэрбум төгрөг /гаалийн үнээр/-өөр оруулж ирэн 4,211.0 сая төгрөгийн татвараас чөлөөлөгдсөн байна.

2.1.44 УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны албан татвараас чөлөөлөх тухай тогтоолыг үндэслэн гаргасан ЗГ-ын 2016 оны 142, 248 дугаар тогтоолоор “Киа Моторс Монгол” ХХК-ийн импортолж ирсэн “Киа K2700” маркийн 10ш түргэн тусламжийн автомашиныг НИТХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 21-ний 60 дугаар тогтоолоор 1,030.0 сая төгрөгөөр НЗД-ын нөөц хөрөнгөөс худалдан авахаар шийдвэрлэсний дагуу худалдан авсан байна.

2.2 Нийслэлийн төсвөөс хэрэгжсэн “АСЕМ”-ын төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хууль зөрчин шууд гэрээгээр гүйцэтгэсэн ба хөрөнгийн ихэнхийг өмчид бүртгээгүй байна.

Нийслэлд “АСЕМ”-ын хүрээнд 35.7 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг зохион байгуулах эрхийг НЗД нийслэлийн харьяа газруудад шилжүүлж, эдгээр



арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахгүйгээр “шууд” гэрээ байгуулсан байна.

Үндсэн мэдээлэл

НИТХ-ын 2015 оны 32/30, 2016 оны 65, 8/01, 4/09 дүгээр тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх нийт 348.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг шинэчлэн баталсан байна.

ЗГ-ын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд шинээр хэрэгжүүлэх автозам, хот тохижилт, засвар үйлчилгээ болон бүтээн байгуулалтын зарим ажил, тоног төхөөрөмжтэй холбоотойгоор нийслэлд нийт 33,634.2 сая төгрөгөөр хийгдэх 24 багц арга хэмжээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 63/37 дугаар “зөвлөмж”-ийн дагуу “шууд” гэрээ байгуулж “АСЕМ”-ын уулзалтаас өмнө ашиглалтад оруулах арга хэмжээ авахыг НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Э.Бат-Үүл/-д даалгажээ.

“АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн төсвөөс нийт 20.3 тэрбум, ХБ-ны концессын 6.9 тэрбум, улсын төсвөөс 8.5 тэрбум, нийт 35.7 төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд гэрээ хийж, 2016 онд 32.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

2.2.1 НЗД /Э.Бат-Үүл/-ын 2016 оны А/137, А/156, А/261, А/274 дүгээр тушаалаар дээрх жагсаалтыг тодотгон “шууд” гэрээ байгуулах замаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг УБ хотын ерөнхий менежер бөгөөд НЗАА /дарга Б.Бадрал/, Худалдан авах ажиллагааны газар /дарга үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ганбаатар/ болон дараах төсвийн захирагч нарт үүрэг болгосон байна.

Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд НЗД /Э.Бат-Үүл/ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²⁵-д заасны дагуу 2016 оны А/24, А/203, А/07, А/67, А/279, А/261, А/10, А/17, А/25 дугаар захирамжаар Тамгын газрын дарга /Ё.Гэрэлчулуун/, УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /дарга /Б.Бадрал/, НХААГ-ын дарга /С.Ганбаатар/, НОБГ-ын газар /дарга Н.Уламбаяр/, УБ хотын Цагдаагийн газар дарга /Ч.Болдбаатар/, Хан-Уул дүүргийн Засаг дарга /Ж.Ганхуяг/ нарт худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байна.

2.2.2 Нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга /Ш.Төмөрбаатар/-д даалгасан боловч бүрэн хэрэгжээгүй байна.

НӨХГ нь НИТХ-ын 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-д “шинээр бий болсон хөрөнгийг захиалагчийн хүсэлтийг үндэслэн бүртгэлд тусгана” гэж заасны дагуу Нийслэлийн авто замын газраас бүртгэлд тусгах хүсэлт ирүүлсэн 8,182.3 сая төгрөгийн авто зам, арчлал, засвар, гэрэлтүүлгийн ажлыг нийслэлийн өмчид бүртгэсэн байна. 2016 онд “АСЕМ”-ын бэлтгэл

²⁵ 14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



ажилтай холбоотой хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 74 хувийг нийслэлийн өмчид тусгаагүй байна.

2.2.3 Зам, тээврийн сайдын 2016 оны 31, 42 дугаар тушаалаар НЗД-д “худалдан авах ажиллагаа” хийх эрхийг шилжүүлснээр НЗД-ын 2016 оны А/157, А/261, А/279 тушаалаар НХААГ-т 15,933.7 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан байна.

2.2.4 НЗД-ын 2016 оны А/24, А/203 дугаар захирамжаар “Монгол наадам” цогцолборын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд хийгдэх 8 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, “худалдан авах ажиллагааны эрх”-ийг НЗД-аас нийслэлийн ЗДТГ-ын дарга /Ё.Гэрэлчулуун/-д шилжүүлсэн байна.

Дээрх захирамжаар “Хүй долоон худгийн гадна цэвэр ус, хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөний макет, 110/35/10 квт-ын цахилгаан хангамжийн зураг төсөл” гэсэн нэр бүхий 3 зөвлөх үйлчилгээний зураг төсөл боловсруулах худалдан авах ажиллагааг “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” НӨҮГ шууд гэрээ байгуулсан.

Мөн эко автобусны замын хажуугаар 3600 м² явган зам автобусны зогсоол, эргэлтийн талбай байгуулах, эко автобус цэнэглэх цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд “Скай стар” ХХК-ийн захирал Ч.Цогтсайхан оролцсон нь СС-ын 2012 оны 194 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын 5.2-д “тендерийн үнэлгээний явцад ТБОНӨХБАҮХАТХ-ийн 54²⁶ дүгээр зүйлд заасан заалтыг зөрчсөн байна.

2.2.5 Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжих нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хороолол, орон сууны хорооллын гэрэлтүүлэг, тохижилтын ажлын хөрөнгөөс “АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх 10 багц 3.0 тэрбум төгрөгийн ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны А/15²⁷ дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр нэг удаа хуралдаж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27, 28 дугаар зүйлд зааснаар захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт заасан нөхцөл, үнийн санал зэргийг удирдлага болголгүй хот тохижилтын ажил хийлгэхээр 35 компанитай “шууд” гэрээ байгуулахаар шийдвэр гаргасан байна.

Нийслэлийн захирагчийн ажлын алба “АСЕМ”-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх хот тохижилтын 10 багц ажлын 41 төсөл, арга хэмжээнд 35 гүйцэтгэгчтэй 2.9 тэрбум төгрөгийн дүнтэй шууд гэрээ байгуулж, нийт 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

²⁶ “гомдол маргааныг хэлцэхээс бусад шалтгаанаар захиалагч болон тендерт оролцогчийн хооронд уулзалт, ярилцлага явуулж болохгүй”

²⁷ Хавсралт 1: Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын,

Хавсралт 2: 2016 оны Хот тохижилт, АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тохижилтын ажлын,

Хавсралт 3: Ногоон байгууламжийн хөрс ариутгал, хортон шавьж, зэрлэг ургамалтай тэмцэх ажлын,

Хавсралт 4: Хөг хаягдал, орчны эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г байгуулсан байна.



2.2.6 Хот тохижилтын ажил болох явган хүний замын хавтанг нөхөн сэргээж будах, шинээр барих, сул шороон даланг эко хавтангаар хучих зэрэг ажлын гүйцэтгэл гэрээнд заасан хугацаанаас 4-52 хоногоор хэтэрсэн боловч захиалагч Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны дарга /Б.Бадрал/ гэрээг хугацаанд нь дүгнэх талаар арга хэмжээ аваагүй байна. *Тухайлбал;*

- *Чингисийн өргөн чөлөө /Төв шуудангийн уулзвараас Мишээл экспогийн хойд уулзвар хүртэл/ явган хүний зам барих ажил;*
- *Энхтайваны өргөн чөлөө /Зүүн 4 замаас Баруун 4 замын уулзвар хүртэл/ явган хүний зам барих ажил;*
- *Чингисийн өргөн чөлөө /Төв шуудангийн уулзвараас ХУД-ийн уулзвар хүртэл/ явган хүний зам барих ажил;*
- *Наадамчдын зам /Яармагын зам дагуу/ эко хавтангаар сул шороогоор хучих ажил;*
- *Энхтайваны гүүрний урд талын сул шороон талбай;*
- *Зайсангийн гудамжны сул шороон талбайг эко хавтангаар хучих ажил.*

2.2.7 НЗД-ын 2016 оны А/456 захирамжаар хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг НӨХГ-т даалгасан боловч захиалагч НЗАА болон НӨХГ нь хот тохижилтын 20 төсөл, арга хэмжээний 1.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй нь НБББ-ийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1²⁸, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2²⁹-д заасныг тус тус зөрчсөн байна.

2.2.8 Нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүйн улмаас түүний ашиглалт, хамгаалалтад хяналт тавих эзэнгүй болсон нь аудитын явцад хийсэн тулган баталгаажуулалтаар илэрлээ. *Тухайлбал;*

- *НЗАА 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Их Мандах-Очир” ХХК-тай 165.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулж Дүнжингаравын зам дагуу 15 байршилд ногоон төгөл бүхий бичил тохижилтын ажил /сүүдрэвч, хогийн сав, цэцгийн мандал/-ыг хийж гүйцэтгэсэн гэх боловч аудитын тулгалтаар нийт 9 сүүдрэвч, 8 хогийн сав, 2 цэцгийн мандал байсан ба сүүдрэвчүүдийн ерөнхий байдал эвдэрсэн, хогийн сав тоногдон алга болсон, цэцгийн мандал эвдэрч нурсан байдалтай байлаа. Эдгээрийг хийсэн хийц материал нь удаан хугацаанд ашиглагдах боломжгүй байгаа нь ажиглагдлаа. Нэг бүр нь 11.0 сая төгрөгийн үнээр хийлгэсэн сүүдрэвч гэхэд хэтэрхий өндөр үнээр хийгдсэн байна.*
- *НЗАА “Ургах гүрэн” ХХК-тай “Наадамчдын зам дагуух сул шороон даланг эко хавтангаар хучих” 284.0 сая төгрөгийн ажлыг 2016 оны 05 дугаар сарын 02-ноос 06 дугаар сарын 10-ны хооронд хийж хүлээлгэх өгөхөөр гэрээ байгуулсан боловч 2016 оны 12 дугаар сарын 06-ны комисс хүлээн авсан байхад НЗАА нь гэрээг дүгнээгүй байна. Аудитын явцад тулган баталгаажуулалт хийхэд сул шороон даланг эко хавтангаар хучсан нь нурж унасан байдалтай байна.*

²⁸ “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ”

²⁹ санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”



Зураг 8



Сүүдрэвч

Зураг 9



Сул шороог эко хавтангаар хучих ажил

2.2.9 ЕС-ын 2016 оны 05 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн “Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах дамжлага нэмэх, ашиглалтад оруулах” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг НЗД-ын 2016 оны А/135 дугаар захирамжаар УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /дарга /Б.Бадрал/-нд шилжүүлсэн ба хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт, тавьж ажиллахыг НӨХГ-ын дарга /Ш.Төмөрбаатар/-д даалгасан байна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 03 дугаар сарын 04-ний А/31 дүгээр тушаалаар энэхүү төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2016-2017 онд Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах, дамжлага нэмэх, ашиглалтад оруулах ажлын хүрээнд 26 төсөл, арга хэмжээг 22 гүйцэтгэгчтэй 7.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, нийт 5.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Төв цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлтийн эхний ээлжийн ажил 2016 оны 7 дугаар сарын 01-ээс 9 дүгээр сарын 01-ний хооронд дуусгахаар төлөвлөсөн нийт 25 ажлаас 2016 онд 17 ажил 100 хувь дуусаж, 8 ажил он дамжин хэрэгжиж 2017 онд дууссан байна.

Гэрээний дагуу зарим төлөвлөгдсөн ажил цаг хугацаандаа хийгдээгүйд НЗАА-аас дараах шалтгаануудаар тайлбар өгч байна. *Тухайлбал;*

- Гэрээний дагуу эхний болон дунд шатны санхүүжилт хийгдээгүйгээс гүйцэтгэгч байгууллагуудын ажил удааширсан;
- УСУГ-ын даргын тушаалаар 2016 оны 7 дугаар сарын 08-нд Төв цэвэрлэх байгууламжийн даргыг чөлөөлж, 2016 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд шинээр дарга томилогдоогүй;
- 2016 оны 8, 9 дүгээр сард үлдсэн 10 ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажил эхэлсэн боловч УМХЕГ-ын үзлэг, НЗТ-ын А/778 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын дүн гартал тодорхойгүй хугацаагаар ажлууд зогссон.

2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс ажлуудыг үргэлжлүүлэх шийдвэр гарснаар НЗД-ын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс 10 ажлын гэрээг баталгаажуулж, бусад ажлын санхүүжилтийг оройтож олгосон нь хугацаа хэтрэхэд нөлөөлсөн гэжээ.



2.2.10 НЗАА нь Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах, дамжлага нэмэх, ашиглалтад оруулах ажлын хүрээнд хийгдсэн 21 төсөл, арга хэмжээний 2.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1³⁰, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2³¹, ТӨБЗГ-ын 2017 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1³² дэх заалтыг тус тус мөрдөж ажиллаагүйг харуулж байна.

Дээрх “Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах дамжлага нэмэх, ашиглалтад оруулах” төсөл, арга хэмжээтэй холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.2.11 НЗД-ын 2016 оны А/07 дугаар захирамжийн 1-ээр хавсралтаар батлагдсан 7 ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны даргын 2016 оны А/36, А/51, А/67 дугаар тушаалаар 70 төсөл, арга хэмжээ болгон задалж, үүний 22 төсөл, арга хэмжээг “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” НӨҮГ-т шилжүүлж, үлдэх 48 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь дээрх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж худалдан авах ажиллагааны ажлын баримтад үнэлгээний хорооны зөвлөмжийг хавсаргасан боловч хуралдааны тэмдэглэлийг ажлын баримтад байхгүй байна.

2.2.12 НЗД-ын 2016 оны А/07 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын дагуу Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжих авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын жагсаалтад орсон Хотын гол болон туслах автозамуудын засвар, арчлалтын ажлын 3.0 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/36, А/51 дугаар тушаалаар ажлын задаргаагаар баталсан байна.

2.2.13 2016 онд нийслэлд хэрэгжүүлэх байсан автозамтай холбоотой төсөл арга хэмжээнд нийт 66.4 тэрбум төгрөгийн төсөвтэй төсөл арга хэмжээнээс 30.6 хувийг, үүнээс зам арчлалтын төсөл арга хэмжээнд 15.3 тэрбум төгрөг батлагдсанаас 32.6 хувийг “АСЕМ”-ын бэлтгэл ажлын хөрөнгөөр хийсэн байна.

“АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн автозам, замын арчлалтад нийслэлээс нийт 13.8 тэрбум, ХБ-ны концессын 6.9 тэрбум, нийт 20.7 төгрөгийн төсөвт өртөгтэй 187 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд сонгон гэрээ хийж, 2016 оны эцэст 19.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байна.

“АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн автозам, замын арчлалтад зарцуулсан хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

³⁰ “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ”

³⁰ “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”

³¹ “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлнэ”



2.2.14 “АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн авто замын төсөл арга хэмжээнд нийт 2,991.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл, арга хэмжээг “АСЕМ”-ын уулзалтаас хойш хэрэгжиж дуусахаар гэрээнд тусгагдсан байна. *Тухайлбал;*

- “Тэргүүн саруул зам” ХХК-ийн гүйцэтгэсэн 1,478.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “60 дугаар сургуулийн баруун уулзвараас Сонсголонгийн арын зам хүртэлх 1.2 км авто зам”-ын /ХУД, 7-р хороо/ ажил, 2016 оны 10 дугаар сарын 31-нд дуусах;
- “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 121.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий шинээр хийгдэх замын тэмдэг /гүйцэтгэлээр/ 2016 оны 12 дугаар сарын 01-нд дуусах; үүнээс 38.7 сая төгрөгийн тэмдэг, тоноглолын арчлалтын ажил /гүйцэтгэлээр/ 2016 оны 12 дугаар сарын 01-нд дуусах, 47.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хайс нөхөн суурилуулалт, арчлалтын ажил 2016 оны 10 дугаар сарын 01-нд дуусах, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хурд сааруулагч хийх ажил 2016 оны 09 дүгээр сарын 01-нд дуусах;
- “НҮУБН” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн нийт 873.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий авто замын тэмдэг, тэмдэглэгээг 16 байршилд хийх ажил 2016 оны 10 дугаар сарын 01-нд дуусах;
- “НҮУБН” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий туслах гудамж замуудын орц, гарц, зогсоол засварлах ажил 2016 оны 10 дугаар сарын 12-нд дуусах;
- “НҮУБН” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 70.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хотын гаднах авто замуудын өвлийн цас, мөсний цэвэрлэгээний ажил 2016 оны 12 дугаар сарын 30-нд дуусах;
- “НҮУБН” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн 233.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд намрын улиралд хийх урсгал засварын ажил 2016 оны 10 дугаар сарын 01-нд дуусах;
- “Дүүрэн трейд” ХХК-ийн гүйцэтгэсэн 60.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий авто зам, явган замын зорчих хэсэг дээр байрласан шугам сүлжээний худгийн түвшин тааруулах ажил 2016 оны 10 дугаар сарын 30-нд дуусах гэх мэт нийт 25 төсөл арга хэмжээг “АСЕМ”-ын бэлтгэл ажилд хамруулан мэдээлсэн байна.

2.2.15 ЗГ-ын хуралдааны тэмдэглэл болон НЗД, УБ хотын Ерөнхий менежерийн гаргасан эрх зүйн шийдвэрт “АСЕМ”-ын үйл ажиллагаанд хамааралгүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа шууд гэрээ байгуулсан байна. *Тухайлбал,*

- “АСЕМ”-ын үйл ажиллагаанд хамааралгүй зам, замын засвар арчлалттай холбоотой 5,794.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 152 төсөл, арга хэмжээг тайлагнасан байна.
/дэлгэрэнгүйг хавсралт №3-с үзнэ үү/

2.2.16 Гэрээт ажлыг гүйцэтгэгчээс хүлээн авч санхүүжилтийг олгосон боловч гэрээ дүгнэсэн протокол, улсын комиссын актыг архивын нэгжид хадгалаагүй зөрчил илэрлээ. *Тухайлбал;*

- “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн “Мэдээллийн тэмдэг суурилуулах” 120.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил;
- “НҮУБН” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн авто замын заадас арилгах нийт 204.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 ажил;
- “Оч наран” ХХК-ийн гүйцэтгэсэн ХУД, Нисэхийн гэр хорооллын 250 м авто замын хучилтыг хүчилтгэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил;
- “Нарны үүсгэл” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сангийн яам орчмын авто замын засвар”-ын 49.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил, нийт 473.9 сая төгрөгийн 17 ажлын гэрээ дүгнэсэн протокол, Улсын комиссын актыг архивын нэгжид хадгалаагүй байна.

2.2.17 Аудитад ирүүлсэн материалаас үзэхэд НЗД-ын 2016 оны А/180 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2016 оны 03 дугаар сарын 25-ны



өдрийн 07 ээлжит хурлаар “Баянмонгол хорооллын урд 1.1 км авто замын ажил Багц 1”-д “Готик голд” ХХК-аас ирүүлсэн нэмэлт материалыг судалж, тус компанийг санхүүгийн чадамжгүй тул гэрээ байгуулах боломжгүй гэсэн дүгнэлт гарган, НХААГ-ын удирдлагад дараагийн компанийг санал болгож оруулж ирүүлэх хүсэлтийг өгчээ. Гэвч 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр “Готик голд” ХХК-тай 958.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ гэрээ байгуулсан байна.

2.2.18 НИТХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 21-ний 65 дугаар тогтоолоор 2015 оны 32/33 дугаар тогтоолд өөрчлөлт оруулсны дагуу НЗД /Э.Бат-Үүл/-ын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны А/25 дугаар захирамжид тусгагдсан “ХУД, 8 дугаар хороо, 60 дугаар сургуулийн баруун уулзвараас Сонсголонгийн арын зам хүртэлх 1.2 км автозам”-ын 1,045.5 сая төгрөгийн төсөвт өртгийг 1,478.5 сая төгрөг болгон 2016 оны 05 дугаар сарын 11-ны А/372 дугаар захирамж гаргасан байна.

НЗД-ын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/25 дугаар захирамжаар энэхүү ажлын худалдан авах ажиллагааны эрхийг Хан-Уул дүүргийн Засаг дарга /Ж.Ганхуяг/-т шилжүүлсэн байна.

Энэхүү ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ХУД-ын Засаг даргын 2016 оны 2 дугаар сарын 02-ны А/34 дүгээр захирамжаар байгуулсан боловч 2016 оны 05 дугаар сарын 20-ны А/214 дүгээр захирамжаар иргэний төлөөллийг сольж өөрчилсөн байна. Уг үнэлгээний хороо 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн эхний хуралдаанаар “Тэргүүн саруул зам” ХХК-тай шууд гэрээ байгуулах зөвлөмж гаргасны дагуу 2016 оны 05 дугаар сарын 27-нд ХУД/2016/НТХ-8/01-1-58,15-6 дугаартай 1,478.5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг “Тэргүүн саруул зам” ХХК-тай байгуулжээ.

Уг ажлыг гэрээний дагуу 2016 оны 05 дугаар сарын 27-аас 07 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэх байсан боловч 2016 оны 12 дугаар сарын 08-ны 2016/580 дугаар актаар хүлээн авч, гэрээг 2017 оны 02 дугаар сарын 13-нд дүгнэсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээний анхны төсөвт өртгийг 433.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх болсон талаар аудитын явцад ирүүлсэн баримтаар нотлогдохгүй байгаа тул хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.2.19 НЗД /Э.Бат-Үүл/-ийн 2016 он 05 дугаар сарын 13-ны А/377 дугаар захирамжаар НЗД-ын нөөц хөрөнгөнөөс НХМГ-т “АСЕМ”-ын үйл ажиллагаанд оролцож буй ААН-ын хоол үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийхэд зориулж 46.4 сая төгрөгийг санхүүжүүлж, НМХГ-ын дарга /Л.Эрдэнэчулуун/-ын 2016 оны А/14 дүгээр тушаалаар төсвийг баталж зарцуулсан байна.

2.3 "АСЕМ"-ын бэлтгэл ажил, үйл ажиллагаанд оролцсон иргэн, хуулийн этгээдүүд ажлын гүйцэтгэлээ тайлагнаагүй, түүнд төрөөс тавих хяналтгүй байжээ.

Ерөнхий мэдээлэл

Аудитын явцад “АСЕМ”-ын үйл ажиллагаанд нийт 395.7 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулагдсан бөгөөд түүний 65.2 хувь буюу 257.9 тэрбум төгрөгийг 39 иргэн, 268 хуулийн этгээдтэй гэрээ хийж зарцуулсан судалгааг нэгтгэн гаргалаа.



Хүснэгт 10

Оролцогсдын судалгаа

№	Иргэн, хуулийн этгээдийн ангилал	тоо	Гэрээний дүн /сая.төг/
1	Төсвийн байгууллага	35	6,690.9
2	Хуулийн этгээд /ХХК/	182	139,092.2
3	Төрийн бус байгууллага /ТББ/	46	3,581.8
4	ХХБ, Голомт банк, УБ хотын банк, Төрийн банк, Хаан банк	5	108,425.4
5	Нэр бүхий 39 иргэн	39	119.6
	Нийт	307	257,909.9

Эх сурвалж: аудитын ажлын баримт

Дээрх зарцуулалтын 52.7 хувь буюу 136.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг дараах хуулийн этгээдийн тайлан, баримтыг үндэслэн аудитад хамрууллаа.

Хүснэгт 11

Аудитад хамрагдагсдын судалгаа

№	Иргэн, хуулийн этгээдийн нэр	Гэрээний дүн /сая.төг/
1	"ОУ-ын Уран бүтээлчдийн Монголын холбоо" ТББ	558.1
2	"Шандаст хонгор" ХХК	71.9
3	"Эрсү" ХХК	371.7
4	"Вертексмон" ХХК	252.0
5	"Нью терравокс" ХХК	536.7
6	"Саунд ов Монголиа" ХХК	271.3
7	"Шангри-ла хотел" ХХК	1,369.4
8	"Лишцэцэг" ХХК	52.2
9	"Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн сан" ТББ	518.0
10	"Зогсолтгүй эргэлт" ХХК	3,452.5
11	"Эвэнт энд Конвенцион сервисес" ХХК	1,091.6
12	"Скай резорт" ХХК	125,101.1
13	"Номадс Хоспиталита" ХХК	1,704.7
14	"Урлаг түншлэл" ТББ	436.6
15	"Ирмүүн агентлаг" НҮТББ	143.1
16	"Гэрлүг" ХХК	110.4
	НИЙТ ДҮН	136,041.3

Эх сурвалж: аудитын ажлын баримт

2.3.1 Аудитаар "АСЕМ"-ын үйл ажиллагаанд оролцон ажил үйлчилгээ үзүүлсэн зарим хуулийн этгээдийн баримтын хүрээнд шалгахад дараах нийтлэг зөрчилтэй асуудлууд байна. Тухайлбал;

- Гэрээний захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлага хэсэгт "гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан болон гэрээгээр хийсэн ажлын гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг гаргаж өгөх, гаргуулан авч хяналт тавих" гэсэн заалтыг оруулаагүй, оруулсан ч хэрэгжүүлээгүй;
- Гэрээ бүрийн зардлын гүйцэтгэлийн тайланг гаргаагүй, зардлыг гэрээ бүрээр анхан шатны баримтаар хөөн тулгахад хүндрэлтэй ойлгомжгүй;
- Гэрээт ажлын хөрөнгийн зарцуулалтыг НББ-ийн зохих стандартын дагуу бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлын дансанд бичилт хийсэн;
- Зарим компанийн 2016 онд олсон орлого, зарцуулсан зарлагын баримтаас "АСЕМ"-тай холбоотой баримтыг ялгахад бэрхшээлтэй, баримт бүрэн бус;
- Туслан гүйцэтгэгч бүртэй гэрээ байгуулаагүй, гүйцэтгэлийг гаргаагүй, зарцуулалтад хяналт тавиагүй, энэ талаар гэрээнд тодорхой тусгаагүй;
- Гэрээгүйгээр худалдан авалт хийсэн;



- “АСЕМ”-ын үйл ажиллагаанд тухайн компаниас ажил үйлчилгээ нийлүүлсэн гэж тайлагнаж байгаа боловч баримтаар нотлогдохгүй, НББОУС-ын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хэрхэн тусгасан нь тодорхойгүй, өөрийн хөрөнгөөр хийгдсэн ажил үйлчилгээний үнэ, өртгийг гаргаж захиалагчтай тохиролцоогүй, хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй;
- “АСЕМ”-ын хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг бүртгэлд тусгаагүй, ГХЯ-нд хүлээлгэж өгөөгүй, гэрээнд энэ талаар тусгаагүй;
- Зарим гэрээг ажил үйлчилгээ хийгдсэний дараа байгуулсан, гэрээ цаг хугацааны хувьд зөрүүтэйгээс хяналт тавих боломжгүй;
- Зарим гэрээнд хийх ажил үйлчилгээ, түрээслэх хөрөнгийн талаар тодорхой заагаагүй, биелэлт тооцох хугацаа, гэрээний огноо, дугаар, гэрээний нийт үнийн дүнг бичээгүй, төсвийг хавсралтаар хийгээгүй, нэмэлт гэрээ байгуулаагүй байна.

2.3.2 “АСЕМ”-ын бүх үйл ажиллагаанд гүйцэтгэгчийг сонгосон шалгаруулалт явуулалгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Шангри-Ла” зочид буудалд байгуулагдсан “Хэвлэлийн төв”-ийн ажлын гүйцэтгэлийн талаар

2.3.3 “АСЕМ”-ийн Үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 04-ний 25 дугаар хуралдаанаас шийдвэрлэсний дагуу “АСЕМ”-ын Шангри-Ла зочид буудлын В1 давхарт “Хэвлэлийн төв” байгуулахаар ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Эвэнт энд Конветион сервисес” ХХК-ийн захирал Л.Булгантөмөр нар 1,076.6 сая төгрөгийн 5 гэрээг байгуулж, “АСЕМ-ын төсвөөс нийт 942.6 сая, “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас нийт 134.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Мөн “Урлаг түншлэл” ТББ-аас 15.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Аудитын явцад тус компаниас ирүүлсэн баримтаас нийт 1,091.6 сая төгрөгийн гэрээт ажлуудаас 24.8 хувь буюу 270.5 сая төгрөгийн ажилд 9 туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч гэрээний биелэлтийг тооцсон акт үйлдээгүй байна.

Аудитын тулган баталгаажуулалтаар ажил гүйлгээтэй холбоотой дараах зөрчилтэй асуудлууд байна. Тухайлбал;

- Иргэн Г.Өлзийбаяртай 01/02 дугаар гэрээгээр 1.4 сая төгрөгийн “тодорхойгүй” ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 5.7 сая төгрөг санхүүжүүлсэн байна.
- “Хүслийн өнгө” ХХК-д хэвлэлд 2016 оны 06 дугаар сарын 28-нд 22.8 сая, 2016 оны 07 дугаар сарын 19-нд 9.8 сая, нийт 32.6 сая төгрөгийг бэлнээр өгсөн байна. Гэвч тус компаниар ямар ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн нь баримтаар тодорхойгүй, гэрээ хийгээгүй байна. Мөн 0.8 сая төгрөгийн материал авч өгсөн байна.
- “Акватик” ХХК-аас 2016 оны 07 дугаар сарын 09-18-ны хооронд 8ш усны аппаратыг 400.0 мянган төгрөгөөр түрээслсэн гэж тоног төхөөрөмж хүлээн авсан акт үйлдсэн боловч буцаан хүлээлгэн өгсөн акт байхгүй байна.
- “Пластик дизайн” ХХК-аар гэрээгүйгээр 19.4 сая төгрөгийн баннер хэвлэлт, тохижилт хийлгэсэн гэж гүйцэтгэлийн тайланд тайлагнасан боловч санхүүжилт нь



харилцахаас 2016 оны 07 дугаар сарын 29-нд “Дөл хангай” ХХК-д шилжүүлэгдсэн байна.

- “ЭЛСТА” ХХК-аар гэрээгүйгээр 3.2 сая төгрөгийн цахилгааны зураг, скиз хийлгэсэн байна.
- Тус компанийн дээрх гэрээт ажил үйлчилгээнд 650.2 сая төгрөгийн зардлыг өөрөө гаргасан гэж ГХЯ-нд зарлагын баримт өгсөн боловч түүнийг ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА-р баталгаажуулаагүй байна.

“Эвэнт энд Конветион сервисес” ХХК-ийн 2018 оны 03 дугаар сарын 9-ны дугааргүй албан бичгээр 2016 оны 07 дугаар сарын 27-нд 2650м буюу 71.9 сая төгрөгийн хивс, 100ш буюу 21.1 сая төгрөгийн гэрэл, 5000м цахилгааны дотор кабель, 1000м цахилгааны гадна кабель, 100м цахилгааны лотки, 1000м кабель далдлагч, 200ш /170x70/ ханын баннер, 36ш /1500x4м/ таазны баннерыг ГХЯ-ны мэргэжилтэн /“АСЕМ”-ын гэрээт нярав/ Д.Амгаланд өгсөн гэж жагсаалтын хамт тодорхойлсон боловч жагсаалтад ГХЯ-ны хүлээн авсан хүний гарын үсэг байхгүй байна.

Аудитаар “Эвэнт энд Конветион сервисес” ХХК захиалагч талд гэрээний 2.7-д “Гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан болон гэрээгээр хийсэн ажлын гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг гаргаж өгөх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.3.4 “АСЕМ”-ын дээд хэмжээний уулзалтын дагалдах хуралдаанууд, ахлах албан тушаалтнуудын уулзалт, хаалтын нэгдсэн хуралдаанд зориулсан тоног төхөөрөмж түрээслэхээр “**Нью Терравокс**” ХХК /ерөнхий захирал Г.Түмэн-Ерөөлт/-тай 536.7 сая төгрөгийн 9 гэрээг “АСЕМ”-ын БАА /дарга Д.Ганхуяг/ байгуулсан ба гэрээний дагуу хийгдсэн ажлын талаар ГХЯ-нд тайлагнаагүй ба аудитын явцад гүйцэтгэлийн тайланг гаргаж өгсөн нь нотлох баримтаар бүрэн нотлогдохгүй байна.

Аудитаар дээрх дурдсанчлан “Нью Терравокс” ХХК-д түрээслүүлсэн тусламжийн тоног төхөөрөмжийн тоо ширхэг зөрүүтэй, гэрээний заалтууд ойлгомжгүй байгаа тул энэ асуудлуудыг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.3.5 “Шангри-Ла Молл” оффисын дотоод сүлжээний ажлыг гүйцэтгүүлэхээр 2016 оны 06 дугаар сарын 30-нд ГХЯ-ны ТЗУГ-ын захирал Т.Тэгшжаргал, “**Вертексмон**” ХХК-ийн борлуулалтын албаны захирал Д.Мэндсайхан нар 16.7 сая төгрөгийн үнийн дүнтэй ВМГ 16/19 дугаартай тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээг байгуулан ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Вертексмон” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Наранцогт нар баталгаажуулж, 2016 оны 06 дугаар сарын 13-нд 13.4 сая, 2016 оны 07 дугаар сарын 22-нд 3.3 сая төгрөгийг ГХЯ-аас шилжүүлжээ.

Мөн “Шангри-Ла Молл оффис”-ын “Хэвлэлийн төв”-ийн тоног төхөөрөмжийг суурилуулах, тохируулах, ажил үйлчилгээг хариуцах, түрээслэхээр 2016 оны 06 дугаар сарын 10-нд Ерөнхийлөгчийн зөвлөх, “АСЕМ”-ын хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлын хэсгийн ахлагч А.Ганбаатар, “Вертексмон” ХХК-ийн техникийн албаны дарга Ө.Энх-амгалан нар 235.3 сая төгрөгийн үнийн дүнтэй 05 дугаартай тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээг байгуулан ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Вертексмон” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Наранцогт нар баталгаажуулж, 2016 оны 06 дугаар сарын 13-нд 188.2 сая, 2016 оны 07 дугаар сарын 27-нд 47.1 сая төгрөгийг ГХЯ-аас шилжүүлжээ.

ГХЯ-ны БАА-аас 2016 оны 07 дугаар сарын 21-ны өдөр тус компанийн гүйцэтгэсэн ажлыг 7 хүн хүлээн авсан гэж “ажил хүлээлцэх акт” үйлдсэн байна. Гэтэл гэрээнд ажил



гүйцэтгэх хугацааг “АСЕМ”-ын үйл ажиллагаа дууссан буюу 2016 оны 07 дугаар сарын 20-нд гэж бичсэн байна. Уг нь “АСЕМ”-ын хуралдаан эхлэхээс өмнө энэхүү дотоод сүлжээ тавих, хэвлэлийн төвийг бэлэн болгож тоног төхөөрөмжийг суурилуулах ёстой байсан ба энэ хугацаанд хийгдсэн гэж тайлбарлаж байгаа нь гэрээг ажил дууссаны дараа хийсэнг харуулж байна.

ГХЯ-д тус компанийн гүйцэтгэсэн ажлын талаарх нотлох баримт хангалтгүй байгаа ба зөвхөн ажлын гүйцэтгэлийн тайлан ирүүлсэн ба аудитын явцад тоног төхөөрөмж, бараа материалыг тус компанид бүртгэлтэй эсэхийг тогтоох боломжгүй байлаа.

2.3.6 “АСЕМ”-ын салбар хуралдаануудын байрын тохижилт, тоног төхөөрөмжийн үйлчилгээг хариуцаж **“Саунд ов Монголиа” ХХК**-ийн ерөнхий захирал М.Уянга, ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг нар 6 төрлийн 271.3 сая төгрөгийн 8 гэрээгээр ажил гүйцэтгэсэн байна.

Мөн 2016 оны 07 дугаар сарын 18-нд 1.3 сая, 2016 оны 07 дугаар сарын 21-нд 12.4 сая, нийт 13.7 сая төгрөгийг гэрээгүй, чухам юу хийх нь тодорхойгүйгээр ГХЯ-аас шилжүүлсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.1.4-т *“Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тус компанийн гүйцэтгэсэн ажлуудын талаар ГХЯ-д гэрээ, үнийн саналаас өөр баримт бичиг байхгүй байсан ба аудитын явцад “Саунд ов Монголиа” ХХК-тай холбогдсоноор дээрх ажлуудын нотлох баримт гэж авчирч үзүүлсэн боловч тэр нь “АСЕМ”-ын үйл ажиллагааны нотлох баримт болох эсэхийг ялгахад бэрхшээлтэй, боломжгүй, 2016 оны компанийн нийт гүйцэтгэсэн ажлын баримт байлаа.

“АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотой дээрх гэрээнүүдэд төсөв хийгдээгүйгээс гүйцэтгэлийг гэрээ бүрээр тайлагнаагүй, хийсэн ажлыг хүлээн авсан акт, гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2-д *“Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэ, зөв, гаргах үндэслэл болно”*, мөн хуулийн 20.1.4-т *“Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.3.7 “АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотойгоор **“Шангри-Ла Хотел” ХХК**, ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуягтай 1,369.4 сая төгрөгийн 4 гэрээгээр ажил гүйцэтгэсэн боловч гүйцэтгэсэн ажлын тайлан, гүйцэтгэлийн акт гэх мэт баримтууд ГХЯ-д байхгүй байсан тул аудитын явцад “АСЕМ”-тай холбоотой гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг аудитад хамруулах албан бичиг явуулсан боловч хариу мэдэгдээгүй болно.

“Шангри-Ла” зочид буудлын хажууд байгуулагдсан “Гэрхотхон”-ын ажлын гүйцэтгэлийн талаар

2.3.8 “АСЕМ”-ын оролцогч улс орнуудын хоёр талын болон Төрийн тэргүүнүүдийн албан бус уулзалтуудыг зохион байгуулахын тулд “Шангри-Ла” зочид буудлын баруун талд Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн талбайд Монгол ёс заншил, өв уламжлалыг таниулах, харуулах зорилгоор монгол үндэсний сийлбэр бүхий “Гэр хотхон” /бүрэн сийлбэртэй 8 ханатай 8 ширхэг гэр/-ыг байгуулж, үйлчилгээ үзүүлэх



зорилгоор 156.4 сая төгрөгийн үнийн дүнтэй 8 дугаар гэрээг 2016 оны 06 дугаар сарын 6-нд, 197.5 сая төгрөгийн төсөвтэй 104 дугаар гэрээг 2016 оны 06 дугаар сарын 22-нд “Эрсү” ХХК /захирал Б.Эрдэнэсүх/-тай “АСЕМ”-ын БАА /дарга Д.Ганхуяг/-тай байгуулсан байна. Гэрээний дагуу “Эрсү” ХХК-д “АСЕМ”-ын төсвөөс санхүүжүүлжээ.

“АСЕМ”-ын БАА-д дээрх гэрээний дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан акт, танилцуулга байхгүй, ажлын гүйцэтгэлийн тайлан, холбогдох баримт байхгүй байсан тул “Эрсү” ХХК-тай холбогдож анхан шатны баримтаар ажлын гүйцэтгэлийг тулгахад шатахуун, шатах тослох материалын зарцуулалтыг тооцсон нотлох баримт /авто машины замын хуудас, мото цагийн тооцоо зэрэг/-гүй байхгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Мөн тухайн үед бороо их орсноос гэрүүдэд 17.8 сая төгрөгийн борооны уснаас хамгаалах хэрэгсэл берзинт, гялгар уут авах, давхар шал хийх, хөшиг, хаяавч оёулах, орчны цэвэрлэгээний материал авах зэрэгт нэмэлт зардал гарсныг гэрээгүйгээр “АСЕМ” БАА санхүүжүүлсэн байна.

“Гэр хотхон”-д зориулж авсан материал, хөрөнгийг “Эрсү” ХХК нь ГХЯ-д буцааж өгөөгүй, энэ талаар гэрээнд заалт байхгүй гэж тайлбарлаж байгаа ба төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг ГХЯ бүртгэлд тусгаагүй орхигдуулсан нь төсвийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтгүй байсныг харуулж байна.

“АСЕМ Вилла” цогцолборт явагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар

2.3.9 “АСЕМ Вилла” хотхоны хаус, Гольфын гарж үйлчилгээний барилгын авто засварын өрөө, Гольф карт, гольфийн үйлчилгээг “АСЕМ”-ын зочдод зориулж 2016 оны 06 дугаар сарын 25-аас 07 дугаар сарын 19-ны хооронд түрээслэх SR-VS.16-035 дугаартай, 98.0 сая /хөрөнгийн түрээс 55.3 сая, гольфийн олох орлого 42.7 сая/ төгрөгийн гэрээг ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Скай резорт” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Батсуурь нар 2016 оны 07 дугаар сарын 04-нд байгуулж, ГХЯ-аас 98.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Мөн 2016 оны 12 дугаар сарын 07-нд “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас “АСЕМ Вилла” хотхоны эд хөрөнгийн эвдрэлийн засварт 3.1 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Аудитаар тус байгууллагын үзүүлсэн баримтын хүрээнд шалгахад дараах зөрчилтэй асуудлууд байна. Тухайлбал;

- Гэрээний төсвийн тооцоог хийсэн боловч гүйцэтгэлийн тайланг гаргаагүй;
- Эд хөрөнгийн эвдрэл хохирлын актад түрээслэгч гарын үсэг зураагүй;
- Түрээсийн гэрээг БХЯ-тай байгуулсан байхад “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас мөнгийг шийдвэрлэсэн байна.

2.3.10 “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-ын УЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 25-ны 5/16 дугаар хурлын тогтоолоор “АСЕМ”-ын өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчид байрлах “АСЕМ Вилла” цогцолборын тохижилт, бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангаж ажиллах “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг” төслийг “Уран зөн” ТББ-аар хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ.



Дээрх шийдвэрийн дагуу “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ, “Уран зөн” ТББ-тай 2016 оны 04 дүгээр сарын 25-нд “АСЕМ Вилла” хотхоны зочид буудлын үйлчилгээ, сайн дурын ажилтнууд болон бусад холбогдох төслийн ажилтнуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 87.4 сая төгрөгийн үнийн дүнтэй 04/16 дугаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

Зөвлөх үйлчилгээний баг нь төслийн хугацаанд дараах ерөнхий чиглэлийн дагуу гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нэгдсэн мэдээллээр хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх дараах ажлуудыг гүйцэтгэн 87.4 сая төгрөгийг зарцуулжээ.

1. Зөвлөх үйлчилгээний баг, гүйцэтгэгч байгууллагуудын удирдлагын баг болон ажилтнуудад хурал уулзалтын менежмент, зохион байгуулалт, зочид буудлын стандартын сургалт зохион байгуулах;
2. Зөвлөх үйлчилгээний баг, гүйцэтгэгч нарын хариуцсан чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
3. Олон улсын стандарт, холбогдох баримт бичгийг орчуулах, хэвлэн бэлтгэх;
4. Уулзалтыг зохион байгуулах ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллээр хангах.

2.3.11 “АСЕМ”-д оролцох улс орнуудын төрийн тэргүүн, өндөр түвшний зочид төлөөлөгч нарт зочид буудлын цогц үйлчилгээг “АСЕМ Вилла” цогцолборт үзүүлэх ажлыг ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, **“Зогсолтгүй эргэлт”** ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанзул нар 3,437.6 сая төгрөгийн 4 гэрээ байгуулж, ГХЯ-ны “АСЕМ”-ын төсвөөс санхүүжилтийг шилжүүлсэн байна.

“АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас 2016 оны 12 дугаар сарын 07-нд 14.9 сая, төгрөгийг “АСЕМ Вилла” цогцолборын эд хөрөнгийн гэмтэл хохиролд өгсөн байна.

ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА-д дээрх гэрээний биелэлтийг ажил хүлээн авсан акт, гүйцэтгэлийн тайлан байхгүй байсан ба тус компаниас аудитын явцад үзүүлсэн болно.

“Зогсолтгүй эргэлт” ХХК-ийн тайлагнаснаар тус компанийн гэрээт ажлуудыг 71.5 хувийг гүйцэтгэхдээ нийт 14 иргэн, 165 хуулийн этгээдтэй 2,458.1 сая төгрөгийн ажил үйлчилгээг хамтран явуулсан ба эдгээрийн 65 хувь буюу 1,599.1 сая төгрөгийн ажилд 16 туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Харин үлдэх 35.0 хувь /нийт зарцуулсан мөнгөний үнийн дүнгээр тооцсон/ буюу 860.0 сая төгрөгийг гэрээгүйгээр, чухам ямар ажил үйлчилгээ хийснийг тогтоох баримтгүй, баримт зөрүүтэй, алдаатай байна.

“АСЕМ”-ын үйл ажиллагаанд тус компаниас 360.8 сая төгрөгийн өртөгтэй, 531.2 сая төгрөгийн үнэтэй ажил үйлчилгээ нийлүүлсэн гэж тайлагнаж байгаа боловч анхан шатны баримтаар нотлогдохгүй, НББОУС-ын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хэрхэн тусгасан нь тодорхойгүй, өөрийн хөрөнгөөр хийгдсэн ажил үйлчилгээний үнэ, өртгийг гаргаж захиалагчтай тохиролцоогүй, хэрхэн үнэлсэн тодорхойгүй байна.

“АСЕМ Вилла” цогцолборт зохион байгуулсан “Монголхотхон”-ын гүйцэтгэлийн талаар

2.3.12 “АСЕМ”-ын бэлтгэл ажлын хүрээнд “АСЕМ Вилла” цогцолборт “Монголхотхон” байгуулах, үзвэр үйлчилгээ явуулах ажлыг ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга



Д.Ганхуяг, “Урлаг түншлэл” ТББ-ийн тэргүүн О.Ундраа нар 436.6 сая төгрөгийн 7 гэрээ байгуулсан байна.

2016 онд ГХЯ-ны “АСЕМ-ын төсвөөс 373.8 сая, “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас 62.8 сая, нийт 436.6 сая төгрөгийг санхүүжүүлжээ.

“Урлаг түншлэл” ТББ-ын аудитад тайлагнаснаар тус компанийн дээрх гэрээт ажлуудыг хийж гүйцэтгэхдээ нийт 9 иргэн, 12 хуулийн этгээдтэй 218.5 сая төгрөгийн ажил үйлчилгээг гэрээгээр, бусдыг нь гэрээгүйгээр зарцуулсан байна.

Төрийн ордонд зохион байгуулсан хандивын үдэшлэгийн гүйцэтгэлийн талаар

2.3.13 “АСЕМ”-ыг зохион байгуулахад албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг өргөн хүрээгээр оролцуулах зорилгоор “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-ын УЗ-ийн хурлын 2016 оны 3 дугаар сарын 05-ны 4/16 дугаар тогтоолоор 2016 оны 03 дугаар сарын 16-нд Төрийн ордонд 60.0 сая төгрөгийн төсөвтэй хандивын үдэшлэгийг зохион байгуулахаар шийдвэрлэн 2016 оны 03 дугаар сарын 10-нд “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ болон “Лишцэцэг” ХХК хандивын үдэшлэг зохион байгуулах 52.2 сая төгрөгийн төсөвтэй 01/15 дугаар гэрээг байгуулж дараах ажлуудыг хийхээр тохиролцжээ.

- Хандивын үдэшлэгийг зохион байгуулалтыг хариуцаж хийх;
- Сандал ширээ түрээслэх;
- Сандал ширээ болон бусад зүйлсийг тээвэрлэх зардал;
- Хөгжим тоног төхөөрөмж түрээслэх, гэрэлтүүлэг хариуцах;
- Урилга тараах;
- Хандивын үдэшлэг зохион байгуулагчдын хоол унааны зардал;
- Баннер хэвлэл, баннерын суурь хийх;
- Танхим чимэглэх зардал.

Хандивын үдэшлэгийг 2016 оны 03 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Төрийн ордны Их танхимд зохион байгуулж 52.2 сая төгрөгийг зарцуулж, ажлын гүйцэтгэлийг 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дүгнэж акт үйлдсэн байна.

“АСЕМ”-ын үйл ажиллагаатай холбоотой бусад нийтлэг ажлын гүйцэтгэлийн талаар

2.3.14 “Монголын Хүүхэд залуучуудын хөгжлийн сан” ТББ нь “АСЕМ”-ын үйл ажиллагаанд сайн дурынхныг оролцуулахын тулд тэдгээрийг бүртгэн, сонгон шалгаруулж, сургалт хийхээр ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Монголын Хүүхэд залуучуудын хөгжлийн сан” ТББ-ын тэргүүн Ш.Энэбишдорж, гүйцэтгэх захирал З.Цэвэлмаа нар 457.5 сая төгрөгийн 7 гэрээ байгуулсан байна.

Тус байгууллагад “АСЕМ”-ын төсвөөс 367.8 сая, “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас 89.7 сая, ХЭДС-аас 60.5 сая, нийт 518.0 сая төгрөг шилжүүлсэн байна.

Аудитын явцад дээрх хөрөнгийн зарцуулалтыг гэрээний дагуу тайлагнаагүйгээс анхан шатны баримтаар хөөн тулгах боломжгүй байна.

2.3.15 “АСЕМ”-д оролцох улс орнуудын төрийн тэргүүн, өндөр түвшний зочид төлөөлөгч болон үйлчилж буй хүмүүсийг хоол хүнсээр хангах ажлын ГХЯ-ны ТНБД,



“АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “**Номадс Хоспиталита**” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дэжид нар 726.7 сая төгрөгийн 2 гэрээ байгуулж, ГХЯ-ны “АСЕМ-ын төсвөөс нийт 726.7 сая төгрөг шилжүүлсэн байна. Мөн Хятадын төлөөлөгч нарын зоогт 8.4 сая төгрөгийг гэрээгүйгээр ГХЯ-ны “АСЕМ-ын төсвөөс шилжүүлсэн байна.

“Номадс Хоспиталита” ХХК 4 байгууллагуудтай гэрээ хийж 165.4 сая төгрөгийн хоолоор үйлчилсэн байна.

Хүснэгт 12

Гэрээгээр хоолоор үйлчилсэн судалгаа

№	Байгууллаг-ын нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Үнийн дүн /сая.төг/	Төсөвтэй эсэх	Гэрээний хугацаа	Зориулалт
1	ЦЕГ		2016.07...	04/2016-Ун-65	59.4	үгүй	2016.07.07 2016.07.15	4400 хүний хоол
2	ОБЕГ		2016.07...	үгүй	9.0	үгүй	2016.07.07 2016.07.15	1794 хүний хоол
	ХХЕГ		2016.07...	үгүй	8.0	Үгүй	2016.07.07 2016.07.15	228 хүний хоол
2	Их тэнгэр цогцолбор ТӨҮГ		2016.07.18	үгүй	Дүнгүй 50.0		2016.07.17 2016.07.22	2017.07.19-ны Их тэнгэрийн хүлээн авалтад 500 хүн*100.0 мян.төг
3	ТТХГ		2016.07...	үгүй	29.0	29.0	2016.07.07 2016.07.20	ЗХЖШ-654 хүн, ХЦ-71 хүн, нийт 725 хүн*10.0 мян.төг
4	АТҮТ ОНӨҮГ		2016.07.08	ХАГ-16/017	10.0		2016.07.07 2016.07.15	94 хүн*8.0 мян.төг=5.2 сая.төг гүйцэтгэлээр
	Нийт дүн				165.4			

Эх сурвалж: Тус компаниас аудитад ирүүлсэн гэрээнүүд

Тус компани “АСЕМ”-ын үйлчилгээнд оролцогч нийт давхардсан тоо /хоолоор гаргасан хүний тоо/-оор 40,453 хүнд 333.7 сая төгрөгийн хоолоор үйлчилсэн гэж тайлагнасан байна.

Хүснэгт 13

Хүний тоогоор гаргасан судалгаа

№	Үйлчилгээний төрөл	Хүний тоо /давхардсан/	Үнийн дүн /сая.төг/
1	Захилгаар үйлчилсэн	20,820	137.3
2	Сайн дурынхан, ар талд ажиллагсдад	12,392	74,4
3	Төрийн байгууллагад	7,241	122.0
	Нийт дүн	40,453	333.7

Эх сурвалж: Тус компаниас аудитад ирүүлсэн тайлан

Тус компанийн “Зогсолтгүй эргэлт” ХХК-тай 969.6 сая төгрөгийн дараах 5 гэрээг байгуулжээ.

- 2016 оны 05 дугаар сарын 27-нд рестораны хоолоор үйлчлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, материал түрээслэх /дугааргүй/ 285.6 сая төгрөгийн гэрээ /2016 оны 07 дугаар сарын 20-нд эд хөрөнгөө хүлээлгэн өгсөн акт үйлдсэн/;
- 2016 оны 07 дугаар сарын 06-нд зөөгч, тогооч, бусад ажилтнуудын хоолонд 31.4 сая төгрөгийн гэрээ;
- 2016 оны 05 дугаар сарын 25-нд мэргэжлийн ажилтнуудыг хөлсөөр ажиллуулахад 288.4 сая төгрөгийн гэрээ;



- 2016 оны 05 дугаар сарын 31-нд сургалтын байрны түрээсэнд 36.8 сая төгрөгийн гэрээ;
- 2016 оны 07 дугаар сарын 01-нд тусгай арга хэмжээний үйлчилгээнд 327.4 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

2.3.16 **“Ирмүүн агентлаг”** ТББ нь “АСЕМ”-ын ажлын хүрээнд нийт **143.1** сая төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх дараах 3 гэрээг байгуулсан байна.

- “АСЕМ”-ын уулзалтын брэндбүүк, “Mongolica” сэтгүүлийн 10,000ш тусгай дугаар, зочдод тараагдах хэрэгслүүдийг хийхийн тулд тус ТББ нь “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-тай 2016 оны 03 дугаар сарын 03-нд 16/005 дугаартай 64.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.
- 12,000ш сэтгүүл бэлтгэхэд ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг, “Ирмүүн агентлаг” ТББ-ийн тэргүүн А.Батжаргал нар 2016 оны 06 дугаар сарын 9-нд дугааргүй 64.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.
- “Mongol village” 500ш танилцуулга бэлтгэхэд тус байгууллага “Урлаг түншлэл” ТББ-тай 2016 оны 07 дугаар сарын 01-нд 16/034 дугаартай 15.1 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулжээ.

Гэрээний санхүүжилтийн ГХЯ-аас 57.6 сая, “АСЕМ 2016 уулзалтыг дэмжих сан” ТББ-аас 20.0 сая, “Урлаг түншлэл” ТББ-аас 15.1 сая, нийт 92.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Тусгай дугаарын 13,000 ш сэтгүүлийг хэвлүүлэх туслан гүйцэтгэгчийн 16/049 дугаартай гэрээг 2016 оны 07 дугаар сарын 05-нд “Таван Богд менежмент” ХХК-тай 40.0 сая төгрөгийн үнийн дүнгээр байгуулсан байна.

Тус байгууллага гэрээний гүйцэтгэлийг тайлагнаагүй, аудитын явцад нийт 17,407 ш тусгай дугаарын сэтгүүл тараасан гэсэн мэдээлэл өгсөн нь нотлох баримтаар нотлогдохгүй байна.

Аудитаар тус байгууллагын үзүүлсэн баримтын хүрээнд шалгахад дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

- Хийсэн ажлын зарцуулалтын тайланг гэрээгээр гаргаагүй, анхан шатны баримтаар тулгах боломжгүй;
- Тус байгууллагын ирүүлсэн мэдээллээс тараасан сэтгүүл болон гаргасан сэтгүүлийн тоо зөрүүтэй;
- 2016 оны тус байгууллагын санхүүгийн тайланд 776.3 сая төгрөгийн орлого олж, 635.3 сая төгрөгийн зардал гаргасан гэж тайлагнаснаас “АСЕМ”-тай холбоотой анхан шатны баримтыг ялгахад бэрхшээлтэй;
- Гэрээнд захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлага *“гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан болон гэрээгээр хийсэн ажлын гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг гаргаж өгөх, гаргуулан авч хяналт тавих”* гэсэн заалтыг оруулаагүйгээс хяналтгүй зарцуулалт хийгдсэн байна.

Зарим компани ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА-тай ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулан санхүүжилт авсан боловч хийсэн ажлын гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, ГХЯ-нд холбогдох нотлох баримт байхгүй байна.

2.3.17 ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА **“Корпорейт Конвейшн центр”** ХХК-тай 2016 оны 04 дүгээр сарын 25-нд Парламентийн чуулга уулзалтын 207 хүний хүлээн авалтын арга хэмжээ, 2016 оны 06 дугаар сарын 27-нд Бизнесийн чуулга уулзалтын 650 хүний



хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулахаар “үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан ажиллаж, дээрх 2 арга хэмжээнд нийт 88.9 сая төгрөг зарцуулсан байна.

2.3.18 “Асем Вилла” цогцолборт 2000м² талбайд 60 машины зогсоолыг 53.9 сая төгрөгөөр хийлгэхээр “**Түрүү гарав**” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 0116 дугаар “ажил гүйцэтгэх гэрээ”-г ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА, “Түрүү гарав” ХХК-тай байгуулж, ГХЯ-ны ТНБД, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг баталгаажуулсан байна.

Гэрээнд захиалагчийг “ГХЯ” гэж тодорхойлсон байхад гэрээний ерөнхий нөхцөлд “Асем Вилла цогцолборт орших “захиалагч” ГХЯ-ны эзэмшлийн талбай дээр автомашины зогсоол хийх”-ээр тусгагдсан байна. Энэ газар нь “захиалагч” гэх ГХЯ-ны газар биш, “Скай резорт” ХХК-ийн эзэмшлийн газар бөгөөд гэрээнд “Скай резорт” ХХК-аас автомашины зогсоол хийлгэсний төлбөрийг гаргуулах талаар тусгагдаагүй тул *шууд* зардал болгосон байна. Гэрээнд “Түрүү гарав” ХХК-тай холбогдох тодорхой мэдээлэл байхгүйгээс аудитад хамруулж чадаагүй болно.



Бүлэг 3.

“АСЕМ”-д зориулан зарцуулсан банкны зээлийн зарцуулалт, түүний үр дүн

3.1 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулан Хөгжлийн банкны эх үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан зочид буудлуудад олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, гүйцэтгэлд ХБ, СЯ-аас хяналт тавьж тайлагнаагүй байна.

Үндсэн мэдээлэл

МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1³³-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн банкны тухай хууль / тухайн үед мөрдөгдөж байсан/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зээл олгох, авах, 16.2-д “Хөгжлийн банкны хувь нийлүүлэгч нь МУ-ын Засгийн газар байх бөгөөд Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг үндэслэл болгон “АСЕМ”-ын бэлтгэл ажлыг хангах үүднээс хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, үнэт цаас гаргахыг зөвшөөрч дараах тогтоолуудыг гаргасан байна. Үүнд:

- ЗГ-ын 2015 оны 06 дугаар сарын 02-ны 226 дугаар тогтоолоор “АСЕМ”-д оролцох төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 150,0 тэрбум төгрөгийг;
- ЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 17-ны 331 дүгээр тогтоолоор гадаад улсуудын төрийн тэргүүнүүд, өндөр хэмжээний зочид, төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулах “АСЕМ Вилла” цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 125,0 тэрбум төгрөгийг төслийн орлогоос эргэн төлөх нөхцөлтэйгөөр арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлэхийг ХБ-ны ТУЗ-д зөвшөөрсөн байна.
- ЗГ-ын 2015 оны 08 дугаар сарын 24-ны 344 дүгээр тогтоолоор 6 жил хүртэлх хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэй үнэт цаас дотоодын зах зээлд гаргахыг ХБ-д зөвшөөрсөн байна.

ЗГ-ын тогтоолын дагуу ХБ-ны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4, 14 дүгээр зүйлийн 14.1, 18 дугаар зүйлийн 18.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн болон мөнгөний зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах шийдвэрийг бүрэн эрхийн хүрээнд дараах шийдвэрүүд гарчээ. Үүнд:

- ХБ-ны ТУЗ-ын 2015 оны 09 дүгээр сарын 08-ны 71 дүгээр тогтоолоор 275.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ХБ-ны үнэт цаасыг дотоодын арилжааны банкаар дамжуулан 6 жил хүртэлх хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэйгээр арилжаалах, гэрээ хэлцэл байгуулахыг ХБ-ны гүйцэтгэх удирдлага /Н.Мөнхбат/-д зөвшөөрч, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХБ-ны Дотоод аудитын албанд даалгасан байна.
- ХБ-ны ТУЗ-ын 2015 оны 09 дүгээр сарын 08-ны 72 дугаар тогтоолоор “АСЕМ Вилла” цогцолборт 125.0 тэрбум төгрөгийн жилийн 4,5 хувийн хүүтэй, 6 жил хүртэлх хугацаатай зээлийг ХХБ-аар дамжуулан олгож гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна.
- ХБ-ны ТУЗ-ын 2015 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “АСЕМ”-д оролцох төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад 150.0 тэрбум хүртэлх төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг жилийн 4,5 хувийн хүүтэй, 6 жил

³³ Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана.



хүртэлх хугацаатай /дэд зээлийг 1 зочид буудалд 30,0 тэрбум төгрөг хүртэл, жилийн 8 хувийн хүүтэй/-гаар ХХБ, Хас, Улаанбаатар, Голомт банкаар дамжуулан олгох гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна. Мөн 2015 оны 11 дүгээр сарын 10-ны 87 дугаар тогтоолоор ХААН банк, 2016 оны 5 дугаар сарын 6-ны 40 дүгээр тогтоолоор Төрийн банкныг зээлдэгчээр тус тус нэмсэн байна.

- “АСЕМ Вилла” цогцолборт олгож буй зээлийн хувьд ХБ-ны ТУЗ-ын 2016 оны 02 дугаар сарын 29-ны 19 дүгээр тогтоолоор 2015 оны 72 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн зээлийн хугацаа хэсэгт энэхүү тогтоол батлагдах өдрийн олгоогүй үлдэгдэл зээлийн хувьд “үнэт цаас буцаан худалдан авах гэрээ (репо)”-ний буцаан худалдан авах өдөртэй адил гэж, дэд зээлийн хүү хэсгийг “Зээлийн хүү(4.5 хувь)+ зээлдэгчийн маржин(“ Үнэт цаас буцаан худалдан авах гэрээ(репо)”-ний хүүгээс хамаарна)” гэж тус тус өөрчлөн, холбогдох гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг ХБ-ны гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсөн байна.

3.1.1 ХБ арилжааны банкнуудтай үнэт цаасыг жилийн 4 хувийн хүүтэйгээр худалдсан бөгөөд ХБ-аас арилжааны банктai дамжуулан зээлийн жилийн хүүг 4.5 хувиар тооцсон байна. Харин арилжааны банкнууд дэд зээлдэгч болох компаниудтай жилийн 13-14 хувийн хүүтэй гэрээ хийжээ. Энэхүү хүүг тооцохдоо суурь /4.5/ хувь дээр үнэт цаасны өртөг /4 хувь/ болон зээлдэгчийн маржин нэмсэн байна. ХБ энэхүү хүүгийн нэмэлтийг дээр дурдсанаар “АСЕМ Вилла” цогцолборын зээлд зөвшөөрч 2016 онд ТУЗ-ын 19 дүгээр тогтоол гарч бусад зочид буудлын зээлтэй холбоотой ХБ-аас гаргасан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

3.1.2 Дээр дурдсан эрх зүйн шийдвэрийн хүрээнд ХБ-ны татан төвлөрүүлсэн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр арилжааны банкнууд аж ахуйн нэгж /зочид буудал/-үүдтэй байгуулсан “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний үндсэн дээр дараах зээлийг олгосон байна.

Хүснэгт 14

Зээлийн судалгаа

№	Зээлдэгч банк	Дэд зээлдэгч	Төслийн нэр	Олгосон зээлийн дүн /сая.төг/
1	Худалдаа хөгжлийн банк	Скай Резорт ХХК	АСЕМ Вилла цогцолбор	125,000.0
2		Макс ложинг ХХК	Рамада зочид буудал	2,500.0
3		Макс хотелс ХХК	Холидэй Инн Улаанбаатар	24,496.1
4		Пума империал ХХК	Империал зочид буудал	21,384.0
5		Хурд интернэшнл ХХК	Foir Point by Sheraton	14,000.0
6		Сэлбэ плаза ХХК	UB City зочид буудал	967.8
7		Хасэбэ-интернэшнл ХХК	Цэцэг зочид буудал	1,612.5
		Дүн		189,960.4
8	Голомт банк	Чингис хаан цогцолбор ХХК	Чингис зочид буудал	9,400.0
9		Дизайнер клуб ХХК	Спрингс зочид буудал	303.1
10		Номадс Резиденс ХХК	Notel nine Ulaanbaatar	12,296.9
		Дүн		22,000.0
11	Улаанбаатар банк	Сити тоувер хотел ХХК	City tower зочид буудал	11,320.0
		Дүн		11,320.0
12	ХААН банк	Амури Оргил ХХК	Grand Hill зочид буудал	900.0
13		Премиум Палас Улаанбаатар	Премиум Палас ХХК	
14		Континснтал ХХК	Континснтал зочид буудал	800.0
15		Хаан палас ХХК	Кэмпински зочид буудал	729.0
		Дүн		2,429.0
16	Төрийн банк	Чингис хааны хүрээ ХХК	Чингис хүрээ цогцолбор	6,500.0
17		Мика интерпрайз ХХК	Мика зочид буудал	1,216.0
		Дүн		7,716.0
НИЙТ ДҮН				233,425.4

Эх сурвалж: аудитын ажлын баримт



ХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйл 8.2³⁴-/ *тухайн үед үйлчилж байсан*/ - д заасны дагуу ХБ-ны Актив Пассивын удирдлагын хороо болон Зээлийн хорооны болон арилжааны банкнууд зээлдэгч, холбогдох хуулийн этгээдэд зээл олгох хурлын шийдвэр гарсныг үндэслэн зээл олгогдсон байна.

3.1.3 ЗГ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2³⁵, ЗГ-ын 2015 оны 226, 344 -р тогтоолыг үндэслэн Сангийн сайд 2015 онд 241 дүгээр тушаалаар “*Ази Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам*”-ыг баталж гаргасан байна. Энэхүү журамд:

- “АСЕМ”-ын дээд түвшний уулзалтын зочдыг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 150,0 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтийг ХБ-ны татан төвлөрүүлсэн эх үүсвэрээс, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр арилжааны банкаар дамжуулан “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний үндсэн дээр олгохоор, 6 хүртэл жилийн хугацаатайгаар, жилийн 9 хувиас илүүгүй хүүтэй, 1 зочид буудалд 30,0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байхаар, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхгүй байх нөхцөлтэй байхаар журамласан байна.
- Арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг өөрийн дотоод үйл ажиллагааны жишгийн дагуу зочид буудлуудад эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн төлөх чадварыг тогтоож, зээл олгох шийдвэр гаргасан байх, эх үүсвэрийн ашиглалт, хэрэгжилтийн тайланг ХБ-д сар бүр ирүүлж байх, “АСЕМ”-ийн дээд түвшний уулзалтыг хүлээн авах төлөвлөгөө, төсөлтэй, зээлийг эргэн төлөх чадвартай байх шаардлага тавьсан байна.
- Мөн энэхүү журмаар эх үүсвэрийн зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд 2015 оны 17 дугаар захирамжаар батлагдсан байр, зочид буудлын асуудал хариуцсан ажлын хэсэг болон ХБ хяналт тавихаар, зээлийг зориулалт бусаар ашигласан, зочид хүлээн авах төсөл хэрэгжээгүй нь тогтоогдвол хууль тогтоомж, гэрээнд заасан дагуу банкны албан тушаалтанд хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тус тус хариуцлага хүлээлгэхээр заасан байна.
- Энэхүү журмын хэрэгжилтэд СЯ-ны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /дарга Н.Цэрэнбат/, Санхүүгийн бодлогын газар /дарга Б.Нямаа/ хяналт тавьж ажиллах ёстой байсан боловч хэрхэн хяналт тавьсан нь тодорхойгүй байна.

Энэ журмын 5.1-д “АСЕМ”-ын байр, зочид буудлын асуудал хариуцсан ажлын хэсэг /түр хугацаанд байгуулагдсан/ зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихаар оруулсан байна. Гэтэл зочид буудалд олгож буй зээл 6 жилийн хугацаатай байна. Арилжааны банкнуудын хэрэгжүүлэх чиг үүргийг заасан тус журмын 3.1.3-т “*эх үүсвэрийн ашиглалт, хэрэгжилтийн тайланг ХБ-д сар бүр ирүүлэх*” гэсэн заалт хэрэгжихгүй байхад ХБ анхаарал хандуулаагүй байна.

3.1.4 Дээрх журамд болон ХБ-ны ТУЗ-ын 2015 оны 71, 72, 73 дугаар тогтоолын 3 дугаар заалтад зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихыг ХБ буюу ХБ-ны Дотоод аудитын албанд үүрэг болгосон боловч хэрэгжээгүй байна.

³⁴ 8.2.Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивын болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана.

³⁵ Хэрэв эрхэлсэн асуудлынхаа хүрээнд шийдвэрлэх гэж байгаа асуудал нь бусад хүрээнийхтэй шууд холбоотой бол Засгийн газрын холбогдох гишүүдтэй урьдчилан тохиролцож зохицуулсан байвал зохино. Засгийн газрын гишүүд удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар хамтарсан тушаал гаргаж болно.



3.1.5 Аудитын явцад ХААН банк, ХХБ, Улаанбаатар хотын банк, Голомт банк, Төрийн банкнаас дэд зээлдэгч нарын зээлийн ашиглалтын талаарх мэдээлэл авахаар 2018 оны 02 дугаар сарын 12-ны 01/356 дугаар албан бичгээр хандсан боловч Голомт, Улаанбаатар хотын банкнаас бусад нь мэдээлэл ирүүлээгүй бөгөөд дэд зээлдэгч 17 компаниас “Амури Оргил” ХХК, “Континентал” ХХК, “Хаан палас” ХХК, “Хасэбэ-интернэшнл” ХХК, “Чингис хаан цогцолбор” ХХК, “Дизайнер клуб” ХХК, “Номадс Резиденс” ХХК “Скай Резорт” ХХК зэрэг 8 компани аудитад хамрагдсан болно.

3.1.6 ЗГ-ын 2015 оны 8 дугаар сарын 17-ны 331 дүгээр тогтоолоор Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын үеэр гадаад улсуудын төрийн тэргүүнүүд, өндөр хэмжээний зочид, төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулах “АСЕМ Вилла” цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 125.0 тэрбум төгрөгийг төслийн орлогоос эргэн төлөх нөхцөлтэйгөөр арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны ТУЗ-д зөвшөөрчээ.

ЗГ-ын 2015 оны 344, 226, 331 дүгээр тогтоолоор 6 жил хүртэлх хугацаатай, 4 хувийн хүүтэй үнэт цаас дотоодын зах зээлд гаргахыг Хөгжлийн банкны ТУЗ-д зөвшөөрсний дагуу Хөгжлийн банкны ТУЗ-ын 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор зочид төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад болон “АСЕМ Вилла” цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор нийт 275.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн дүн бүхий Хөгжлийн банкны үнэт цаасыг дотоодын арилжааны банкаар дамжуулан 6 жил хүртэлх хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэйгээр арилжаалж, холбогдох гэрээ хэлцлийг байгуулахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн байна.

Мөн Хөгжлийн банкны ТУЗ-ын 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 72 дугаар тогтоолоор “АСЕМ Вилла” цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 125.0 тэрбум төгрөгийн зээлийг, жилийн 4,5 хувийн хүүтэй, нэмэгдүүлсэн хүү нь үндсэн зээлийн хүүгийн 20 хувь, 6 жил хүртэлх хугацаатай, дэд зээлийн хүү 8 хувь, зээлийг бэлэн бусаар төгрөгөөр олгохоор шийдвэрлэсэн байна.

2015 оны 9 дүгээр сарын 25-нд ХБ, ХХБ-тай З-АС-С2015-76 дугаартай /дэд зээлдэгч “Скай резорт” ХХК, зээлийн дүн 125.0 тэрбум төгрөг, хүү жилийн 4.5 хувь, 6 жил хүртэлх хугацаатай/ дамжуулан зээлийн гэрээ хийсэн байна. Энэхүү гэрээнд 2016 оны 03 дугаар сарын 01-нд эхний ээлжид 60.0 тэрбум төгрөгийг жилийн 8.0 хувийн хүүтэй, дараагийн 65.0 тэрбум төгрөгийг жилийн 4.5 хувийн хүүдээр зээлдэгчийн маржин³⁶-ний хүүгээс хамааран нэмэгдүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулжээ.

“Скай резорт” ХХК нь ХХБ-тай 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр 125.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 60.0 тэрбум төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай, 65.0 тэрбум төгрөгийг жилийн 11.5 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай гэрээ байгуулан өөрийн өмчлөлийн 249.4 тэрбум төгрөгийн балансын үнэтэй хөрөнгө, 53 ш хаус болон 2 давхар клуб хаусыг дэд бүтцийн хамт барьцаалсан байна.

Зээлийн 60.0 тэрбум төгрөгийг 2015 оны 9 дүгээр сарын 25-нд, 55.0 тэрбум төгрөгийг 2016 оны 03 дугаар сарын 04-нд, 10.0 тэрбум төгрөгийг 2016 оны 5 дугаар сарын 5-нд олгосон байна.

³⁶ Үнэт цаас буцаан худалдан авах гэрээ (репо)-ний хүү



“Скай резорт” ХХК-ийн тайлагнаснаар 2018 оны 03 дугаар сарын 19-ны байдлаар 125.0 тэрбум төгрөгийн зээлийн хүүд 23.8 тэрбум төгрөг төлсөн ба 95.1 тэрбум үндсэн зээлийн төлөөгүй үлдэгдэл байна.

Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Богд Хан Уул, Хүрхрээгийн аманд 20,832 м.кв талбайтай 53 ширхэг Вилла, 2,306 м.кв талбайтай 1 ширхэг клуб хаус бүхий, нийт 23,138 м.кв талбайтай “Скай Вилла” цогцолборын барилга угсралтын ажлыг тус цогцолборын газрын гүний дулааны насос, доторх дэд бүтэц болон гадна дэд бүтцийн хамт /Скай Вилла цогцолборын хашаанаас гадна байрлах дэд бүтэц/ гүйцэтгүүлэхээр ерөнхий гүйцэтгэгч “М-Си-Эс Проперти” ХХК-тай 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр SR-C-15-001 дугаартай 126.2 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан бөгөөд 2016 оны 8 дугаар сарын 2-нд гэрээний дүнг 895.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт гэрээний дүнг 127.1 тэрбум төгрөг болгосон байна.

“АСЕМ Вилла” цогцолборын газар “Марриот” ХХК-ийн эзэмшилд байдаг ба газар ашиглах 2015/193 дугаартай гэрчилгээг 2015 оны 07 дугаар сарын 08-нд авсан бөгөөд УБ хотын Баянзүрх дүүргийн Засаг дарга /Д.Пүрэвдаваа/, Богдхан уулын дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны дарга /Ц.Ширэндэв/, “Марриот” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Батсуурь нар 2015 оны 08 дугаар сарын 05-нд 2015/112 дугаар газар ашиглах гэрээ байгуулснаар БЗД-ын Богдхан уулын дархан цаазат газрын хилийн зааг дотор “Хүрхрээ”-гийн амны хязгаарлалтын бүсэд амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 4 га газрыг 2015 оны 08 дугаар сарын 06-аас 2020 оны 07 дугаар сарын 08-ны хүртэл эзэмшүүлсэн байна.

ХБ-ны эх үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийн дээрх асуудлуудыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.2 БНСУ-ын Экспорт-импортын банкны зээлээр авсан 43 автобусыг “АСЕМ”-ын үйлчилгээнд бүгдийг ашиглах шаардлагагүй байжээ.

Үндсэн мэдээлэл

Эдийн Засгийн Хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2011-2015 онд авах зээлийн тухай МУ-ын ЗГ /Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Сангийн сайд Б.Болор/, БНСУ-ын ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд ашиглагдаагүй үлдэгдэл 244.5 сая ам долларын хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг ЗГ-ын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 459 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг төслийн хүрээнд 30.5 сая ам долларын өртөг бүхий 300 автобусыг зээлийн хөрөнгөөр худалдан авахаар тусгасан байна.

Сангийн яам /Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Гантулга/, Зам тээврийн яам /АЗТБХЗГ-ын автотээврийн хэлтсийн дарга Т.Зулзүсэм/ нар БНСУ-ын Экспорт-Импортын банктай 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “АСЕМ”-ын үйл ажиллагаанд болон зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглах автобусыг худалдан авахад зориулж 5.5 сая ам долларын, жилийн 0.25 хувийн хүүтэй зээл авах талаар уулзалт хийсэн байна.

Дээрх уулзалтаар тохиролцсоны дагуу Сангийн яам /сайд Б.Болор/, БНСУ-ын Экспорт-Импортын банк 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл” /Мон-10/ ба “Хот хоорондын



нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл" /Мон-9/-ийн 5.5 сая ам долларын зээлийн гэрээ байгуулсан байна.

3.2.1 ЗТС /М.Зоригт/-ын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 47 дугаар тушаалаар "АСЕМ"-ын дээд түвшний уулзалтын төлөөлөгч нарт үйлчлэх автобусны үйлчилгээг чанар болон аюулгүй байдал соёлын өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /СБНХАГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ю.Өлзийжаргал/-д үүрэг болгожээ.

Зам тээврийн яамны ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/-ын 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тушаалаар автобус нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүн³⁷-ий бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Тус үнэлгээний хороо нь БНСУ-ын Экспорт-Импортын банк болон Тээврийн аюулгүй байдлын газраас "Hyundai motor company", "Kia motors corporation" компанийг санал болгож ирүүлсэн үнийн саналыг харьцуулах замаар хамгийн бага сайн үнийн санал ирүүлсэн "Hyundai motor company" шалгаруулж, нэг бүр нь 127,680 ам доллар, нийт 5,490.240 ам долларт багтаан гэрээ хийх зөвлөмжийг 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ЗТЯ-ны ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/-д хүргүүлсэн байна.

3.2.2 ЗТЯ, БНСУ-ын "Хьюндай моторс" компанитай 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 112 дугаар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байна.

"Хьюндай моторс" компаниас 43 автобусыг хүлээн авч, ЗТЯ-ны ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/-ын 2016 оны 206 дугаар тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй, "АТҮТ" ТӨҮГ-ын дэд захирал /Д.Батбаатар/-ын 2016 оны А/166 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс тус тус томилогдон 2016 оны 06 дугаар сарын 24-нд 01 дугаар акт үйлдэн 43 автобусыг хүлээн авч "АТҮТ" ТӨҮГ-ын дэд захирлын 2016 оны А/166 дугаар тушаалын 2 дугаар хэсэгт заасны дагуу "АСЕМ"-д үйлчлэх жолооч нарт акт үйлдэн автобус бүрийг хүлээлгэн өгсөн байна.

3.2.3 "АСЕМ"-ын үйлчилгээнд зориулж "АТҮТ" ТӨҮГ-аас автобус бүрд улсын дугаар, бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн даатгал, GPS, хөшиг, суудлын бүрээс, тээврийн хэрэгслийн даатгал, жолооч нарт "АСЕМ"-ын логотой ажлын хувцас, жолоочийн хариуцлагын даатгал, цалин хөлс, хоол, эмчийн үзлэг гэх мэт зардалд 195.0 сая төгрөгийн нэмэлт зардал гарсан байна. *Тухайлбал;*

- 43 автобусанд үндсэн 43 жолооч, ээлжийн 4 жолооч ажиллаж цалинжуулсан ба цалинд "АСЕМ 2016 дэмжих сан" ТББ-аас 17.5 сая, "АТҮТ" ТӨҮГ-аас 45.7 сая, нийт 63.2 сая төгрөг санхүүжүүлжээ.
- Автобусны шатахууны зардалд ГХЯ-аас 15.0 сая төгрөг ба 10.0 сая төгрөгийн шатахууны талон авсан бөгөөд "АСЕМ"-ын үйлчилгээнд 43 автобус нийт 7,774 км гүйлт гарч, 10.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Автобус бүрд зарцуулагдаагүй нийт 4.2 сая төгрөгийн шатахууны үлдэгдэл байна. Харин ГХЯ-аас ирсэн санхүүжилтээс 10.0 сая төгрөгийг "АСЕМ"-ын бус зардалд зарцуулсан байна.
- "АСЕМ"-ын үйл ажиллагаа явагдсан 16 чиглэлд 43 автобус 2016 оны 07 дугаар сарын 02-18-ны хооронд 16 өдөр үйлчилсэн байна. Бүх автобус өдөр бүр үйлчилгээнд гараагүйгээс гадна нийт 4,734 зочид тээвэрлэсэнг автобусны суудал³⁸-ын тоотой харьцуулахад 15.3 хувийг ашигласан байна. *Тухайлбал,*

³⁷ Д.Доржханд, Б.Нямдорж, Б.Өлзийжаргал, Т.Баясгалан, Б.Одонтуяа

³⁸ Автобус 45 хүний суудалтай 45*43*16=30960 хүн



- 2016 оны 07 дугаар сарын 2-ны өдөр “Нисэх-зочид буудал” гэсэн 1 чиглэлд УНЗ 4118 улсын дугаартай автобус 15 хүн тээвэрлэсэн бол ³⁹ хамгийн ихдээ л 2016 оны 07 дугаар сарын 15-нд 39 автобус үйлчилгээнд гарч 1,768 хүн тээвэрлэсэн байна.
- “АТҮТ” / захирал Н.Пунцаг, СХОГ-н дарга Ш.Баяраа/ ОХУ-ын “Веком” компанитай 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 51.4 сая төгрөгийн 150 ш терминал ASC-7S ext тоног төхөөрөмжийг холбогдох дагалдах хэрэгслийн хамт худалдан авахаар ХХАГ 16/010 дугаар гэрээ /шууд/ байгуулан хүлээн авч бүртгэлд тусгажээ. Энэхүү тоног төхөөрөмжөөс 52 ш-г ЦЕГ-ын авто баазын “Toyota Prius 30” маркийн авто машинд, 43 ш-г АТҮТ-ийн 43 автобусанд суулгасан байна. Гэвч эдгээрийг хүлээлгэн өгсөн, авсан болон ашиглалтын талаар тодорхой баримт байхгүй байна.
- Мөн ОХУ-ын “Веком” компанитай 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 110.9 сая төгрөгийн GSM болон GPRS технологийн дэмжлэгтэй тээврийн хэрэгслийн хяналтын “Wialon Local” программыг худалдан авахаар ЛГ-16/001 дугаар гэрээ /шууд/ байгуулан хүлээн авч зохих шийдвэргүйгээр бүртгэлд тусгасан байна. Одоогоор орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээний хяналтад ашиглаж байгаа гэж тайлбар өгсөн.

3.2.4 “АТҮТ” ТӨҮГ-ын нэр дээр 43 автобусанд улсын дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээ гаргасан боловч эдгээр автобусыг бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.5 “АСЕМ”-ын үйлчилгээнд явсны дараа автобусуудыг нэг сарын хугацаатай хадгалуулахаар 2016 оны 10 дугаар сарын 14-нд “АТҮТ” ТӨҮГ-ын Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Д.Батбаяр, мэргэжилтэн Э.Жанцалдулам нар акт үйлдэж, 43 автобусыг жагсаалтаар, гэрээ байгуулалгүйгээр “Тэнүүн огоо” ХХК-д хүлээлгэн өгч нэг жил хадгалуулсан байна.

“Тэнүүн огоо” ХХК 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 42 автобусыг хүлээлгэн өгсөн баримт үйлдэлгүйгээр ЗТХЯ-ны өмнөх талбай /авто зогсоол/-д авчирч байршуулж, нэг жил хадгалсны дулаан агуулахын төлбөр 69.0 сая төгрөгийг нэхэмжлэн, төлбөрийг шийдэх хүртэл нэг автобусыг барьцаанд авсан бөгөөд 2018 оны 2 дугаар сарын 14-д барьцааны автобусыг буцаан авсан байна.

“АТҮТ” ТӨҮГ-ын захирал /Х.Дэлгэрнаран/-ын 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/309 дүгээр тушаалаар автобусыг хадгалах, хүлээлгэн өгөх 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилсон байна. Уг комисс “Эрдэм транс” ХХК-тай автобусыг хадгалах, хадгалуулах тухай ТГ17/015 дугаар гэрээ байгуулж 43 автобусыг тус компанийн гадна талбайд жагсаалтаар хүлээлгэж өгсөн байна. Тухайн үед жагсаалтад 43 автобуснаас 7 автобусны GPS, 1 автобусны антен, 2 телевизийн удирдлага, 4 хөгжмийн удирдлага, 5 автобусны дугуйн колбак дутагдсан байна.

3.2.6 ЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 198 дугаар тогтоолоор “Улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд ирсэн 43 автобус болон 2 дахь үе шатанд нийлүүлэгдэх автобусны төлбөрийн жилийн хүү

³⁹ АТҮТ-өөс гаргаж өгсөн судалгаагаар



2.25 хувь, хугацааг 12 жил хүртэл байхаар гэрээний нөхцөлийг тооцож дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулахыг Сангийн сайд /Б.Чойжилсүрэн/-д зөвшөөрсний дагуу арилжааны банкуудаас зээлийн бүтээгдэхүүний санал авсны үндсэн дээр Хөгжлийн банкны “Ди Би Эм Лизинг” /лизингийн /ХХК, “Чингис хаан банк” ХХК-ийг сонгон Сангийн яамны ТНБД /Б.Нямаа/-ын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 8-3/5896 дугаар албан бичгээр ЗТХС /сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Ганбат/-д мэдэгдсэн байна.

Сангийн яамнаас /БНСУ-ын Экспорт-Импортын банкнаас хөнгөлөлттэй авсан зээлийг төлөх 30 жилийн үнийг өнөөгийн мөнгөний үнэ цэнээр тооцоолон/ нэг автобусны үнийг 270.0 сая төгрөг байхаар тогтоож, ЗТХС-д 2017 оны 11 дүгээр сарын 16-нд Сангийн сайдын 8-3/6493 албан бичгээр “дамжуулан зээлдүүлэх гэрээ хийх нь зүйтэй” гэж үзэн мэдэгдсэн байна.

3.2.7 Зам тээврийн хөгжлийн яам 2017 оны 12 дугаар сарын 15-нд “Чингис хаан банк” ХХК-тай 117 дугаар, “Ди Би Эм Лизинг” ХХК-тай 116 дугаар дамжуулан зээлдүүлэх гэрээг тус тус байгуулсан байна.

2018 оны 03 дугаар сарын 01-ний байдлаар аудитаар хяналтын тооллого хийхэд “Эрдэм транс” ХХК-ийн дулаан агуулахад 21 автобус байсан бөгөөд 2018 оны 3 дугаар сарын 5-ны байдлаар “Ди Би Эм лизинг” ХХК 31 автобусийг дараах байгууллагуудад зээлээр худалдсан байна.

Хүснэгт 15

Худалдсан автобусны судалгаа

№	Худалдан авсан байгууллагын нэр	Автобусны тоо	Үнийг дүн /сая,төг/	Тайлбар /төлбөрийн нөхцөл/
1	“Атибус” ХХК	3ш	810.0	
2	“Эрдэм транс” ХХК	2ш	540.0	
3	“Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК	2ш	540.0	
4	“Шивээ овоо” ХХК	2ш	540.0	
5	“Тээвэр ачлал” ХХК	2ш	540.0	
6	“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК	1ш	270.0	
7	Ач буян тревэл ХХК	2ш	540.0	
8	Минтранс ХХК	1ш	270.0	
9	Цагдаагийн ерөнхий газар	5ш	1350.0	
10	ИНЕГ	6ш	1620.0	
11	Авлигатай тэмцэх газар	2ш	540.0	
12	Батлан хамгаалах яам	3ш	810.0	Гэрээ баталгаажаагүй байна.
Нийт 31ш			8,370.0	

Эх сурвалж: аудиторын ажлын баримт

Төсөвт байгууллагуудын авсан нийт 10ш автобусыг лизингээр /зээлээр/ авахыг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн акт байхгүй байна.

- АТГ нь 2018 оны 02 дугаар сарын 26-ны 18/04 дугаар гэрээгээр 2ш автобусыг 540.0 сая төгрөгөөр, жилийн 4.5 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай зээлээр;
- ЦЕГ 5ш, БХЯ 3ш автобусыг “Ди Би Эм лизинг” ХХК-тай гэрээ хийгээгүйгээр “Эрдэм транс” ХХК-аас авсан байна.

3.2.8 Улсын төсвөөс БНСУ-ын Экспорт-Импортын банканд гэрээний дагуу 2016-2017 онд зээлийн хүүд 20,625 ам доллар буюу 50.5 сая төгрөг төлөхөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 14,352 ам доллар буюу 35.2 сая төгрөгийг төлж, 6,273.0 ам доллар буюу 15.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх БНСУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөтэй холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.



Бүлэг 4.

"АСЕМ"-ын үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламжийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал

Үндсэн мэдээлэл

"АСЕМ"-ын үйл ажиллагаанд БНХАУ, БНСУ-ын Олон Улсын "Койка" байгууллагаас нийт 20.4 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн тусламжаар ирсэн бол Сингапур, Тайланд, Бельги улсад тусламжаар үнэ төлбөргүй сургалтад оролцсон, 1,8 тэрбум төгрөгийн мөнгөн болон бусад хэлбэрийн хандивыг иргэн, хуулийн этгээдээс хандивласан байна.

Хүснэгт 16

Хандив, тусламжийн судалгаа

/сая.төг/

Хандив, тусламж авсан байгууллагын тоо	Хандив тусламж				НИЙТ ХАНДИВ ТУСЛАМЖ
	БНХАУ Тавилга, тоног төхөөрөмж бараа материал	БНСУ Бараа материал	Иргэн, хуулийн этгээд Мөнгө	Автомашин, бензин талон	
41	17,999.3	2,311.5	1,753.4	99.9	22,164.1

Эх сурвалж: аудитын ажлын баримт

4.1 "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зориулж БНХАУ-с ирүүлсэн буцалтгүй тусламжийн хөрөнгийг ажлын хэсэг томилон хүлээн аваагүй, тэдгээрийг зохих байгууллагын шийдвэргүйгээр тараасан байна.

Үндсэн мэдээлэл

ГХС-ын 2016 оны 02 дугаар сарын 29-ний А/17 дугаар тушаалаар "АСЕМ"-ыг зохион байгуулахтай холбогдуулан "АСЕМ"-ын түнш улсуудаас үзүүлэх техникийн буцалтгүй тусламж, тоног төхөөрөмжийг хүлээн авах, зохицуулах ажлын хэсгийг нийт 11 /ЕТГ, ГХЯ, ХЗЯ, ТТХГ, ЦЕГ, ИНЕГ, ОБЕГ, ГТЕГ, НЗАА, Монголын Зочид буудлын холбоо/ хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч энэхүү ажлын хэсгийн хийсэн ажлын талаар баримт материал байхгүй байна.

2016 оны 03 дугаар сарын 16-ны "АСЕМ"-ыг зохион байгуулах, чиг үүргээр хангах "Үндэсний зөвлөл"-ийн 19 дүгээр хуралдаанаар БНХАУ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд ирэх зочид буудлын тавилгыг зочид буудлуудад худалдах талаар хэлэлцэж, энэ асуудлыг шийдвэрлээд эргэж танилцуулахыг ЕТГ-ын дарга П.Цагаан, Ерөнхийлөгчийн зөвлөх А.Баттөр, "АСЕМ"-ын БАА-ны орлогч дарга Б.Баясгалан нарт үүрэг болгосон байна.

2016 оны 03 дугаар сарын 30-ны "Үндэсний зөвлөл"-ийн 21 дүгээр хуралдаанаар БНХАУ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд ирэх зочид буудлын тавилга, тоног төхөөрөмжийн хуваарилалтын тухай хэлэлцэж, зочид буудлуудад үнийн дүнгээс 50 хувиар багасган, 30 хувийг бэлнээр төлж, үлдэгдэл 20 хувийг 2016 онд багтаан төлөх зарчмаар ажиллахыг Ерөнхийлөгчийн зөвлөх А.Баттөрд үүрэг болгожээ.

2016 оны 05 дугаар сарын 11-ний "Үндэсний зөвлөл"-ийн 26 дугаар хуралдаанаар "АСЕМ"-ын үеэр ашигласан хандиваар болон "АСЕМ"-ын төсвөөс худалдан авсан тоног төхөөрөмж, эд материалын бүртгэлийг ГХЯ-ны ДБҮЭГ-т хариуцуулсан байна.



"АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 2016 оны 05 дугаар сарын 25-аас 06 дугаар сарын 27-ны өдрүүдэд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар нийт 126 вагон /чингэлэг/, онгоц /1 удаагийн/-оор зочид буудлын иж бүрдэл тавилга, цагаан хэрэгсэл, албан тасалгааны тавилга, хурлын орчуулгын тоног төхөөрөмжүүд ирсэн байна.

4.1.1 ГХЯ, "АСЕМ"-ын БАА-аас БНХАУ-ын буцалтгүй тусламжаар вагоноор ирэх хөрөнгийг хүлээн авах комиссыг албан ёсоор томилоогүй, "АСЕМ"-ын гэрээт нярав Д.Амгаланг тээвэр зуучийн компанийн "терминал дээр очиж хүлээж ав" гэсэн ГХЯ-ны мэргэжилтэн, "АСЕМ"-ын БАА-ны нягтлан бодогч С.Амарсанаагийн аман шийдвэрээр сайн дурын ажилтан оюутан хүүхдүүдийн хамт хүлээн авч, тараасан ба зарим хөрөнгийг ДБҮЭГ-ын нярав н.Мөнхжаргал хүлээн авч тараасан боловч хүлээн авсан талаар акт үйлдээгүй, тараахдаа гар бичмэлээр гарын үсэг зуруулж өгсөн гэж тайлбарлаж байна.

4.1.2 Гаалийн 43 үндсэн, 28 нэмэлт мэдүүлгийг үндэслэн аудитаар тулгахад буцалтгүй тусламжийн хүрээнд ирсэн дээрх чингэлгүүдэд ерөнхийлөгчийн өрөөний 30, люкс өрөөний 232, стандарт өрөөний 316, нийт 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, 13773ш цагаан хэрэглэл (дэр, дэрний уут, гарын алчуур, матрасны углаа, ор, хөнжлийн даавуу, ванны алчуур, толгойн алчуур гэх мэт), 5456ш албан тасалгааны тавилга, эд хогшил, хуралдаан зохион байгуулахад ашиглах орчуулгын зориулалттай тоног төхөөрөмж 5,852.3 сая төгрөг /гаалийн мэдүүлгээр/ төгрөгийн тоног төхөөрөмж ирснийг "АСЕМ"-ын БАА хүлээж авсан байна.

4.1.3 "АСЕМ"-ын гэрээт нярав Д.Амгалан нь ТӨБЗГ-аас албан ёсны тогтоол шийдвэр гараагүй байхад 2016 оны 8,9 дүгээр саруудад ТӨБЗГ-ын аман болон албан ёсны биш цохолттой бичгээр зочид буудлын 475 иж бүрдэл /стандарт өрөөний 241, люкс өрөөний 206, ерөнхийлөгчийн өрөөний 28/ тавилгуудыг "АСЕМ"-ын түнш зочид буудлууд болон хувь хүн, ААН-д 1.171.4 сая төгрөгөөр, 670 ш албан тасалгааны тавилга эд хогшлыг 102.2 сая төгрөгөөр байгууллага, хувь хүмүүст худалдсан, зочид буудлын 103 ком /стандарт өрөөний 75, люкс өрөөний 26, ерөнхийлөгчийн өрөөний 2/ тавилгуудыг 233.8 сая төгрөгөөр, албаны зориулалттай нийт 4784ш тавилга, тоног төхөөрөмжийг нийт 34 төсвийн болон ТӨҮГ-уудад /596.9⁴⁰ сая төгрөг/ үнэ төлбөргүй шилжүүлсэн зэрэг нь ТБОНӨТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.1.4 ТӨБЗГ-ын мэргэжилтэн Д.Нарангэрэлийн ам шийдвэрээр нярав Д.Амгалан БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд ирсэн цагаан хэрэгслийг үнэлэх, зарж борлуулах талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй байхад тэдгээрийг зочид буудлын 578 иж бүрдэл тавилгыг дагуулан тарааж, үлдэх 225 ш цагаан хэрэглэлийг Улсын клиникийн төв эмнэлэгт, 620 ш цагаан хэрэглэлийг Нэгдсэн 2 дугаар эмнэлэгт үнэ төлбөргүй олгосон байна.

4.1.5 ГХЯ-ны ТНБД /Д.Ганхуяг/-ын 2016 оны 07 дугаар сарын 19-ны А/180 дугаар тушаалаар "АСЕМ"-ыг зохион байгуулж дууссаны дараа төсвийн хөрөнгөөр худалдан авч хэрэглэсэн болон ГХЯ-д БНХАУ-аас үзүүлсэн техникийн тусламжийн хүрээнд ашигласан хурлын тавилга, техник, тоног төхөөрөмжийг бүртгэн хураан авч, цаашид яамны үйл ажиллагаанд ашиглаж болох эд зүйлс, ашиглагдахгүй илүүдэл хэсгийг тодорхойлон гаргах, зарж борлуулан орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг ДБҮЭГ-

⁴⁰ Хөрөнгийг тараах үед үнийг тогтоогоогүй байсан ба тогтоосон үеийн үнээр тайланд тусгав



т хариуцуулж, гүйцэтгэлийг тайлагнахыг ДБҮЭГ-ын захирал О.Заяамандахад хариуцуулсан байна.

ДБҮЭГ-ын захирал О.Заяамандах дээрх шийдвэрийн дагуу 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдөр А/65 дугаар тушаалаар ажлын хэсэг томилж, "АСЕМ"-д ашиглагдсан тавилга, эд хогшлыг бүртгэн авч, "Уран ган" ХХК-ийн агуулах болон ДБҮЭГ-ын агуулахад зөөн шилжүүлж, энэ ажлыг хариуцан гүйцэтгэхийг "АСЕМ"-ын нярав Д.Амгаланд даалгасан байна.

4.1.6 ГХЯ-аас 2016 оны 12 дугаар сарын 8-ны 08/6967 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд хүлээж авсан хөрөнгийн холбогдох зөвшөөрлийг авахаар тоо хэмжээ, үнэлсэн үнийн саналаа явуулсан байна.

ҮАГ-аас ГХС-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэлтэй утсаар холбогдож "АСЕМ"-ын хөрөнгөтэй холбоотой ТӨБЗГ-аас тогтоол шийдвэр гарсан талаар лавлахад шийдвэр гараагүй гэсэн тайлбарыг өгч байсан учраас энэхүү аудитаар "АСЕМ"-ын хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгүүдийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу данс бүртгэлд тусгах, шилжүүлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, өр авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгч, зочид буудлын иж бүрдэл тавилгуудыг худалдан борлуулсны орлого 457.5 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТ хууль болон бусад холбогдох журмыг мөрдөж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх талаар зөвлөмж өгсөн байна.

Гэтэл тусламжийн бүх хөрөнгө тараагдаж дууссаны дараа ТӨБЗГ-аас 2017 оны 03 дугаар сарын 75, 76, 77, 78, 04 дүгээр сарын 121, 122, 123, 07 дугаар сарын 318, 319 дүгээр тогтоолуудаар БНХАУ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд ирсэн зочид буудлын болон албан тасалгааны тавилга, эд хогшлыг /ДБҮЭГ-ын тогтоосон үнээр/ үнэлж, 599.2 сая төгрөгийн 4784 ш албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж, 233.9 сая төгрөгийн 103 иж бүрдэл зочид буудлын тавилгыг 14 төрийн байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлж, данс бүртгэлд бүртгэх, 475 иж бүрдэл зочид буудлын тавилгыг 1,171.4 сая төгрөгөөр, 670 ш бусад тавилга, тоног төхөөрөмжийг 102.2 сая төгрөгөөр тус үнэлэн байгууллага, иргэдэд худалдан борлуулж, борлуулснаас орох орлогоос хөрөнгө хадгалах, тээвэрлэх, хуваарилахтай холбогдон гарсан 116.6 сая төгрөгийн зардлыг суутган тооцож, үлдэх хэсгийг улсын төсвийн өмч хувьчлалын орлогын дансанд 2017 онд багтаан төвлөрүүлэхийг ДБҮЭГ-ын захирал Ё.Нямжавт даалгасан байна.

ТӨБЗГ БНХАУ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд ирсэн тавилга, тоног төхөөрөмжийн үнэлгээ болон хуваарилалтын талаар цаг хугацаанд нь холбогдох тогтоол шийдвэрийг гаргаагүй нь ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д *"төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах"* гэсэн заалтыг, ДБҮЭГ нь ТӨБЗГ-аас албан ёсны шийдвэр ирээгүй байхад тавилгуудыг шилжүүлсэн, худалдсан зэрэг нь дээрх хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т *"... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.



4.1.7 ДБҮЭГ нь ТӨБЗГ-ын дээрх тогтоол шийдвэрийн дагуу 1,273.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулснаас 2017 оны жилийн эцсийн байдлаар 763.7 сая төгрөгийн орлогыг хураан авч, орлогоос хөрөнгө хадгалах, тээвэрлэх, хуваарилахтай холбогдон гарсан зардал 116.7 сая төгрөгийг суутган тооцож, 644.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 2.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүйг 2017 оны эцэст өглөгөөр тайлагнасан байна.

ДБҮЭГ нь 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нэр бүхий 11 иргэнээс 37.9 сая, 13 ААН-ээс 379.9 сая, нийт 417.8 сая төгрөгийн зочид буудлын тавилгын, 16 иргэн, ААН-ээс 60,0 сая төгрөгийн албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмжийн, нийт 477.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй ба санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.

4.1.8 ДБҮЭГ-ын захирал /Ё.Нямжав /-ын 2017 оны 04 дүгээр сарын 23-ны А/57 дугаар тушаалаар дээрх авлагыг барагдуулах ажлын хэсгийг дэд захирал Д.Хулганжаваар ахлуулан томилсон байна.

ДБҮЭГ-ын захирал /Ё.Нямжав/-ын 2017 оны 05 дугаар сарын 8-ны А/63 дугаар тушаалаар "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зориулан БНХАУ-аас хандивласан тавилгыг худалдан борлуулах явцад үүссэн өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан байна.

Ажлын хэсгээс төлбөрийн үлдэгдэлтэй байгаа 13 компанийг шүүхэд өгснөөс "Зул-Оюу" ХХК, "Мондевелопмент" ХХК, "Баянгол зочид буудал" ХК, "Зогсолтгүй эргэлт" ХХК, "Скай резорт" ХХК, "Мон жаргалант" ХХК-дад төлбөрийг төлүүлэхээр шүүгчийн захирамж гарсан, "Блюскай эжиа" ХХК, "Мика интерпрайз" ХХК-ийн төлбөрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхийн гүйцэтгэх хуудас гарсан, "Нью терравокс" ХХК, "Маркет аксес плесс монгол" ХХК, "Зорголын гүнж" ХХК, "Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо" ТББ, "Наранбулаг трейд" ХХК-уудын хэрэг шүүхийн шатандаа хянагдаж байна.

4.1.9 Авлагаа барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан компаниудаас 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 4 компани 29.2 сая төгрөгийн төлөлт хийж, "Зогсолтгүй эргэлт" ХХК 14.6 сая төгрөгийн үнэ бүхий 202 ш орны матрас, 5 ком стандарт өрөөний тавилгыг ашиглаагүй тул буцаасан, О.Заяамандах /ДБҮЭГ-ын захирал асан/ 0.4 сая төгрөгийн 2ш кресло, 0.7 сая төгрөгийн үнэ бүхий 5ш сандал буцаасан, иргэн Нэргүй 0.3 сая төгрөгийн үнэ бүхий 3ш буйдан, 0.5 сая төгрөгийн үнэ бүхий 3ш хөлийн тавиурыг буцаасан, "Баянгол зочид буудал" ХК 2.1 сая төгрөгийн үнэ бүхий 11ш 2 хаалгатай шкафыг тус тус буцааж тушаасан байна.

4.1.10 Дээрх буцааж тушаагдсан борлуулах ёстой хөрөнгүүд болон агуулахад байсан 0.8 сая төгрөгийн 10ш сандал, 0.2 сая төгрөгийн 2ш хөлийн тавиур, 30.3 сая төгрөгийн үнэ бүхий 244 ш тавилгыг ТӨБЗГ-ийн Бүртгэл хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэлийн хийсэн хуваарийн дагуу төсвийн болон ТӨҮГ-дад хуваарилж холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгсөн байна.

ТӨБЗГ нь дээрх тавилгуудын худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх талаар цаг хугацаанд нь холбогдох тогтоол шийдвэрийг гаргаагүйгээр төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн нь ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д *"төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах"* гэсэн заалтыг, ДБҮЭГ-ын нярав Д.Амгалан нь ТӨБЗГ-аас албан ёсны бус гараар бичсэн хуваарийн дагуу тавилгуудыг хүлээлгэж өгсөн нь дээрх хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т *"... төрийн*



өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.1.11 БНХАУ-аас буцалтгүй тусламжаар нийлүүлсэн зочид буудлын тавилга болон албан тасалгаа, хурлын зориулалттай тавилгыг ТӨБЗГ-ын дээрх дурдсан 10 тогтоолоор 43 төрийн байгууллага 2,004.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэлд тусгасан эсэхийг аудитаар тулган баталгаажуулахад 1,994.0 сая төгрөгийн хөрөнгийг 40 байгууллага бүртгэлд тусгаж, дараах 3 байгууллага 10.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ. *Тухайлбал;*

- ТӨБЗГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны 122 дугаар тогтоолоор “Завхан АЗЗА” ТӨХК-д 4 төрлийн 34 ширхэг 3.0 сая төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшлыг тус компанийн Улаанбаатар хот дахь төлөөлөгч хүлээн авсан боловч 15 ширхэг сандлыг үлдээн бусад тавилгыг үндсэн баримтгүйгээр компанидаа хүргүүлсэн байна. Харин 19 ширхэг 1.9 сая төгрөгийн тавилгыг компанийн эд хариуцагч хүлээн авч агуулахад хадгалахдаа холбогдох баримтыг үйлдээгүй, нягтлан бодогчдоо мэдэгдээгүй зэргээс шалтгаалан 3.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгээгүй;
- ТӨБЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 05-ны 318 дугаар тогтоолоор ГЕГ-т 2.1 сая төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг сандлыг 2017 оны 11 дүгээр сарын 01-нд ГЕГ-ын нярав хүлээн авсан боловч үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогчдоо мэдэгдээгүйгээс бүртгэлд тусгаагүй;
- ТӨБЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор Сүхбаатар аймгийн ЗДТГ-т 6.4 сая төгрөгийн зочид буудлын “стандарт” зэрэглэлийн өрөөний 3 иж бүрдэл тавилгыг “Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ” ОНӨҮГ-ын бүртгэлд авахаар шийдвэрлэж, Орон нутгийн өмчийн албанд бүртгэлд тусгах шийдвэр гаргуулахаар хандсан боловч шийдвэр гараагүйн улмаас бүртгэлд тусгаагүй байна.

4.1.12 ТӨБЗГ-ын 2017 оны 76, 122, 123, 318, 319 дүгээр тогтоолоор 84.7 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг БХЯ, түүний харьяа байгууллагуудад хуваарилан хөрөнгийн дансанд бүртгэхээр шийдвэрлэсэн боловч ТӨБЗГ-ын 2017 оны 123 дугаар тогтоолоор ЗХЖШ-т хуваарилагдсан 950.0 мянган төгрөгийн 2 ширхэг агааржуулагчийг 2016 оны 08 дугаар сарын 04-нд “Техникал сервис консалтинг” ХХК-аас нэг бүрийн 500.0 мянган төгрөгөөр худалдан авсан гэсэн бүртгэлд тусган үнийг шилжүүлсэн байна.

4.1.13 ГХС Ц.Мөнх-Оргил, ЭМС А.Цогцэцэг нарын 2016 оны 08 дугаарын 04-нд акт үлдэн 60ш агааржуулагч хүлээн авсан гэсэн байхад ТӨБЗГ-ын 2017 оны 03 дугаар сарын 07-ны 76 дугаар тогтоолд 61ш агааржуулагчийг ЭМЯ-нд өгсөн гэсэн байна. Гэтэл ЭМЯ 60ш-ийг авч 1 агааржуулагч /үнэ 950.0 мянган төгрөг/-ыг орлогод аваагүй байна.

4.1.14 “АСЕМ”-ын БАА-д БНХАУ-аас ирсэн буцалтгүй тусламжийн зочид буудлын тавилгаас ЦЕГ-ын “Сүүж уулын амралт”-д нийт 5 ш буюу 10.8 сая төгрөгийн үнэтэй тавилгыг авч ТӨБЗГ-ын 2017 оны 07 дугаар сарын 05-ны 319 дүгээр тогтоолоор бүртгэлд тусгасан байна.

4.1.15 БНХАУ-ын ГХЯ болон бусад байгууллага, компаниас ИНЕГ-ын саналын дагуу буцалтгүй тусламжаар 15 тооны 10,395.1 сая юаны өртөгтэй 3,223.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирснийг “АСЕМ”-ын БАА ИНЕГ-т хүлээлгэн өгсөн хүлээн авч бүртгэлд тусгасан, одоогоор ашиглаж байна.



ГХЯ-аас ИНЕГ-ын “Сэргээн засах амралтын бааз”-д 2017 оны 10 дугаар сарын 18-нд 36.8 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирснээс аудитын тулган баталгаажуулалтаар 2 төрлийн 10 ширхэг 2.8 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан тул төлүүлэхээр акт тогтоов.

БНХАУ-ын тусламжаар ирсэн дуу, орчуулгын “TAIDEN” брэндийн тоног төхөөрөмжийг ГХЯ хүлээн авч акт үйлдэн, үнэлээгүйгээр “Нью Терравокс” ХХК-д өнөөг хүртэл түрээсээр ашиглуулсаар байна.

4.1.16 МУ, БНХАУ-ын ЗГ хоорондын 2016 оны 01 дүгээр сарын 5,6-ны өдрийн захидлыг үндэслэн БНХАУ-ын ЗГ-аас “АСЕМ”-ыг дэмжиж МУ-ын ЗГ-т “АСЕМ”-д ашиглагдах тоног төхөөрөмж, тавилгыг буцалтгүй тусламжаар олгохоор шийдвэрлэсэн байна.

Тусламжийн дуу, орчуулгын “TAIDEN” брэндийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан ерөнхий актад 1 дүгээр ээлж 2016 оны 04 дүгээр сарын 29-нд онгоцоор, 2 дугаар ээлж 2016 оны 06 дугаар сарын 18-нд вагоноор хүлээн авч ГХС /Л.Пүрэвсүрэн/, БНХАУ-ын худалдааны сайд /Гао хучөн/ нар гарын үсэг зурсан байна.

Гэвч уг тоног төхөөрөмжийг ГХЯ-аас комисс томилж хүлээн авсан баримт аудитын явцад олдоогүй бөгөөд хилээр орж ирсэн гаалийн мэдүүлэгт “АСЕМ”-ын гэрээт нярав Д.Амгалан гарын үсэг зурсан байна. Эдгээр тоног төхөөрөмжийг гаалийн мэдүүлэгт 5,852.3 сая төгрөгөөр үнэлж, нийт 65.8 сая төгрөгийн НӨАТ, ОАТ, гаалийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл ГХЯ үнэлээгүй байгаа ба үнэгүйгээр түрээслүүлж байна.

Дээрх тоног төхөөрөмжийг түрээслэх, түрээслүүлэхээр 2016 оны 07 дугаар сарын 19-нд “Нью Терравокс” ХХК-ийн ерөнхий захирал Г.Түмэн-Ерөөлт /түрээслэгч/, ДБҮЭГ-ийн захирал О.Заяамандах /түрээслүүлэгч/ нар дугааргүй гэрээнд гарын үсэг зурсныг ГХЯ-ны ТНДБ, “АСЕМ”-ын БАА-ны дарга Д.Ганхуяг баталгаажуулсан байна.

Гэрээний хавсралт гэх бичигт 62 төрлийн 6955 ширхэг тоног төхөөрөмжийг жагсаалтаар гарган “АСЕМ”-ын гэрээт нярав Д.Амгалан, “Нью Терравокс” ХХК-ийн тоног төхөөрөмжийн хэлтсийн Э.Наранбат нар гарын үсэг зурсан боловч энэхүү хавсралт албан ёсоор баталгаажаагүй байна.

Гэтэл ГХЯ-ны ТЗУГ-ын мэргэжилтэн Н.Амармэндийн хүлээлгэн өгсөн, “Нью Терравокс” ХХК-ийн сүлжээний инженер Г.Баянцагааны хүлээн авсан гэж гарын үсэг зурсан огноогүй барааны жагсаалтад 106 нэрийн нийт 9,408.5 ширхэг бараанаас ГХЯ-д 2 удаа авч нийт 38 нэрийн 1,503ш техник, хэрэгслийг ашигласан бөгөөд “Нью Терравокс” ХХК-д 7,905.5 ширхэг байгаа гэжээ.

Ийм байдлаар тухайн тоног төхөөрөмжийг гаалиар орж ирэхэд /“АСЕМ”-ын гэрээт нярав Д.Амгалан хэлснээр/ “Нью Терравокс” ХХК-д шууд өгснөөс тодорхой тоо ширхгийг мэдэхгүй байгаа ба хилээр орж ирэхэд ГХЯ комисс гарган хүлээн авч бүртгэлд тусгаагүйгээс барааны нэр төрөл, тоо ширхэг, хайрцгийн тоо, жин тодорхойгүй болж зөрүүтэй болгосон бөгөөд одоогоор ГХЯ бүртгэлд тусгах талаар арга хэмжээ авч үнэлээгүй, өмчлөлд аваагүй байгаа нь тухайн үед ажиллаж байсан ажилтнуудын ажлын хариуцлагатай холбоотой байна.

Энэхүү зөрчилтэй асуудал нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн



Аудитын явц /2018 оны 3 дугаар сарын 1/-д энэхүү тоног төхөөрөмж “Нью
Терравокс” ХХК-ийн хадгалж буй газарт очиж үзсэн болно.

Зураг 10Зураг 11



“Нью Терравокс” ХХК-аас тоног төхөөрөмж хадгалсан агуулахын түрээсийн төлбөрт 2017 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар 87.0 сая төгрөгийг нэхэмжилж албан бичиг ирүүлсэн боловч гэрээнд энэ талаар заалтгүйгээс ГХЯ шийдээгүй байна.

“Нью Терравокс” ХХК-д түрээслүүлсэн тоног төхөөрөмжийн талаарх асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

4.2 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж БНСУ-ын олон улсын “Койка” байгууллагаас хандивласан буцалтгүй тусламжийн нийт хөрөнгийн хэмжээ, үнийн дүн тодорхойгүй байна.

4.2.1 ГХС-ын 2016 оны 02 дугаар сарын 29-ний А/17 дугаар тушаалаар БНСУ-ын “Койка” олон улсын байгууллагаас ирэх буцалтгүй тусламжийн хүлээн авах дараах 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан боловч уг ажлын хэсгийн хөрөнгө хүлээн авсан эсэх нь тодорхойгүй, энэ талаар мэдээлэл ГХЯ-нд байхгүй байна.

1. Ажлын хэсгийн ахлагч Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Гадаад бодлогын зөвлөх /А.Баттөр/;
2. ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА-ны орлогч дарга /Д.Баясгалан/;
3. ХЗЯ-ны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга /Т.Ганбаатар/;
4. “АСЕМ”-ын БАА-ны ахлах мэргэжилтэн /С.Амарсанаа/;
5. ТТХГ-ын Хяналт шинжилгээ, дотоод аудитын тасгийн дарга хошууч /Ж.Гантөмөр/;



6. ЦЕГ-ын Санхүү, хангамжийн газрын Хангамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн /Б.Цэндбаяр/;
7. ИНЕГ-ын Нисэх буудлын удирдах газрын Орон нутгийн аэродром, инженерийн албаны дарга /Г.Мөнхболд/;
8. ОБЕГ-ын Санхүү, хангалт үйлчилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн /Д.Болорцэцэг/;
9. Гааль, татварын ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын байцаагч /О.Мөнхзул/;
10. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга /Т.Батбаяр/;
11. Монголын Зочид буудлуудын холбооны ажилтан /Б.Содгэрэл/.

4.2.2 ГИХГ БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны “Койка” байгууллагын тусламжаар өгсөн 12 нэрийн 464ш, 590.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2017 оны 08 дугаар сарын 29-ний 361 дүгээр тогтоолоор бүртгэлд тусгасан байна.

Эдгээр тоног төхөөрөмжийг 2016 оны 5 дугаар сард хүлээн авсан боловч тус газарт эдгээрийг хүлээн авсан акт, хэрхэн үнэлсэн талаарх баримтыг аудитад гаргаж ирүүлээгүй бөгөөд хөрөнгийг хүлээн авах, үнэлэхдээ комисс томилоогүй байна.

4.2.3 ТТХГ БНСУ-ын “Койка” олон улсын байгууллагаас хандивласан 148.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалыг ТТХГ-ын Өмч хамгаалах байнгын хорооны зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн бүртгэлд тусгасан боловч тэдгээрийг хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй, зохих байгууллагаас зөвшөөрөл аваагүй бүртгэсэн байна.

Дээрх байгууллагуудад хөрөнгийг акт үйлдэн 2 тал гарын үсэг зурж баталгаажуулан хүлээн авсан баримтгүй байна.

4.3 Төрийн байгууллагууд хандивын хөрөнгийг хэрхэн үнэлж бүртгэлд тусгасан нь тодорхой баримтаар нотлогдохгүй байна.

ХЗЯ-д БНХАУ, БНСУ-аас тусламжаар орж ирсэн тоног төхөөрөмжийн хилээр орж ирсэн гаалийн мэдүүлэг байхгүй, тэдгээрийг хэрхэн үнэлж бүртгэлд тусгасан нь тодорхойгүй байна.

4.3.1 БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд ХЗЯ-д нийт 752.6 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүлээж авсан гэжээ. Үүнд :

- Автомашины дуут гэрлэн дохио, чанга яригч 250 ширхэг 162.3 сая төгрөг;
- Зөөврийн хяналтын төхөөрөмж 9 ширхэг 240.1 сая төгрөг;
- Хамгаалалтын өмсгөл 1000 ширхэг 283.7 сая төгрөг;
- Тээврийн хэрэгсэл албадан зогсоогч 100 ширхэг 42.6 сая төгрөг;
- Гар чийдэнтэй цахилгаан бороохой 1000 ширхэг 23.9 сая төгрөг.

Дээрх тусламжаар орж ирсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн Хятадын талын дагалдах бичиг баримт, гаалийн мэдүүлэг байхгүй байхад ЦЕГ-ын дарга /Р.Чингис/-ын 2016 оны 05 дугаар сарын 24-ний Б/266 дугаар тушаалаар хөрөнгийг бүртгэлд тусгаж, орлого авсан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.3.2 БНСУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд нийт 53 нэр төрлийн 564,707 ам.доллар буюу 1,572.7 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ЦЕГ хүлээж авсан гэжээ.



Уг тусламжаар орж ирсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн Солонгосын талын дагалдах бичиг баримт, гаалийн мэдүүлэг байхгүй байхад 53 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ЦЕГ-ын дарга /Р.Чингис/-ийн 2016 оны 12 дугаар сарын 12-ны Б/700 дугаар тушаалаар хөрөнгийг бүртгэлд тусгасан нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д *“Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.3.3 БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн нийт 5,442.9 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг 2016 оны 5 дугаар сарын 08-ны өдөр ГХЯ-ны “АСЕМ”-ын БАА-ыг төлөөлж /Д.Ганхуяг/ ОБЕГ-ыг төлөөлж /П.Баттогтох/-д акт үйлдэн хүлээлгэж өгснөөр ОБЕГ-ын даргын доорх тушаалуудаар Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хуваарилжээ.

- ОБЕГ-ын дарга /Т.Бадрал/-ын 2016 оны 07 дугаар сарын 19-ний А/194 дүгээр тушаалаар 2,632.1 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж;
- ОБЕГ-ын дарга /Т.Бадрал/-ын 2016 оны 08 дугаар сарын 30-ны А/209 дугаар тушаалаар 2,810.8 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж.

Ой хээрийн түймэр унтраах зориулалтын нийт 2,166.0 сая төгрөгийн 6 автомашиныг Багануур дүүргийн болон Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн Онцгой байдлын хэлтэст хуваарилж бүртгэсэн байна.

4.3.4 ТТХГ-т БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн автомашин албадан зогсоогч 79.0 сая, зочид буудлын тавилга, эд хогшил 93.5 сая, нийт 172.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

ТТХГ ХБНГУ-ын 110.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалыг ТТХГ-ын Өмч хамгаалах байнгын хорооны зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн бүртгэлд тусгасан боловч тэдгээрийг хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй, зохих байгууллагаас зөвшөөрөл аваагүй бүртгэсэн байна.

ТаЕГ-т БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 7.6 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг бүртгэлд тусгасан байна.

4.4 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж бусад байгууллагаас хандивласан хөрөнгийг зохих зөвшөөрлийн дагуу бүртгэлд тусгаагүй байна.

4.4.1 “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж 2016 оны 8 дугаар сарын 10-нд “Моннис” ХХК-аас ГХЯ-нд 2ш Ниссан Теана маркийн автомашин бэлэглэснийг 1ш-ийг НЗДТГ-т 2018 оны 8 дугаар сарын 16-нд автомашин хүлээлцсэн акт үйлдэн үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгсөн бөгөөд 1ш-ийг ХЗЯ-д 2018 оны 09 дугаар сарын 01-нд хүлээлцэх актгүйгээр өгсөн байна.

НЗДТГ-т шилжүүлсэн дээрх “Ниссан Теана” маркын автомашиныг Нийслэлийн төр, захиргааны автобазад шилжүүлсэн боловч бүртгэлд 2018 оны 03 дугаар сарын 06-ны байдлаар тусгаагүй байгаа ба уг автомашин 2018 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар нийт 38.3 мянган км явж, 37.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

ХЗЯ-д дээрх “Ниссан Теана” маркны автомашины УБЛ 0376 улсын дугаартай гэрчилгээнд эзэмшигч нь “Моннис моторс” ХХК байгаа ба ХЗЯ-аас тус компанид эзэмшлийг шилжүүлэх хүсэлтийг 2017 оны 12 дугаар сарын 21-ны 1-4/4902 дугаартай албан бичиг явуулсан боловч хариу ирээгүйгээс бүртгэлд тусгаагүй бөгөөд түүнийг ХЗЯ албан хэрэгцээнд ашиглаж байна.



Аудитын дүгнэлт

- ✚ Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг Монгол Улсад зохион байгуулахдаа түүний үр дүн, ач холбогдлыг тодорхойлоогүй, гарсан үр өгөөжийг тооцож тайлагнаагүй байна.
- ✚ ҮАБЗ-ийн 2014 оны 63/37 дугаар зөвлөмжийн 3.5.7 дахь хэсгээр өгсөн зөвлөмжийг үндэслэл болгон ЗГ болон бусад төрийн байгууллагаас эрх зүйн шийдвэр гаргаж хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу "АСЕМ"-ын үйл ажиллагааг зохион байгуулахад хамааралтай гэж үзсэн бүх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо *шууд* гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчих нөхцөл бүрдүүлсэн байна.
- ✚ "АСЕМ"-ын уулзалтыг Монгол Улсад зохион байгуулахын тулд МУ-ын Ерөнхийлөгч 2014 онд Үндэсний зөвлөлийг байгуулсан байхад энэхүү ажлыг цаг хугацааны хувьд бүрэн төлөвлөн зохион байгуулалттай, санхүүгийн хяналттайгаар хуулийн хүрээнд явуулах боломж байсан байна. Гэвч "АСЕМ"-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, зарцуулах хөрөнгийн төсвийг санхүүжилтийн бүх эх үүсвэрээр нэгтгэн гаргаж батлаагүй байна.
- ✚ МУ-ын Засгийн газар, МУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 163 дугаар зарлигаар байгуулагдсан "АСЕМ-ын Үндэсний зөвлөл, Ерөнхий сайдын 2015 оны 17, 128, 2016 оны 13 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд, ЗГ-ын 2014 оны 382 дугаар тогтоол болон ГХС-ын 2015 оны 8 дугаар сарын 31-ний А/75 дугаар тушаалаар байгуулагдсан ГХЯ-ны "АСЕМ"-ын Бэлтгэл ажлын алба нь "АСЕМ"-ын үйл ажиллагаанд төсвийн болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн хөрөнгө, түүний зарцуулалтын тайланг гаргаж ЗГ, УИХ-д танилцуулаагүйгээр ажлаа дуусгасан байна.
- ✚ "АСЕМ"-ын үйл ажиллагаанд улс, нийслэлийн төсвөөс төсөвлөн зарцуулсан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтад тавих санхүүгийн хяналтыг холбогдох эрхийн актад орхигдуулснаас "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулсан 395.7 тэрбум төгрөгийн хөрөнгө хяналтгүй зарцуулагдсан байна.
- ✚ Нийслэл "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн 74 хувийг өмчлөлд бүртгээгүйгээр байна.
- ✚ "АСЕМ"-ын бэлтгэл ажлын хүрээнд гэрээний захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний 2.7⁴¹ ба 3.6⁴² дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, зарим гэрээнд энэ талаар дурдаагүйгээс гүйцэтгэгч хөрөнгийг хяналтгүй зарцуулсан ба гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.
- ✚ "АСЕМ" нэрийн дор түүнд хамааралгүй төсөл, арга хэмжээг хууль зөрчин шууд гэрээгээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтгүй явуулсан байна.
- ✚ Сангийн сайдын 2015 оны 241 дүгээр тушаалаар батлагдсан *"Ази Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"*-ыг СЯ, ХБ хэрэгжүүлээгүй байна.
- ✚ "АСЕМ"-ын үйлчилгээнд БНСУ-ын Экспорт-импортын банкны зээлээр авсан 43 автобусыг ашиглах шаардлагагүй байсан ба "АСЕМ"-тай холбоотойгоор 195.0 сая төгрөгийн нэмэлт зардал гаргасан бөгөөд эдгээр автобусны борлуулалт 2 жилээр хойшилсон байна.
- ✚ Одоогийн байдлаар 10 автобусыг эрх зүйн зөвшөөрөлгүйгээр төсвийн байгууллага лизингийн зээлээр авсан байна.

⁴¹ "гэрээт ажлын гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг шалгаж хүлээж авах үүрэгтэй

⁴² Гэрээт ажлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг захиалагч талд гаргаж өгөх



- ✚ “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж ирсэн хандив тусламжийг хүлээн авах, хуваарилахад ажлын хэсгийг ажиллуулаагүйгээс хандив, тусламжийн хөрөнгийн бүртгэл будлиантаж, бүрэн хэмжээгээр бүртгэлд тусгасан эсэх нь нотлогдохгүй байна.
- ✚ “АСЕМ”-д зориулж ирэх хандив, тусламжийн хөрөнгийг тооцоолсон бол тэр хэмжээгээр төсвийн хөрөнгийг хэмнэх боломж байсан байна.
- ✚ Аудитаар нийт 290,890.8 сая төгрөгийн зарцуулалттай холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ. *//Дэлгэрэнгүйг хавсралт №4-с үзнэ үү/*



Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

ЗАСГИЙН ГАЗАРТ:

- ❖ Монгол Улсад олон улсын чанартай томоохон арга хэмжээг зохион байгуулахдаа урьдаас төлөвлөгөө гарган төсөв батлуулж зохион байгуулалттайгаар явуулах, хөрөнгийн зарцуулалтад “хэрэгцээ” хяналттай байлгах арга эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах;
- ❖ Олон улсын томоохон арга хэмжээний үр дүн, ач холбогдлыг тооцон үр өгөөжийг тайлагнаж байх;
- ❖ “АСЕМ”-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан боловч үр дүн, үр өгөөжийг тайлагнаагүй, санхүүгийн сахилга бат, хуулийг баримтлаагүй нэр бүхий албан тушаалтанд ажлын хариуцлага тооцох;
- ❖ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтыг хэрхэн ойлгож, хэрэгжүүлэх, хамрагдах ажил, үйлчилгээг эрх зүйн талаас боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллах.

САНГИЙН САЙДАД:

- ❖ БНСУ-ын Экспорт-импортын банкны зээлээр авсан 43 автобуснаас 10 автобусыг төсвийн байгууллагууд лизингийн зээлээр авч байгааг анхаарч холбогдох арга хэмжээ авах;
- ❖ “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулан Хөгжлийн банкны эх үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан зочид буудлуудад олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, гүйцэтгэлд Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу хяналт тавьж тайлагнаж байх.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДАД:

- ❖ “АСЕМ”-ын үйл ажиллагааг зохион байгуулахад зөрчил гаргасан холбогдох нэр бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох;
- ❖ Хандив, буцалтгүй тусламжийн хөрөнгийн борлуулалтын орлогыг бүрэн бүрдүүлж, авлагыг барагдуулах;
- ❖ “Нью терравокс” ХХК-ийн эзэмшилд байгаа тусламжийн хөрөнгийг үнэлэн төрийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАД:

- ❖ Нийслэлд 2016 онд “АСЕМ”-тай холбоотой хэрэгжсэн төсөл арга хэмжээний хөрөнгийг нийслэлийн өмчлөлд бүртгэх ажлыг зохион байгуулах.

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД:

- ❖ “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулан Хөгжлийн банкны эх үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан зочид буудлуудад олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж байх;
- ❖ БНСУ-ын Экспорт-Импортын банкнаас хөнгөлөлттэй авсан зээлээр авсан 43 автобусыг тус банкны “Ди Би Эм Лизинг” ХХК-аар дамжуулан лизингээр худалдаж байгаатай холбогдуулан зээлийн төлөлтөд хяналт тавьж, тайлагнаж байх.



Хавсралт №1

"АСЕМ"-ЫН УУЛЗАЛТУУДАД УЛСЫН ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН СУДАЛГАА

/сая.төг/

№	Харилцагч	Дүн /сая.төг/	Утга
	Парламентийн уулзалт	144.0	
1	Саунд ов Монголиа ХХК	41.0	тоног төхөөрөмж, түрээс, тайз засалт
2	Мөнхийн үсэг ХХК	0.7	хавтас, дэвтэр
3	ТЗАҮЦогцолбор	14.7	зоог
4	Алтан алим ХХК	3.3	хурлын баннер
5	Дөл хангай ХХК	1.6	хулдаасан хэвлэл
6	Хасид Хангал ХХК	2.2	баннер
7	Чингис хааны хүрээ ХХК	12.0	зоог
8	Дизайнер Клуб ХХК	4.7	Италийн Триумф компаний төлөөлөгчдийн буудлын зардал
9	Улсын филармони	18.0	урлагийн тоглолт
10	Хийморь принтинг ХХК	1.1	урилга, дугтуй, хөтөлбөр
11	Корпорейт Конвейшн центр ХХК	23.9	зоог
12	Баянгол зочид буудал ХК	15.9	зоог
13	Иргэн Н.Сэлэнгэ	1.8	орчуулагчийн хөлс
14	Телевизийн мэргэжлийн зураглаачдын холбоо	2.2	шууд дамжуулсны төлбөр
15	Бичиг хэргийн зардал	0.9	уртасгагч, кабель
	Хүнсний аюулгүй байдлын уулзалт	93.2	
16	Туушин Зочид буудал ХХК	15.0	зоог
17	ТЗАҮЦогцолбор	15.5	кофе брейк, үдийн хоол
18	Пресслоорд ХХК	3.8	урилга, гарын авлага хөтөлбөрийн зардал
19	Бест ШДАТ ИНК ХХК	0.9	бичиг хэргийн зардал
20	Саунд ов Монголиа ХХК	32.5	тайз засалт тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөр
21	Женко тур бюро ХК	10.8	үзвэр, үдийн зоог
22	Иргэн Н.Ашит	5.4	урлагийн тоглолт
23	Аз хур ХХК	2.4	бэлгэд Эко тосон бал, USB флаш диск
24	Нью Терравокс ХХК	6.9	орчуулгын болон аудио тоног төхөөрөмж ажиллуулсны хөлс
	Залуучуудын уулзалт	108.0	
25	МУИС	10.6	оюутнуудын байрлах байрны түрээс
26	Женко тур бюро ХК	10.8	бусад үйл ажиллагааны үзвэрийн зардал
27	Блюскай Эйжиа ХХК	17.0	хүлээн авалтын зардал
28	Монголын залуучуудын холбоо ТББ	20.0	бусад үйл ажиллагааны зардал
29	Би Ар Би ХХК	30.4	тоног төхөөрөмжийн түрээс, тохижилт
30	Алтан шат ХХК	3.8	цэвэр усны зардал
31	Нью Терравокс ХХК	8.5	орчуулгын тоног төхөөрөмж
32	Талын цэнхэр салхи ХХК	0.6	урилга хөтөлбөрийн үнэ
33	Улаанбаатар чуулга	3.4	нээлтийн үйл ажиллагааны түрээсийн төлбөр
34	Эвридэй Интернэшнл ХХК	2.9	цайны завсарлага
	Түмний чуулган уулзалт	238.0	
35	Хүний эрх хөгжлийн төв ТББ	5.9	орчуулагчийн хөлс
36	Иргэн Дэ.Ганхуяг	3.0	орчуулагчийн хөлс
37	Иргэн.Булган	3.4	орчуулагчийн хөлс
38	Иргэн.Халиун	2.0	орчуулагчийн хөлс
39	Иргэн Бя.Одгэрэл	2.4	орчуулагчийн хөлс
40	Иргэн Да.Халиун	2.1	орчуулагчийн хөлс
41	Иргэн Д.Наран	1.2	орчуулагчийн хөлс
42	Иргэн Б.Амарзул	0.5	орчуулагчийн хөлс
43	Иргэн М.Одгэрэл	12.9	орчуулгын тоног төхөөрөмж
44	Иргэн Б.Одончимэг	1.9	тоног төхөөрөмжийн төлбөр
45	БИсофт Интернэшнл ХХК	6.0	гаднын төлөөлөгчдийн зочид буудлын
46	Хүний эрх хөгжлийн төв ТББ	40.2	ажлын албаны зардал
47	Иргэн Г. Энхбаяр	1.9	интернет үйлчилгээний төлбөр
48	Маршал Креатив Эйжинси ХХК	6.0	баримтат киноны төлбөр
49	Саунд ов Монголиа ХХК	29.0	тоног төхөөрөмжийн түрээс
50	ТЗАҮЦогцолбор	64.4	үдийн хоол, кофе брейк
51	Нью Терравокс ХХК	12.2	орчуулгын тоног төхөөрөмжийн түрээс
52	Баянгол зочид буудал ХК	27.5	хүлээн авалтын төлбөр



53	МУИС	10.1	төлөөлөгчдийн байрны түрээс
54	Баянгол зочид буудал ХК	1.8	илтгэл тавихаар уригдсан 4-н төлөөлөгчийн зочид буудлын зардал
55	МҮЭХ-ҮҮТөв	2.6	орон нутгийн төлөөлөгчдийн зочид буудлын төлбөр
56	Элбэгдорж Хүрээлэн	1.0	хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал
	Ахлах албан тушаалтнуудын уулзалт	233.0	
57	Санширо ХХК	9.9	төлөөлөгчдөд ноолууран ороолт
58	Дүүлэн Жигүүр ХХК	0.5	төлөөлөгчдийн групп зураг авалтын төлбөр
59	Нью Терравокс ХХК	4.9	орчуулгын болон аудио тоног төхөөрөмжийн ажил
60	Шангила-Улаанбаатар хотел	12.9	оройн зоог
61	Бест ШДАТ ИНК ХХК	0.9	бичиг хэргийн зардал
62	Номадс Хоспиталити ХХК	21.8	өдрийн хоолны төлбөр
63	Грандворк интернэшнл ХХК	3.8	цаас хор, уртасгагчийн төлбөр
64	Мэжиккроун ХХК	1.2	баннерын төлбөр
65	Хаш контакт ХХК	1.6	зааланд халуун, хүйтэн үлээгч угсарсны хөлс
66	Туушин Зочид буудал ХХК	19.4	оройн зоогийн төлбөр
67	Блюскай Эйжиа ХХК	35.0	Ахлах албан тушаалтнуудын уулзалтын өдрийн хоолны төлбөр
68	Нью Терравокс ХХК	15.7	Ахлах албан тушаалтнуудын уулзалтын орчуулгын тоног төхөөрөмжийн төлбөр
69	Онгитур ХХК	1.6	Ширээний бүтээлгийн үнэ
70	Шангила-Улаанбаатар хотел	73.3	Хүлээн авалт, хоолны зардал
71	Дуурь бүжгийн эрдмийн театр	2.4	Урлагийн тоглолт
72	Капитал орд ХХК	26.1	Спам шүүлтүүр хийх программ хангамж
73	Нью Эйкшн ХХК	1.2	өндөр хурдны интернетийн үйлчилгээний төлбөр
74	Флорэвэр-од ХХК	0.8	хиймэл цэцгийн үнэ
	Сангийн сайд нарын уулзалт	189.0	
75	Хойд хаг ХХК	1.0	энгэрийн зүүлтийн үнэ
76	Сангийн яам	178.0	уулзалтын зардал
77	Иргэн З.Базаргүр	1.0	синхрон орчуулагчийн хөлс
78	Нью Терравокс ХХК	9.0	орчуулгын болон аудио тоног төхөөрөмж ажиллуулсны хөлс
	Бизнесийн уулзалт	238.0	
79	Корпорейт Конвейшн центр ХХК	65.0	хаалтын хүлээн авалтын төлбөр
80	ТЗАҮЦогцолбор	46.2	өдрийн хоол, завсарлагааны цай кофе
81	Гоёо ХХК	36.8	бэлэг дурсгалын зардал
82	Аз хур ХХК	10.2	төлөөлөгчдийн дэвтэр үзгийн зардал
83	Хүлэгт тайж ХХК	8.2	төлөөлөгчдийн бэлгийн тор
84	Сэлэнгэ пресс ХХК	13.8	төлөөлөгчдийн хөтчийн ном
85	Иргэн Л.Болормаа	2.0	урлагийн тоглолтын хөлс
86	Иргэн М.Чимэдтогтох	1.7	урлагийн тоглолтын хөлс
87	Иргэн С.Наран	1.3	урлагийн тоглолтын хөлс
88	Аж үйлдвэрийн яам	12.5	холбогдох бусад зардлууд
89	МГЗНХолбоо ТББ	1.4	230ш гэрэл зургийн үнэ
90	Иргэн М.Одгэрэл	2.3	орчуулгын тоног төхөөрөмжийн төлбөр
91	Саунд ов Монголиа ХХК	32.6	тоног төхөөрөмжийн түрээс, тохижилтын төлбөр
92	Номинтав трейд-Оолмарт	4.0	ус ундааны үнэ
	Редакторуудын уулзалт	59.8	
93	Блюскай Эйжиа ХХК	6.0	хүлээн авалтын зардал
94	Туушин Зочид буудал ХХК	37.0	оройн зоог, кофе брейкийн зардал
95	Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга	1.7	урлагийн тоглолтын хөлс
96	Хөлгөн Хэлхээ ХХК	0.8	урлагийн тоглолтын хөлс
97	Дуурь бүжгийн эрдмийн театр	0.8	урлагийн тоглолтын хөлс
98	Нью Терравокс ХХК	7.6	орчуулгын тоног төхөөрөмж
99	Саунд ов Монголиа ХХК	1.1	тайз засалт хулдаасан хэвлэл
100	Монголиан гүрмэ энд катеринг	4.8	оройн зоог
	НИЙТ ДҮН	1,303.0	



"АСЕМ"-ын дээд түвшний уулзалтад зарцуулсан хөрөнгийн судалгаа

/сая.төг/

№	Огноо	Харилцагч байгууллага	Дүн	Гүйлгээний утга
1	2016.05.03	СЯ-ГХЯ	378.0	Италын Триумф компанид бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх гэрээний өлбөр
2	2016.05.02	ТТХГ	26.1	АСЕМ-ын зочны хамгаалалтын машины шатахуун
3	2016.05.13	МГЗН холбоо ТТБ	3.6	АСЕМ-ын хурлын гэрэл зураг авалтын төлбөр
4	2016.06.07	Өгөөж Чихэр боов ХХК	12.5	Триумф компанын төлөөлөгчдийн байрны түрээс
5	2016.06.07	Ц.Цэлмүүн АСЕМ	9.4	Триумф компанын төлөөлөгчдын хоолны зардал
6	2016.06.15	БХЯ	664.8	Нүүдэлчдийн наадам зочид буудлын зардал
7	2016.06.22	Номин даатгал	62.4	Авто машины даатгал
8	2016.06.28	Төрийн банк	0.2	Гүйлгээний шимтгэл
9	2016.07.01	МҮЭХ-ҮҮ төв	1.8	Триумф компанын төлөөлөгчдийн зочид буудлын төлбөр
10	2016.07.04	Лишцэцэг ХХК	206.9	Хурмын ордны үйлчилгээний төлбөр
11	2016.07.04	Сити дизайн ХХК	4.0	Автомашины тусгай дугаарын үнэ
12	2016.07.05	БХЯ	132.0	Нүүдэлчдийн наадам зочид буудлын зардал
13	2016.07.05	ДМТӨСХХИГ сан	87.3	Чингис хааны сэрэг дүрийн их засвар
14	2016.07.05	Капитал орд ХХК	25.3	Автомашины угаалга
15	2016.07.05	Монкабель систем ХХК	19.6	Кибер аюулгүй байдлын материал
16	2016.07.05	Гигалинк ХХК	3.7	Кибер аюулгүй байдлын тоног төхөөрөмж
17	2016.07.07	ЗХ-ний 014 дүгээр анги	19.4	АСЕМ-ын шатахуун
18	2016.07.07	ЦЕГ	29.5	АСЕМ-ын шатахуун
19	2016.07.07	АТҮТ ТӨҮГ	15.0	АСЕМ-ын шатахуун
20	2016.07.07	ОБЕГ	20.3	АСЕМ-ын шатахуун
21	2016.07.22	Ди Вай Кэй Би ХХК	26.6	Шороон зам барих төлбөр
22	2016.07.08	Чингисийн хүрээ	85.0	АСЕМ-ын хүлээн авалт
23	2016.07.08	Иргэн Ш.Гантуул	2.0	Телевизийн бичлэгийн төлбөр
24	2016.07.18	Он энд офф продакшн ХХК	74.8	Чингисийн талбай АСЕМ-ын хаалтын ажиллагааны зардал
25	2016.07.18	Нийтлэг үйлчилгээний газар	68.0	Нүүдэлчдийн наадмын зоог
26	2016.07.19	Жи эй Пи ХХК	107.0	АСЕМ баннер хулдаасан хэвлэл
27	2016.07.21	Жарден ХХК	1.0	Ширээний цэцэг
28	2016.05.20	ДБҮЭГ	2.3	АСЕМ-ын хүлээн авалт зардал
29	2016.07.01	Шангри-ла-УБ хотел	384.5	Уулзалтын 55 өрөөний түрээс
30	2016.07.01	Вертексмон ХХК	13.4	55 өрөөний дотоод сүлжээ, тоног төхөөрөмжийн түрээс
31	2016.07.19	Нийслэлийн соёл урлагийн газар	17.8	АСЕМ 20 жилийн тоглолт
32	2016.07.20	Хийморь притинг	10.5	АСЕМ-ын соёлын зардал
33	2016.07.19	МГЗН холбоо ТТБ	8.4	АСЕМ-ын гэрэл зураг авалт
34	2016.07.20	Саунд ов Монголиа ХХК	21.2	АСЕМ-ын уулзалтын тохижилтын ажил
35	2016.07.20	Гаммафото ХХК	3.9	Зураг хэвлэлийн зардал
36	2016.07.20	Азийн загварын агентлаг ТББ	6.5	Бэсрэг наадмын моделийн зардал
37	2016.07.21	Монголиан гүрмэ энд катеринг	19.4	Үйлчилгээний төлбөр
38	2016.07.21	Жарден ХХК	1.0	Ширээний цэцэг
39	2016.07.22	Вертексмон ХХК	3.3	дотоод сүлжээ
40	2016.07.26	Иргэн Ө.Солонго	7.1	наадмаар тараасан нарын зоонтогийн үнэ
41	2016.07.26	Маршал Креатив энжинси ХХК	25.0	АСЕМ-ын шторк баримтат кино хийх
42	2016.07.26	Нийслэлийн соёл урлагийн газар	18.2	Нүүдэлчдийн наадмын зардал
43	2016.07.26	Саунд ов Монголиа ХХК	16.8	Тоног төхөөрөмж түрээс, тохижилтын ажил
		НИЙТ ДҮН	2,645.5	



**Нийслэлд хэрэгжсэн байршлын хувьд “АСЕМ”-ын үйл ажиллагаатай
холбоогүй төсөл, арга хэмжээнүүд**

/сая.төг/

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дүн
1	60 дугаар сургуулийн баруун уулзвараас Сонсголонгийн арын зам хүртэлх 1,2 км авто замын /ХУД, 7-р хороо/	Тэргүүн саруул зам ХХК	1,478.4
2	Залуучуудын өргөн чөлөө, Самбуугийн гудамж, Гэсэр сүмийн уулзвар - ШУТИС-ийн уулзвар /тэмдэглээ/	Мастер роуд ХХК	25.0
3	Сөүлийн гудамж /Энхтайваны өргөн чөлөө ТЗСО-ны урд зам - Чингисийн өргөн чөлөө/тэмдэглээ/	Мастер роуд ХХК	
4	Токиогийн гудамж /Түннелийн баруун уулзвараас Энхтайваны өргөн чөлөө Бөхийн өргөөний уулзвар/ тэмдэглээ/	Мастер роуд ХХК	
5	Энэбишийн өргөн чөлөө /Баянбүрдийн аюулгүйн тойрог - Хорооллын эцэс/	Би Эс Эм Жи ХХК	20.0
6	Ард Аюушийн өргөн чөлөө /Саппорогийн аюулгүйн тойргоос Өргөө кино театрын уулзвар хүртэл/	Хайрхан бар ХХК	24.2
7	Дамдинсүрэнгийн гудамж, /ХСҮТ-ийн урд уулзвар - Олимпын гудамж/	Агиу ХХК	27.6
8	Ажилчны гудамж / ТЭЦ-3-н уулзвар-Гурвалжингын гүүр/	Пирамид проект ХХК	32.5
9	Чингүнжавын гудамж /Өргөө кино театрын урд зам - 25-р эмийн сангийн уулзвар/	Туурайн жим ХХК	32.9
10	Хувьсгалчдын гудамж /Гэсэр сүмийн уулзвар - Телевизийн эцэс/		
11	Чингэлтэйн гудамж / 32-н уулзвар - Дамбын уулзвар/	Бэст Виндинг роуд ХХК	33.2
12	Амарсанаагийн гудамж /Амарсанаагийн уулзвар - ЭНЭШТ-н аюулгүйн тойрог/	Нэмэгт оргил ХХК	30.9
13	Үйлдвэрчний эвлэлийн гудамж /21-р хороолол Драгон төвийн баруун талын уулзвараас Баянхошууны гудамж хүртэл/		
14	1 дүгээр хорооллын арын зам	Хөх мөнх сервис ХХК	30.8
15	Хасбаатарын гудамж /Ард Аюушийн өргөн чөлөө, III, IV хорооллын эцсээс дээш Бичил хорооллын урдуур явж Хувьсгалын зам хүртэл/	Отгон царам дриллинг ХХК	43.2
16	22-н товчоо чиглэлийн авто зам	Готик голд ХХК	59.2
17	2 хутагтын зам /Гэмтлийн эмнэлгийн урдуур/	Ньюсит рөүд ХХК	23.3
18	Барилгачдын гудамж /1р хороололд- Хархорин захаас хойш 1-р хорооллын арын зам хүртэл/		
19	Дандарбаатарын гудамж /офицеруудын ордны аюулгүйн тойргоос цайз зах/		
20	Жуулчны гудамж /урт цагааны урдуур/	Мадимос групп ХХК	25.9
21	Авто замчдын гудамж /Энхтайваны өргөн чөлөөнөөс доош Клиникийн 1 дүгээр амаржих газрын зүүн талаар, Сэлбэ голын баруун эргийг даган Нарны зам хүртэлх гудамж/		
22	Элчний гудамж /Яаралтай тусламжийн төвийн баруун талаар/	Шинэ гэрэлт зам ХХК	26.5
23	396-р гармаас Толгойт, Орбитын тойрог руу салдаг уулзвар/		
24	Дунд голын гудамж /Чингисийн өргөн чөлөөнөөс баруун тийш Дунд голоо даган Энгельсийн гудамж хүртэлх гудамж/	Мотор сервис ХХК	44.1
25	Энгельсийн гудамж /Хан уул дүүргийн цагаан хаалганаас дээш Мод боловсруулах үйлдвэр /	Зун зам ХХК	35.2
26	Нарны зам		
27	Шар хадны авто зам	Би Эс Эм Жи ХХК	48.0
28	Цэрэндоржийн гудамж /Энхтайваны өргөн чөлөө,Улсын их дэлгүүрийн урд талаас Сөүлийн гудамж хүртэл/		
29	Заназарын гудамж /Барилгын техникумын уулзвараас зүүн тийш/		
30	Залуусын гудамж /Москвыгийн гудамжнаас дээш СХД-ийн Эрүүл мэндийн нэгдлийн баруун талаар Өнөр хорооллын гудамж хүртэл/		
31	Чин ван Ханддоржийн гудамж /Энхтайваны өргөн чөлөөнөөс доош ЗХУ-ын элчин сайдын яамны баруун талаар Сөүлийн гудамж хүртэл/		
32	Энхтайваны гүүрний зүүн, баруун талын туслах авто зам		
33	Бөмбөгөр худалдааны төвийн баруун урд уулзвараас MN-25 суваг телевизийн хойд уулзвар хүртэл хайс суурилуулах	УБЗЗАГ ОНӨААТҮГ	15.2
34	Энхтайвны өргөн чөлөөнд Зүүн 4 замын уулзвараас Арслантай гүүр хүртэл замын хойд хэсэгт хайс суурилуулах	УБЗЗАГ ОНӨААТҮГ	38.0
35	Энхтайвны өргөн чөлөөнд 32-р байрнаас Цамбагарав хүртэл замын урд хэсэгт хайс суурилуулах	УБЗЗАГ ОНӨААТҮГ	57.0
36	Сөүлийн гудамжинд хайс суурилуулах /Энхтайваны өргөн чөлөө ТЗСО-ны урд зам - Чингисийн өргөн чөлөө/	УБЗЗАГ ОНӨААТҮГ	21.4
37	Барсын зүүн уулзвараас Нарын гүүр хайс суурилуулах	УБЗЗАГ ОНӨААТҮГ	8.2
38	Тэмдэг, тоноглолын арчлалтын ажил /гүйцэтгэлээр/	УБЗЗАГ ОНӨААТҮГ	38.7
39	Хайс нөхөн суурилуулалт, арчлалтын ажил /гүйцэтгэлээр/	УБЗЗАГ ОНӨААТҮГ	47.5
40	Хурд сааруулагч	УБЗЗАГ ОНӨААТҮГ	20.0



41	Зам дохионы шон /тумбэ/	УБЗЗАГ ОНӨААТҮГ	13.0
42	Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооллын 34 дүгээр байрны арын 3 замын уулзвар	"Сүлжээт зам" ХХК	79.0
43	Сонгинохайрхан дүүргийн Энхтайваны өргөн чөлөөний авто зам, 5 дугаар баазын урд уулзвар	"Хонгор хээр" ХХК	109.8
44	Баянгол дүүргийн Хасбаатарын гудамжны 13 дугаар сургуулийн арын зам	"Сүлжээт зам" ХХК	59.0
45	Сонгинохайрхан дүүргийн Баянхошууны авто зам, Баруун салаа, Зүүн салааны уулзвар	"Сүлжээт зам" ХХК	98.3
46	Баянгол дүүргийн Энхтайваны өргөн чөлөөний авто замын 25 дугаар эмийн сангийн автобусны буудлын явганы гарц	"Сүлжээт зам" ХХК	59.0
47	Баянзүрх дүүргийн Доржийн гудамж, Кино үйлдвэрийн зам руу салдаг уулзвар	"Отгон зам" ХХК	89.4
48	Баянзүрх дүүргийн Амгалангийн авто зам 62 дугаар цэцэрлэгийн урд гарц	"Отгон зам" ХХК	59.4
49	ЭТӨЧ /Саппоро-10-р хороолол - Зүүн 4-н зам/	НҮҮБН ОНӨААТҮГ	204.0
50	Намъянжугын гудамжны авто зам/ /Зүүн дөрвөн замаас урагш Нарантуул захын баруун талын замын уулзвар хүртэлх гудамж/		
51	Их тойруу /Баруун 4 замаас - Сансарын аюулгүйн тойрог/ -ийн авто зам		
52	Бага тойруугийн авто зам		
53	Их сургуулийн гудамжны авто зам/Гадаад хэлний дээд сургуулийн баруун хойд талаас их тойруу хүртэл/		
54	Сүхбаатарын гудамжны авто зам/Төв музейн зүүн талын замын уулзвараас хойш Их тойруу хүртэл/		
55	Авто замчдын гудамжны авто зам/ Үндсэн хуулийн гудамжнаас баруун тийш /тээврийн товчоо/ баруун тийш Варьете чуулгын урдуур Баянгол дүүргийн тамгын газар хүртэлх гудамж/		
56	1-р төрөхийн урд талын авто зам		
57	Олимпын гудамжны авто зам		
58	Нарны замаас Цэцэрлэгт хүрээлэнгийн араар Чингисийн өргөн чөлөө хүртэлх авто зам		
59	Чингисийн өргөн чөлөө / Төв шуудангийн уулзвар- Яармагийн гүүр/-ний авто зам		
60	Энхтайваны гүүрний баруун урд талын туслах зам		
61	Зайсангийн замаас Улаанбаатар сувиллын урдуур явсан авто зам		
62	Зайсангийн авто зам / 120-н мянгатын уулзвараас Зайсан толгойн эцсийн буудал - Сүрьеэгийн эмнэлэг /		
63	Самбуугийн гудамжны авто зам//Гэсэр сүмийн урд талын замын уулзвараас зүүн тийш Төв музейн урд талын замын уулзвар хүртэл/	Туурайн жим ХХК	66.9
64	Залуучуудын өргөн чөлөөний авто зам/Сансрын туннэлээс зүүн тийш Их тойруу гудамж хүртэл/		
65	Содномын гудамжны авто зам/МУИС-ийн эдийн засгийн дээд сургууль, Дашчойлон хийдийн хооронд байрлах Бага тойруу, Их тойрууг холбосон гудамж/		
66	Жоби төвийн хойд талын авто зам		
67	Лааганы гудамжны авто зам/Тусгаар тогтнолын талбайн зүүн хойд талаас дээш Их тойруутай нийлэх гудамж/	Мэжистрал ХХК	56.5
68	Баруун Сэлбийн гудамжны авто зам/Энхтайвны өргөн чөлөөнөөс Улсын их дэлгүүрийн зүүн талаар хойш Хувьсгалчдын өргөн чөлөө /Самбуугийн гудамж /хүртэл/		
69	Нисэхийн гэр хорооллын авто зам		
70	Яармагийн гэр хорооллын авто зам		
71	Эрчим хүчний гудамжны авто зам/Ажилчны гудамж, Гурвалжингын гүүрнээс баруун тийш Сонсголонгийн зам хүртэлх гудамж/	ЗЗБ ХХК	53.7
72	Ажилчны гудамжны авто зам//Ажилчны гудамж, Гурвалжингын гүүрнээс баруун тийш Сонсголонгийн зам хүртэлх гудамж/		
73	Төмөр замын садны арын зам		
74	10-р хорооллын туслах авто зам		
75	Жасрайн гудамжны авто зам/25-р эмийн сан, Энхтайваны өргөн чөлөөнөөс доош БГД-ийн ЗДТГ-ын баруун талаар Нарны зам хүртэлх гудамж/	Эс И Зэт Эй Эм ХХК	63.8
76	Магсаржавын гудамжны авто зам/Төмөр замын буудлын хойд цэцэрлэгээс дээш Энхтайвны өргөн чөлөө хүртэл/		
77	Энэбишийн гудамжны авто зам//Баянбүрд цогцолборын дэргэдэх замын уулзвараас III, IV хорооллын Номин плаза дэлгүүр хүртэлх/		
78	Ард Аюушийн гудамжны авто зам/Од кино театрын хойд талын дугуй тойргоос баруун тийш 3, 4-р хорооллын дундуур Гэмтлийн эмнэлгийн хойд талын уулзвар хүртэл/		
79	Жамсранжавын гудамжны авто зам//Баянгол дүүргийн 7, 8-р хорооны нутаг дэвсгэрийн Чингүнжавын гудамжнаас Ард Аюушийн гудамж хүртэл Гэмтлийн эмнэлгийн урд талын гудамж/	Эм Эн Ай Жэй ХХК	43.8
80	Дамдинбазарын гудамжны авто зам//Баянгол дүүргийн 18,19-р хорооны нутаг дэвсгэрийн Амарсанаагийн гудамжнаас Чингүнжавын гудамж хүртэл/		



81	Чингүнжавын гудамжны авто зам//ТЗ-ын эмнэлгийн хойд талын уулзвараас хойш Ард Аюушийн өргөн чөлөө хүртэл/	Хурд роуд ХХК	42.0
82	Амарсанаагийн гудамжны авто зам/барилгын техникумын баруун талын уулзвараас хойш Ард Аюушийн өргөн чөлөө хүртэл/		
83	Хорооллын хүнсний захаас Од кино театр хүртэлх авто зам		
84	Баянгол дүүрэг Бичил хорооллын баруун талын авто зам		
85	Хувьсгалчдын гудамжны авто зам/Баянхошууны автобусны эцсийн буудлын замын уулзвараас зүүн тийш авто замын дагуу, Радио телевизийн төвийн зүүн талаар Гэсэр сүмийн урд талын замын уулзвар хүртэл/		
86	Ханын материалын авто зам	Шинэ Гэрэлт Зам ХХК	36.7
87	Сонгинохайрхан дүүргийн 4.5 дугаар хороог заагласан далан дээгүүр 2.5 км авто зам		
88	Нарангийн энгэрийн хогийн цэгийн авто зам		
89	Найрамдал Зуслан чиглэлийн авто зам		
90	Өнөр хорооллын арын авто зам		
91	Нарангийн гол, Их Нарангийн авто зам	Отгон Царам Дриллинг ХХК	45.8
92	Орбитын авто зам		
93	5-н шараас Толгойт Орбитын уулзвар хүртэлх авто зам	Жинхэнэ зам ХХК	63.6
94	22-ын товчоо чиглэлийн авто зам		
95	Токиогийн гудамжны авто зам/ЭТӨЧ-өөс Чингэс зочид буудлын зүүн талаар хойд их тойруу хүртэл /	Өлзий Хутагийн Наран ХХК	56.5
96	Лувсанцэвээний гудамжны авто зам//БЗД, Энхтайваны өргөн чөлөөнөөс Кино үйлдвэрийн уулзвараар хойш Б.Доржийн гудамж хүртэл гудамжийг/		
97	Доржийн гудамжны авто зам//Мамбадацангын урд талын замын уулзвараас 15 дугаар хорооллын араар Дандар баатрын гудамж хүртэл/		
98	Шар хадны авто зам		
99	Дандарбаатарын гудамжийг Улаанхуарангийн авто замтай холбосон авто зам		
100	БЗД, 5, 22 хороо Алтан Өлгий, Монелийн задгай Моносын хэсгийн 2 км авто зам		
101	Нарны зам /Өгөөмөр захын уулзвараас Төмөр замын вокзал хүртэл/		
102	Цагдаагийн академиас хойш Шархадны зам хүртэлх 1.5 км авто зам		
103	Амгалангийн авто зам / Ботаникийн эцсийн буудлаас Улиастай салдаг уулзвар /		
104	Амгалангийн замаас Ботаникийн цэцэрлэгийн зүүн талаар Жанжин клуб хүртэлх авто зам	Трүй рөүд ХХК	61.6
105	Баянзүрхийн товчоо чиглэлийн зам		
106	Улиастайн авто зам		
107	Цагдаагийн гудамжны авто зам/Чулуун овооны замын постоос төв зам дагуу тройлебусны эцсийн буудал хүртэл/	Цагаан зам ХХК	48.0
108	Цагаан байр Дэнжийн 1000-н холбосон далан дагасан авто зам		
109	Дэнжийн 1000 авто зам		
110	Хүчит шонхор захаас Хувьсгалчдын гудамжны уулзвар хүртэлх авто зам		
111	Дэнжийн 1000-н Чингэлтэйн өргөн чөлөөг холбосон авто зам		
112	Чингэлтэй Хайлаастыг холбосон авто зам	Би Ти Өү ХХК	77.6
113	Дарь эх Тоосгон заводын зам		
114	Яргайт, Гоодой, Баянбулаг, Жигжид, Санзай, Хандгайтын хүүхдийн зуслангийн авто зам		
115	Бэлх чиглэлийн авто зам	Төгс Үржих Зам ХХК	83.9
116	Дарь эхийн авто зам		
117	Шадивлан чиглэлийн авто зам		
118	Дэнжийн 1000-н авто зам	Женерал роуд ХХК	70.0
119	Дарь эхийн авто зам		
120	Шадивлан чиглэлийн авто зам		
121	Шар хадны авто зам	Танкштелле ХХК	42.0
122	Нарны зам /Өгөөмөр захын уулзвараас Төмөр замын вокзал хүртэл/	Оч Наран ХХК	52.5
123	Үйлдвэрчний эвлэлийн гудамжны авто зам	Экспресс зам ХХК	51.7
124	5-н шараас Толгойт Орбитын уулзвар хүртэлх авто зам		
125	Хувьсгалчдын гудамжны авто зам		
126	Хүчит шонхор захаас Хувьсгалчдын гудамжны уулзвар хүртэлх авто зам	Өвгөдийн жим ХХК	56.0
127	Эрчим хүчний гудамжны авто зам		
128	Ажилчдын гудамжны авто зам		
129	Самбуугийн гудамжны авто зам	Жи Жэй Си ХХК	69.6
130	Бага тойруугийн авто зам		
131	Залуучуудын өргөн чөлөөний авто зам	Грэйт роуд ХХК	61.8
132	Денверийн гудамжны авто зам/Их тойруугаас доош Сэлбэ голын баруун эрэг дагуу явж Бээжингийн гудамж хүртэлх/		
133	Эрхүүгийн гудамжны авто зам		



134	Токиогийн гудамжны авто зам /Энхтайвны өргөн чөлөөнөөс Чингис зочид буудлын зүүн талаар дээш Их тойруу хүртэл/		
135	Авто замчдын гудамжны авто зам		
136	Үндсэн хуулийн гудамжны авто зам /МУСТО-ны зүүн талаар урагш Нарны зам хүртэлх гудамж/		
137	Багц-1. Их тойруу/Баруун 4 замаас-Сансрын аюулгүйн тойрог/-ийн авто зам, Олимпын гудамжны авто зам, Энгельсийн гудамжны авто зам, Чингисийн өргөн чөлөө/Төв шуудангийн уулзвар-Яармагийн гүүр/-ний авто замын заадас засвар	Нийтийн үйлчилгээний "Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ	98.0
138	БЗД, 06 дугаар хороо, Бөхийн өргөөний зүүн талаар явсан авто замыг Дамдинсүрэнгийн гудамжтай холбох 20 м авто зам	НҮҮБН ОНӨААТҮГ	16.8
139	БЗД, Нарантуул ОУХТөвийн хойд хаалганаас Халдвартын эмнэлгийн автобусны эцсийн буудал хүртэлх 0.3 км дайрган хучилттай авто зам	НҮҮБН ОНӨААТҮГ	8.7
140	Жамъян гүний гудамжны авто замыг UB Mart-н зүүн талаар Гэндэнгийн гудамжтай холбох авто замын засвар	НҮҮБН ОНӨААТҮГ	18.0
141	Хөх тэнгэрийн гудамжны авто замын зорчих хэсгийг засварлах ажил	Наранбулагхан ХХК	298.5
142	СХД, Баруун салааны уулзварт 80 м авто зам	Танкштелле ХХК	43.9
143	ХУД, Нисэхийн гэр хорооллын 250 м авто замын хучилтыг хүчитгэх	Оч Наран ХХК	100.0
144	Гол гудамж замуудын орц, гарцын засварын ажил	НҮҮБН ОНӨААТҮГ	250.0
145	Туслах гудамж замуудын орц, гарц, зогсоол засварлах ажил	НҮҮБН ОНӨААТҮГ	50.0
146	Олимпын гудамжны зогсоолыг засварлах ажил	Хайдро проект ХХК	38.4
147	Авто замын хашлаганы засвар, арчлалтын ажил /гүйцэтгэлээр/	НҮҮБН ОНӨААТҮГ	50.0
148	СБД, 2 дугаар хороо, 29 байр орчмын авто замын засварын ажил	Төгс зам ХХК	100.0
149	Сангийн яам орчмын авто замын засварын ажил	Нарны үүсгэл ХХК	50.0
150	Хотын гаднах авто замуудын өвлийн цас, мөсний цэвэрлэгээний ажил	НҮҮБН ОНӨААТҮГ	70.0
151	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд намрын улиралд хийх урсгал засварын ажил	НҮҮБН ОНӨААТҮГ	233.0
152	Авто зам, явган замын зорчих хэсэг дээр байрласан шугам сүлжээний худгийн түвшин тааруулах	Дүүрэн трейд ХХК	60.0
Нийт дүн			5,794.2



**Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах
иргэн, хуулийн этгээдийн нэрс**

д/д	Шалгуулах төсөл, арга хэмжээний нэр	Оролцогч хуулийн этгээдийн нэр	дүн
			/сая.төг/
1	ХБ-ны эх үүсвэрээр арилжааны банкаар дамжуулан олгосон зээл	ХХБ, Голомт, УБ, ХААН, Төрийн банкаар дамжуулан зээл авсан 17 аж ахуйн нэгж	233,425.4
2	Нийслэлийн төсвөөс шууд гэрээ байгуулан зарцуулсан хөрөнгө	"АСЕМ"-ын ажлын хүрээнд автозам, хот тохижилт, засвар үйлчилгээ, бүтээн байгуулалтын тоног төхөөрөмж	33,634.2
3	БНСУ-ын Экспорт-импорт банкнаас авсан 43 автобусны зээл	Сангийн яам	5.5 сая ам доллар ⁴³ буюу 11,265.2
4	Тусламжаар ирсэн тоног төхөөрөмж, түүний түрээс	"Нью терравокс" ХХК	5,852.3
5	Гадаад томилолт	ГХС асан Л.Пүрэвсүрэн болон Г.Учралт, Г.Амартүвшин	33.1
6	Хандив тусламжийн хөрөнгө	БНСУ-ын "Койка" олон улсын байгууллагын хандив	2,311.5
7	"Тэнгэрийн өрх" хөшөө байгуулсан талаар	"ОУ-ын Уран бүтээлчдийн Монголын холбоо" ТББ "Шандаст хонгор" ХХК иргэн Бат Эрдэнэ	667,0
8	"АСЕМ"-тай холбоотой шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээнүүд	УБЦТС ТӨХК	3,702.1
НИЙТ ДҮН			290,890.9

⁴³ 2016.03.21-ны Монголбанкны ханш 2048.21